

АЧАРЬЯ-ВАЙШНАВУУДЫН ДУУНУУД

Радха ба Кришнаг магтан дуулсан

дууллауд, мантранууд

Өмнөх үг

Олон улсын Кришнагийн ухамсрын нийгэмлэг нь 1966 онд Нью-Йорк хотноо үндэслэгдэн байгуулагдсан билээ. 1965 оны есдүгээр сард Нэгдсэн Улсад ирэх үедээ би цор ганцаар байсан бөгөөд эцэст нь арай гэж би 1966 онд хуучин мухлаг байсан нэгэн байшинг түрээслэсэн хийгээд мөн Хоёрдугаар өргөн чөлөөний 26 номерын байрыг хөлслөх хүртэл багагүй бэрхшэл саадыг туулсан юм. ИСККОН албан ёсоор бүртгэгдсэний дараагаар Чак Барнетт нэрт залуу болон түүний хамт өөр хэд хэдэн хүн ирж нэгдсэн бөгөөд тэд бүгд ирээдүйн хөдөлгөөний маань цөмийг бүрдүүлсэн билээ. ИСККОН дөнгөж мэндэлж ахуй тэр үед би өдөр бүр Нью-Йоркийн Томпкинс-Сквер паркад очиж нэгэн модны дор суун Харе Кришна *маха-мантра*г дуулдаг байв. Шриман Барнетт, Брюс нэрт өөр нэг залуу нар миний өмнө бүжиглэж эхэлсэн анхны хүмүүс байлаа. Дараахан нь тэдэн дээр үзэгчдээс хэд хэдэн хүн нэмэгдсэн юм. “Нью-Йорк Таймс” сонин нэгэн дугаартаа Томпкинс-Сквер паркад болж байсан энэхүү дууллын тухай өгүүлсэн жижигхэн тэмдэглэл болон мөн бидний зургийг тавьсан байв. Тэмдэглэлийн гарчиг нь, залуусыг Харе Кришна хөдөлгөөнд намайг уриалан оруулж байна хэмээсэн утгатай байлаа. Хэсэг хугацаа өнгөрсний дараагаар Чак, Брюс болон өөр бусад хэдэн залуус миний шавь болсон ба 1970 онд Чак, Брюс нар маань Ачьютананда Свами, Брахмананда Свами нэрүүдийг авч *санныасын* сахил хүртсэн юм. Одоо харин Брахмананда Африкт, Ачьютананда Энэтхэгт номлол үйлдэж явна.

1967 онд би өвдөж, Нэгдсэн Улсаас Энэтхэгт буцан ирсэн юм. Надаас хагацан салахыг тэвчиж үл чадахын эрхээр Шриман Ачьютананда Вриндаванд над дээр хүрэлцэн ирлээ. Тэр цаг үеэс Ачьютананда Свами Энэтхэгт амьдрах болсон бөгөөд энэ бүх цаг мөчид тэрээр нөр ихээр ажиллаж хөдөлмөрлөсөн юм: тэрээр Калькутта болон Бенгалийн бусад хотуудаар өргөн цар хүрээтэй номлол үйлдэж, бенгали хэл дээр дуулахад суралцаж, *мриданг* хөгжим дээр ном ёсоор нь тоглоход суралцсан билээ. Өнөөдөр тэрээр англи хэл дээр тайлбартай бенгали дуунуудын цуглуулгыг эмхлэн бүрдүүлжээ.

Бхактивинода Тхакур, Нароттама дас болон бусад Гаудия-вайшнавчуудын *сампарадаид* хамаарах аугаа аугаа *ачарьягуудын* бичсэн дуунуудын эмхэтгэл мэндэлж буйд би ихэд баярлаж байна. *Ачарья* нарын дуунууд нь жирийн нэг дуунууд биш юм. Хэрэв тэдгээрийг вайшнавын дүрэм журам, заагдсан зааврыг даган баримтлагч цэвэр ариун вайшнавчууд дуулвал тэдгээр нь сонсогчдод амьд бодгаль болгонд зүүрмэглэн байх Кришнагийн ухамсрыг сэргээж чадна. Ийм учраас би вайшнавын аль болох олон дууг дуулж, тэдгээрээр цуглуулга хийж миний шавь нар хийгээд Барууны бусад иргэд энэ дуунуудыг дуулж тийн өөрсөддөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлээсэй хэмээн Шриман Ачьютананда Сваמיד зөвлөдөг билээ.

Би, өөртөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлэх гэсэн Ачьютананда Свамигийн чин үнэн эрмэлзлийнх нь төлөө түүнийг адислан ерөөж байна. Цаашдаа тэрээр энэ

зам мөрөөрөө амжилттай урагшилж, *майагийн* бүхий л зангыг амжилттайгаар даван туулна хэмээн найдна. Бид майагийн аюултай нөлөөллийг үргэлж санаж байх ёстойгийн хамт түүний асар хүчтэй илбэ шидээс холхон байхыг эрмэлзэх хэрэгтэй. Хэрэв бид түүний нөлөөллөөс зайлсхийхийг хүсвэл *киртана-расагийн* трансцендент рашаанд умбах ёстой. Учир нь *киртана-раса* материаллаг ертөнц дэхь хамгийн аюулгүй байр суурь юм. Харе Кришна.

А.Ч.Бхактиведанта Свами

Оршил

1971 онд Бурхан Чайтаньягийн төрсөн газар болох Шри Майапурт, Шрила Прабхупадад үйлчлэх аз тохиолоо: би тэнд манай нийгэмлэгийн олон улсын төвийг үндэслэн байгуулахад оролцсон юм. Тэр жил Майапурт аймшигтай үер болсон бөгөөд үерийн ус олон өдрийн туршид нэмэн нэмсээр байсан боловч тэрээр манай нийгэмлэгийн харъяанд орших газрыг усанд автуулаагүй юм. Үер манай Парама Гуру Махараж, Шрила Бхактисиддханта Сарасватийн тавьсан далан болон тогтсон зам буюу хашлагын тусламжтайгаар биднийг тойрон гарсан байв. Энэ тухай би Бурханы Адислалт Багш танаа бичсэн захидалдаа дурдсан юм: “Ус манай эзэмшлийг үерт автуулаагүй бөгөөд Шрила Бхактисиддхантын зам биднийг аварлаа” хэмээн бичив. Шрила Прабхупада хариундаа миний үгэнд огт өөр утга санаа бүхий хариуг ирүүлсэн байлаа: “Тиймээ, Шрила Бхактисиддхантын зам биднийг үргэлж авран хамгаална. Ийм учраас багш шавийн хэлхээнд хамаарах номын багш нарыг үргэлж алдаршуулагтун. Чингэснээр чиний амьдрал амжилт, аз хиймориор дүүрэх болно”. Хожим хойно, би Шрила Бхактивинода Тхакур болон Нароттама даса Тхакурын дуунуудыг англи хэл дээр орчуулах хүсэлтэй байгаагаа хэлтэл Бурханы Адислалт Багш маань: “Тиймээ, бид Бхактивинодын үүрэг даалгаврыг үргэлжлүүлэх ёстой” хэмээсэн юм. Тиймээс ч энэ ном маань Шри Чайтанья Махапрабхугаас эхлэлтэй багш шавийн хэлхээнд хамаарах ачарья нарын бүтээлүүдийн орчуулгын анхны бүрэн эмхэтгэл бөгөөд би үүндээ мөн Тхакур Бхактивинодын товч намтрыг орууллаа. Энэхүү цувралын маань дараагийн номуудад Шрила Нароттама даса Тхакур, Шриниваса Ачарья болон бусад *ачарья* нарын намтруудыг багтаах болно.

Энэхүү эмхэтгэлийн маань дуунуудын ихэнхийг Бхактивинода Тхакур болон Нароттама даса Тхакур нар бичсэн бөгөөд англи хэл рүү хөрвүүлэхэд тэд заримдаа тийм ч их яруу эгшиглэнтэй бус сонсогдох хэдий ч бүх орчуулга эх хувийнхаа утга санааг гажуудуулалгүйгээр дамжуулж байгаа юм. Эдгээр дуунуудын ая нь маш гайхамшигтай хийгээд номын хамт тэдгээрийн бичлэг бүхий кассетыг олж авч болно. Энэ бүх дуунууд болон шүлгүүд цэвэр чин бишрэлээр зүтгэх үйлийн мөн чанарыг нээн өгөх ба тэдгээрт өгүүлэхдээ Шри Кришнад чин бишрэлээр үйлчлэх нь зөвхөн номын багшийн өршөөлөөр олгогддог бөгөөд түүний хүслийг төгс биелүүлснээр энэхүү өршөөд адислалыг олж авч болох тухай өгүүлдэг.

Эдгээр дуунууд нь Кали эриний үндсэн, хамгийн аугаа адислал болох Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама, Харе Рама, Рама

Рама, Харе Харе *мантраг* хамтаар дуулах үйлийг орлож чадахгүй гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү *мантраны* ач холбогдлыг үнэлж цэгнэх боломжгүй. Энэ номонд орсон дуунууд нь *маха-мантрагаас* үүсэн гарсан бөгөөд түүнийг тайлбарладаг. Тийнхүү тэдгээр нь *маха-мантрагийн* бүтээгдэхүүнүүд болох ба иймээс ч ямар нэг байдлаар түүнээс ялгаа үгүй юм.

Шрила Нароттама даса ба Бхактивинодын дуунууд нь ведийн мантрагаас ялгаа үгүй. Гэсэн хэдий ч Шрила Прабхупадагийн “Чин бишрэлийн рашаанд” тэмдэглэснээр, хүн бүр Гаятри мантра унших сахил аваагүй байсан ч зүгээр л Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе-г давтан уншсанаар бурханлаг амьдралын дээд төгс төгөлдөрт хүрч болно гэжээ.

Эдгээр дуунууд нь Кришнагийн ухамсрыг номлогчдын мэдлэгийн шавхагдашгүй эх үүсвэр болдог. Эдгээр дуунуудын нэг мөр нь л олон цагийн номлолын сэдэв болж чадна. Учир нь тэдгээрийн үг бүр нь гүн гүнзгий гүн ухааны утга агуулгатай билээ. Номлогч нь “Бхажаху ре мана”, “Шри Рупа Манжари пада”, “Охе Вайшнава Тхакура” эсвэл “Шри Манах-шикша” зэрэг дуунуудын энгийн шүлэг, мөрийг дурсан санах нь л хангалтай бөгөөд энэ нь бүгдэд бурханлаг гүн ухааны дурын сэдвийг дэлгэрэнгүйгээр нээн таниулж чаддаг тул Кришнагийн ухамсрын гүн ухаанлаг үнэн нь тэдгээрт ийм л яруу цэцэн, гүн гүнзгийгээр шигтгэгдсэн байдаг. Шрила Прабхупада эдгээр дуунуудыг өөрийн ном болон лекцэнд байнгад иш татдаг бөгөөд энэ эмхэтгэлд тэдгээрийн зарим нэгэнд хийсэн тайлбар багтаж буй.

Шрила Прабхупадагийн өөрийнх нь орчуулсан дуунуудыг зөвхөн түүний орчуулга байдлаар нь тавьсан ба учир нь түүний орчуулгуудыг цааш нь тайлбарлах шаардлагагагүй байдаг. Англи хэл дээр энэхүү трансцендент шүлгүүдийг анх удаа хөрвүүлж буй бөгөөд оршил болгож би энд Шрила Бхактивинода Тхакурын товч намтрыг оруулахаар шийдсэн юм.

Бхактивинода Тхакурын амьдралын

тухай найруулал

Бхактивинода Тхакурын бүхий л амьдрал Бурханы Дээд Бодгаль Шри Кришнад үйлчлэн зүтгэхэд чиглэгдсэн байлаа. Дэлхий нийтэд түүний үйл нь ямархан сайн сайхныг авчирсныг Шри Чайтаньягийн аугаа үйл, зургаан Госвамийн үйлтэй адилтган ойлгож болно. Түүний бурханлаг үйл хийгээд бурханлаг судар номууд нь оюун ухаант, боловсрол бүхий хүмүүст томоохон нөлөө үзүүлсэн бөгөөд Бурхан Чайтаньягийн номлол хийгээд эгэлгүй сургаалд нь итгэх итгэлийг бий болгосон юм.

Зуун жилийн цаадтай эргэн өнгийж харахуйд бид Чайтанья Махапрабхугийн цэвэр ариун, гүн гүнзгий, аугаа бурханлаг гүн ухаанаас эхлэлтэй вайшnavын шашин тэр үед ямаршуу уналтын байдалд орсон байсныг гайхан харах болно. Тэр ч атугай өргөн дэлгэр мэдлэг бүхий эрдэмт *пандитууд* Бурхан Чайтаньягийн сургаал болсон аугаа гүн ухааныг бүрэн гүйцэд танин ойлгож чадахгүй байв. Боловсрол мэдлэг муухан хүмүүсийн мунхагийн харанхуйгаас үүдэлтэй үл итгэх үзлийн улмаас вайшnavын шашин уналтанд орсон байсан бөгөөд нийтийн мөнгөн дээр амьдардаг гуйлгачдын халхавч мэтээр тооцогддог байлаа. Гэвч Бурханыг хайрлах хайрандаа хөтлөгдсөн Бхактивинода Тхакур Вед, Упанишад, Пуран, “Бхагаватам”-ын хуудаснаа далдлагдсан гүн гүнзгий гүн ухааныг дэлгэрэнгүй тайлбарлан өгүүлсэн юм. Үндсэн зорилго нь Бурханд үйлчлэхэд орших түүний үйлийн ачаар мөн түүний энгийн хийгээд өргөн олон уншигчдад ойлгогдохоор бичигдсэн түүний номууд энэхүү гүн ухааныг дэлхий нийтэд нээн таниулав. Чухамхүү түүний зохиолууд, зүйрлэшгүй бурханлаг чанарынхаа ачаар нийгэмд өндөр боловсрол бүхий бүхэл бүтэн давхаргыг бий болгосон ба тэдгээр хүмүүс нь Шри Чайтаньягийн сургаал дээр суурилсан цэвэр, дэвшилтэт Кришнагийн гүн ухааны бурханлаг мэдлэгийг олж авснаараа болон өөрсдийн вайшnavын итгэл үнэмшлээрээ толгой дээгүүр, бардамхан явах болсон юм.

Тхакур Бхактивинода нь чинээлэг гэр бүлд төрсөн(тэрээр 1838 оны есдүгээр сарын 2-нд төрсөн ба түүнийг төрөхөд нь Кедаранатха Датта гэж нэрлэжээ) боловч түүний балчир нас бэрхшээл саадаар дүүрэн байв. Тэрээр хүүхэд ахуй насаа өөрийн нагацынд Бирнагарт(Улаграм)-д өнгөрөөсөн бөгөөд тэндээс арвангурван насандаа эцгийгээ нас нөгчисний дараагаар Калькуттад нүүн ирж сургуулиа дүүргэсэн юм. Удалгүй их сургуулиа төгссөний дараахан түүнд авга ах нь үхлийн ирмэг дээр байгаа тухай мэдээ ирэв. Авга ах Ражаваллабха Датта нь Калькуттад тун нэртэй нэгэн агаад өөрийн амьдралынхаа сүүлчийн өдөр хоногуудыг Орисст аглаг буйд газарт даяанч байдлаар өнгөрөөсөн ажээ. Тэрээр ирээдүйг зөгнөн хэлдэг байсны дээр өөрийн үхэх өдрийг тов тодорхой мэддэг байжээ. Учир нь тэрээр дээд төрөлт амьд бодгалиудтай холбоо тогтоох чадварыг эзэмшсэн байв. Өөрийн авгын нас нөгчих тэр чухал цаг мөчид Тхакур Бхактивинода түүнтэй хамт байж түүнээс сургаал зааврыг нь сонссон ба энэхүү аугаа сүнснийг халин одсоны дараа тэрээр Орисс мужийн бүхий л гол гол сүм, ашрамуудаар зочлон очжээ.

Бхактивинода Тхакурын цаашдын үйл гэгээрүүлэх үйлтэй холбоотой байлаа. Тэрээр Орисст англи хэл зах болсон ба энэхүү мужийн бүхий л ашрамын талаар өгүүлсэн жижгэвтэр ном бичжээ. Тэр номондоо тэрээр өөрийн өвөг дээдэст хамаарах газар шороон дээр оршин буй тухайгаа дурьджээ. “Орисс мужийн Чхотимангалпур тосгон надад харьяалагддаг. Энэ тосгонд миний өвөг дээдсийн ариун гэгээн хүмүүст хэсэгхэн газартай нь хамтад нь бэлэглэсэн нэгэн сүм байдаг. Энэ сүмийн хамба лам нь хэрмэл мөргөлчидөд түнэр харанхуй шөнө хоноглох ор дэр гаргаж өгөхөө больсон ажээ. Энэ тухай дуулж мэдээд би хэрэв дахин нэг удаа л зочноо таагүй байдлаар хүлээж авсан тухай гомдол санал дуулдвал газрыг нь хураан авна хэмээн сүрдүүлсэн юм”. Хожим Бхактивинода Тхакур төрийн албанд зүтгэх болж Бенгалид нүүн ирэв. Тэнд тэрээр нэгэн хотод “Шримад Бхагаватам”-ын гүн ухааны тухай түүхэн хүүрнэлээ өгүүлсэн байдаг. Энэ яриа нь мянга мянган

хүний анхаарлыг соронздон татжээ. Тэр яриандаа тэрээр “Бхагаватам”-ын хаалттай хуудсан дахь хосгүй үнэт эрдэнийн тухай өгүүлээд энэ бүтээлийг гүн ухаанч сэтгэлгээтэй хүн бүр унших ёстой гэсэн байдаг. Хэдэн жилийн дараагаар тэрээр Чампаран хотод нүүн ирэв. Тэр хотод олон мянган унан доройтсон хүмүүсийн мөргөл үйлддэг *брахма-дайтья*(буг шидлийн нэгэн төрөл)орогносон аварга том баньян мод оршдог ажээ. Нэгэн удаа Бхактивинода Тхакур дээр эрдэм мэдлэгээрээ нэрд гарсан нэгэн бүсгүйн эцэг хүрэлцэн ирэв. Тэрээр өргөл хандив цуглуулан явж байсан бөгөөд Бхактивинода тэр даруй түүнийг мөнөөх хий үзэгдэл орогнодог модны доор “Бхагаватам”-ыг уншуулахаар суулгажээ. Сарын дараагаар, “Бхагаватам”-ыг уншиж дууссан өдөр тэр мод чимээ шуугиантайгаар газарт булгаран унасан бөгөөд хий үзэгдэл ч мөнхөд тэр газрыг орхин оджээ. Хий үзэгдэлд мөргөдөг ариун бус зарим нэг хүмүүсээс бусад хотын бүх иргэд тэднийг дайтывгаас ангижруулж өгсөнд нь Бхактивинодад тун ихээр баярлан талархав.

Бхактивинодын нүүн очсон дараагийн хот бол Пури байлаа. Тэрхүү районы удирдлага мэдэлд нь байдаг комиссар, Бхактивинодаг Пурид ажиллах болсныг мэдээд ихэд баярлаж засаг төрийн төлөөлөл байдлаар Жаганнатхын сүмийн хэв журмыг сахиж байхыг хүсэв. Бхактивинодын зүтгэл чармайлтаар сүмд байсан олон тооны хууль бус үйл ажиллагаа төгсгөл болж Бурхан Шүтээндээ хоол хүнс өргөх цаг хугацаа хатуу тогтсон байна. Дараахантай нь Тхакур Бхактивинода засгийн эсрэг боссон бослогыг дарах үүрэг хүлээсэн бөгөөд тэр бослогыг өөрийгөө Маха-Вишнугийн хувилгаан хэмээн өргөмжилсөн Бишикишена нэрт этгээд өдөөсөн байв. Тхакур Бхактивинодын мөрдөн шалгах явцад энэ хүн нь жирийн нэг хууран мэхлэгч, гэмт хэрэгтэн болох нь тодорхой болсон ба түүнд засаг төрийн тогтоол шийдвэрийг зөрчсөн хэмээн ял тулган буруушаажээ. Шүүх Бишикишенаг хагас жил эрх чөлөөг нь хассан бөгөөд тэрээр шүүх хурлын дараагаар удалгүй шоронд нас нөгчжээ. Тэр хүн үнэхээр эгэл жирийн бус хүч чадалтай нэгэн байсан хэдий ч түүнийгээ харин бурханлаг бус аргаар хөгжүүлсэн байсан хийгээд ийм ч учраас Тхакурын мэдэлд захирагдах хэрэгтэй болсон байна. Бишикишена жирийн хүмүүсийг айлган сүрдүүлдэг байсан тул тэд Шрила Бхактивинодыг шударга шүүхийн нэрийн өмнөөс ч түүнийг хариуцлагад татахгүй байхыг гуйн хүсч байлаа. Учир нь *йогч* өөрийн ид шидийн хүчийг хэрэглэхвий тэр нь ноцтой үр дагаварт хүргэх вий хэмээн айн болгоомжилсноос үүдэлтэй байв. Гэвч хэзээ ч юуг ч хуурмагаар үйлдэж байгаагүй, хэнд ч өөрийн жинхэнэ чанар, бурханлаг хүч чадлаа нээн харуулж байгаагүй Тхакур, чөтгөрийн хүчийг эзэмшсэн өөрийгөө зарлан тунхаглагчийг хялбараар ялан дийлсэн юм. Бишикишена төгсгөл болсны дараагаар хөрш зэргэлдээ тосгонд Баларама хэмээн өөрийгөө нэрийдэгч нэгэн этгээд гарч ирэв. Энэ этгээдтэй болон өөр бас бус өөрийгөө Бурханы хувилгаан хэмээн нэрлэгчидтэй Бхактивинода Тхакур тулгарч байсан ч Бишикишены адилаар тэдний санаа зорилго нуран унасаар байсан юм.

Жаганнатха-Пурид Тхакур Бхактивинода утга зохиолын үйл болон бурханлаг зохиол бүтээлийг хэлэлцэхэд багагүй цаг хугацааг зориулав. Тэрээр Баладева Видьябхушаны тайлбартайгаар хэвлэгдэн гарсан “Веданта сутрын” тайлбарыг бэлтгэв. Мөн түүнчлэн Нароттама дас Тхакурын гайхамшигт бүтээлүүдтэй эн зэрэгцэх мөнхийн бүтээл “Кальяна калпатару”-г (түүний хэсгээс “Вибхавари

Шеша” нэртэйгээр энэ номонд оруулсан)бүтээв. 1877 онд Тхакур Бхактивинода өөр хот руу нүүн шилжиж 1881 онд “Сажжана-тошани”(Цэвэр чин бишрэлтэнгүүдийн баяр баясгалан) сэтгүүлийг хэвлэн гаргаж эхлэв. Тэр сэтгүүл нь бурханлаг амьдралын асуудлуудад чиглэгдсэн хийгээд хожмоо тун ч их нэр хүндийг олсон юм. Мөн тэрээр Кришнагийн бурханлаг ахуйг нээн таниулсан гүн ухааныг илтгэсэн “Шри Кришна-самхита”-г хэвлэн гаргасан ба боловсрол мэдлэг бүхий хүмүүст тэдний Бурхантай холбоотой жинхэнэ харьцааг нээн харуулсан юм. Энэ бүтээлийг олон олон немец эрдэмтэд баяр хөөртэйгөөр хүлээн авсан бөгөөд учир нь Кришнаг жирийн нэг баатар эр-дурлагч хэмээн тооцдог өргөн олон уншигчдын санаагаар бол яруу найрагчийн төсөөллийн үр дүн хэмээн тооцож байсан ба харин Шрила Бхактивинода Ведийн нотолгоон дээр үндэслэн Кришна бол Парабрахман, Дээд Трансцендент Бодгаль, Туйлын Үнэн гэдгийг үзүүлсэн юм.

Нараил тосгонд байх сүүлчийн өдрүүддээ Бхактивинода Вриндаванд хүрэлцэн очсон бөгөөд тэнд тэрээр Канжхарам гэж нэрлэгдэх бүлэг дээрэмчидтэй тулгарчээ. Энэхүү хүчирхэг дээрэмчид нь ариун мөргөлийн газарт хүргэдэг зам дагуу бүгэн нуугдаж хөөрхий мөргөлчидийг тонон дээрэмдэг байв. Бхактивинода Тхакур энэ тухай төр засагт мэдээлж олон сарын тулалдааны дараагаар дээрэмчдийг Вриндаванаас эгнэгт хөөж чадсан юм. Энэ цаг үеэс эхлэн Тхакур Бхактивинода олон тооны хүн цугласан цуглаан дээр Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе хэмээх ариун нэрийг дуулах *санкиртан* хөдөлгөөн дээр үндэслэсэн сургаалыг дэлгэрэнгүй тайлбарлаж идэвхитэйгээр номлол үйлдэж эхлэв.

Удалгүйгээр Тхакур Бхактивинодын нүүн очсон Барасатад тэрээр бенгалийн нэртэй зохиолч Банкимчандратай учирчээ. Энэхүү уулзалтаас өмнөхөн энэ роман хийгээд жүжгийн зохиол бичигч нь Кришнагийн тухай номоо дөнгөж дуусгаад байв. Шрила Бхактивинода Кришнагийн тухай сэдвээр нэр хүндтэй мэдлэг бүхий нэгэн гэдгийг мэдсэн тэрээр өөрийн гар бичмэлийг уншиж үзэхийг хүсэв. Анхдагч байдлаараа тэр ном барууны гүн ухааны хэв загварын үнэр ханхалсан элдэв бодол төсөөлөл, олон янзын материаллаг эргэцүүллээр дүүрэн байлаа. Гэвч дөрвөн өдрийн яриа хөөрөөний дараагаар Бхактивинода Банкимчандрыг өөрийн бүтээлээ бүрнээ эргэн харах хийгээд түүнийг Бурхан Чайтаньягийн цэвэр, энэ газар дэлхийн бус сургаалтай тохируулан өөрчлөхийг итгүүлж дөнгөв. Бхактивинодын Барасатад байх сүүлчийн жил дээд шүүхийн нэртэй нэгэн шүүгч түүнийг Шри Вишванатха Чакраварти Тхакурын тайлбартай түүний өөрийнх нь (Бхактивинодын) орчуулгатайгаар “Шримад Бхагавад гита”-гийн нэр хүндтэй бүтээлийг хэвлэн гаргах бэлтгэл базаахыг хүсэв. Бүтээлийн өмнөх үгийг Банкимчандар бичсэн бөгөөд тэрээр түүний хөдөлмөр бүтээлийнх нь төлөө Бхактивинодад өөрийн хүндэтгэлээ илэрхийлсэн байв. Ном маш хурднаар борлогдож дууссан ба энэ бүхний дараагаар удалгүйгээр Бхактивинода Тхакур “Шри Чайтанья-шикшамрита”(“Бурхан Чайтаньягийн рашаан мэт сургаал”) нэртэй өөр нэгэн гайхамшигт бүтээлээ хэвлүүллээ. Энэ номондоо Бурхан Чайтаньягийн теист гүн ухаан ба барууны цэцэрхийлэн мэтгэлцэгч сэтгэгчдийн ном номлолын тухай өгүүлсэн байв. Энэ номондоо Шрила Бхактивинода алхам алхмаар бусад төрлийн

гүн ухааныг бут цохисоор Бурхан Чайтаньягийн гүн ухааны давуу байдлыг батлан нотлосон юм.

1885 онд Бхактивинода Тхакур “Шри Вишва-вайшнава-ража-сабха” нийгэмлэгийг үндэслэсэн бөгөөд түүний зорилго нь цэвэр *хари-бхактиг* номлоход оршиж байлаа. Энэхүү нийгэмлэгт Калькуттын нэр цуутай олон оршин суугч элсэн орсон ба түүний олон талт үүрэг зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хэд хэдэн хороог байгуулжээ.

Бхактивинода Тхакур Бурхан Чайтаньягийн тоглоом наадам болж өнгөрсөн тэр газар нутгийг үзэхийг маш ихээр хүсэж байсан хийгээд нэг бус удаа түүнийг Навадвипын (Майапур)ойролцоо орших дурын ямар нэг хотод илгээж өгөөч гэсэн хүсэлтийг тавьж байв. Шилжин суурьших ажилдаа амжилт олж чадаагүй тэрээр ажлаасаа халагдах албан ёсны өргөдлөө өгсөн авч татгалзсан хариуг авчээ. Гэвч удалгүй түүнийг маш ихээр баярлуулсан мэдээг авав. Тэрээр Навадвипаас гучин таван километрийн зайд орших Кришнанагарт ажиллах шийдвэрийг хүлээн авчээ. Навадвипаас нэг их холгүй газарт суурьшин тэрээр тэнд өөрийн бүхий л зав чөлөөтэй цаг мөчөө өнгөрөөх болов. Тэрээр шууд л Бурхан Чайтанья Өөрийн тоглоом наадмаа өрнүүлж асан газар нутгийн тодорхой байршлын талаарх мэдээллийг цуглуулж эхлэсэн бөгөөд орчин үеийн Навадипа нь ердөө зуун жил л оршин буй юм гэдгийг олж тогтоон Бурханы төрсөн жинхэнэ газар нутгийг олж тогтоохоор шийдсэн байна. Орчин үеийн Навадипа нь Бурхан Чайтаньягийн төрсөн газар нутаг биш гэдэгт гүнээ итгэсэн тэрээр Түүний жинхэнэ мэндэлж төрсөн газар нутгийг олохыг чармайн нутгийн оршин суугчдаас асуун сураглаж эхлэв. Зарим нэг хүн Чайтаньягийн төрсөн газар нь хотын захад оршдог хэмээн итгүүлэхийг оролдож байсан ба эдгээр хүмүүсээс салж холдоход түүнд тийм ч амар биш байлаа. Үнэнийг олж тогтоохын тулд тэрээр оршин суугчдаас дэлгэрэнгүйгээр асуун лавлаж байсан ба үүний үр дүнд тэрээр түүний эрж буй тэр газар одоо урсгалаа өөрчлөн урсаж буй Ганга мөрөн урсдаг болохыг мэдэв. Тийм тайлбарт сэтгэл нь үл ханасан тэрээр өөрөө *йога-нитхи*(төрсөн газар) олох эрэлд гарлаа. Багагүй бэрхшээл саадыг туулан байж тэрээр өөрийгөө танин ухамсарласан олон сүнс Шри Чайтанья Махапрабхугийн жинхэнэ төрсөн газар хэмээн тооцож мөргөл үйлддэг газар нутаг оршин байдаг тухай олж мэдэв. Харин тэр газар нь тухайн үеийн мусульманы газар нутагт харъяалагдах тийм газар байлаа. Нутгийн оршин суугчдаас асууж лавлан тэдний заасныг “Шри Майапур” хэмээн нэрлэгдсэн арван наймдугаар зууны хоёрдугаар хагаст хамаарах хуучны газрын зурагтай тулган үзэж эцэст нь Бурхан Чайтаньягийн жинхэнэ төрсөн газрыг олж тогтоов. Өөрийн энэхүү нээлтийн дараа тэрээр “Навадвипа-дхама-махатмья”(Энэ номын тавдугаар бүлэг нь бенгали хэлээр ИСККОН-ы “Бэж ту Годхед” сэтгүүл дээр хэвлэгдэн гарсан) нэртэй үнэ цэнтэй бүтээлээ хэвлүүлжээ.

1895 он бол вайшнавизмын түүхэнд хамгийн мартагдашгүй он жил болсон юм. Энэ онд болж өнгөрсөн бүх үйл явдлын гол баатар нь Бхактивинода Тхакур байлаа. Чухамхүү энэ онд тэрээр өргөн олонд Бурханы жинхэнэ төрсөн газрыг олсон тухайгаа болон Түүний төрсөн газар нутгийн жинхэнэ ач холбогдлыг нээн таниулж Шри Чайтаньягийн төрсөн газрыг албан ёсоор хүлээн зөвшөөрүүлж чадсан юм.

Бурхан Чайтаньягийн төрсөн газар нутагт болж өнгөрсөн баяр ёслолд мянга мянган зочид гийчид цугласан байв.

Тхакур Бхактивинода түүний энэхүү нээлт мартагдан гээгдэхийг хүсээгүй учраас ажлаасаа огцорсон даруйдаа тэрээр сүм барихаар шийдэж машид хүлцэнгүйгээр нэг айлын хаалганаас нөгөө айлын хаалга дамжин өргөл хандив цуглуулж эхлэлээ. “Амрита базар патрика” сонин 1894 оны 12 сарын 6-ны дугаартаа “Энхтайвны шүүхийн туслах Бабу Кедаранатха Датта саяхан ажлаасаа огцорсон бөгөөд Нийгэмлэгийн хамгийн идэвхитэй гишүүдийн нэг юм. Өөрийн салбар хороог төлөөлөн тэрээр Калькутта болон бусад газар нутгуудаар хандив өргөл цуглуулж яваа бөгөөд ерөөл буянт зорилгын төлөө энэтхэг хүн бүрээс ядаж ганц ширхэг рупи хайрлахыг гуйн айлаас айл дамжин шийдвэр зориг төгс явна. Хэрэв Бабу Кедаранатха Датта гартаа хүүдий барин айл хэсэх санаа зорилгоо орхихгүй л бол өөрийгөө энэтхэг хэмээн үнэлж хүндэтгэдэг хүн бүр, энэхүү буянлаг *бхакта* өөрийн айлчлалаар хүндэтгэл үзүүлсэн айл бүр хэдий даруу жаахан ч хамаагүй өөрийн өргөл хандиваа Гаура-Вишнуприйгийн сүм барих санд гарцаагүй өргөл болгон хандивлана гэдэгт бид гүнээ итгэж байна ” хэмээсэн байв. Үнэн хэрэгтээ өмнөө тавьсан буянт зорилгодоо хөтлөгдөн Тхакур Бхактивинода маш олон айлаар орсон юм. Бурхан Чайтаньягийн үүрэг даалгаврыг биелүүлэхийг хүсэмжлэн тэрээр урьд өмнө нь хэзээ ч орж байгаагүй айлдаа ч орж байв. Бхактивинода Тхакурын чармайлт талаар болсонгүй: цуглуулсан зүйлсээрээ Бурхан Чайтаньягийн төрсөн буюу илэрсэн газарт байгууламж барьсан юм. Тэр үед Бурханы ариун нэр алдрын тухай номлол сургаал маш өргөн дэлгэр тархсан байсан бөгөөд түүний тухай мэдээлэл дэлхийн бөмбөрцгийн хамгийн алслагдсан өнцөг буланд ч хүрсэн байв. “Гауранга-смарана-мангала-стотра” Шри Чайтаньягийн сургаал хийгээд амьдралын тухай өгүүлсэн англи хэл дээрхи оршилтойгоор хэвлэгдэн гарсан нь Бурхан Чайтаньягийн төрсөн газрыг нээсний дараагаар тун ч удалгүй гарсан Бхактивинодын бүтээл бөгөөд дэлхийн хоёр тал бөмбөрцгийн бүхий л сургалтын танхим дахь номын сангийн тавиуран дээр өөрийн байр сууриа олсон билээ.

Бхактивинода Тхакур, Бурхан Чайтанья хийгээд Бурхан Кришнагийн нэр алдрыг номлох үйл хэдийчинээ идэвхитэй явагдана төдийчинээ баяр баясгаланг амсдаг байв. “Гауранга-смарана-мангала-стотра” хэвлэгдсэний дараагаар тэрээр “Шри Брахма-самхита”, “Шри Кришна-карнамрита” бүтээлүүдэд тайлбар хийсэн бөгөөд мөн түүнчлэн өөрийн үнэ цэнэтэй үхэлгүй мөнхийн бүтээл болох “Шри Хари-нама-чинтаmani”, “Бхажан-рахасья” нэртэй хоёр бүтээлээ туурвисан юм. Түүнээс гадна тэрээр вайшnavын гүн ухааныг өгүүлсэн “Шримад Бхагаватам” бүтээлийн бүх шүлэг багтсан “Шримад-бхагаватарка-маричи-мала”-г хянан засварлав. Тэрээр өөрийн утга зохиолын ажил үйлэнд амрахыг үл мэдрэн ажиллан байсан бөгөөд түүний үзэгнээс вайшnavын гүн ухааны тухай өгүүлсэн маш олон бүтээл гарсан юм. Бхактивинода Тхакур өөрийн албаны ажлаа дуусгаад үдэш орой зохиол бичих ажилдаа ордог байлаа. Шөнийн нэг, хоёр цаг хүртэл дуугаа зохиож, номоо бичдэг байв. Түүний зохиол бүтээлийн ихэнхи нь “Сажжана-тошани” сэтгүүлд хэвлэгдэн гардаг байсан юм. Утга зохиолын оволзсон ажлын хажуугаар тэрээр Бенгалийн олон олон район мужаар ариун гэгээн нэр алдрын тухай номлолыг идэвхитэйгээр

явуулдаг байсан бөгөөд түүний тосгон сууринд номлол үйлдэн очих нь хүмүүст гайхалтай нөлөөллийг үзүүлдэг байлаа. Надийн төвд ажил үйлээ явуулахын тулд тэрээр Шри Годрума-двипад Шри Свананда-сукхада-кунжа нэртэй байшин сууцыг барьжээ. Энэ газарт *хари-намын* идэвхитэй номлол одоог хүртэл үргэлжилсээр байгаа билээ.

Хорьдугаар зууны эхээр Бхактивинода Тхакур Пурид суурьшихаар шийдэж тэнд далайн эрэг дээр өөрийн байшингаа барьжээ. Олон олон үнэнч бишрэлт сүнснүүд түүний адислалыг хайн эрж эцэст нь түүнийг олж чадсан юм. 1908 онд тэрээр ертөнцийн амьдралаас огоорч Шрила Гауракишора дас Бабажигас *бабажи* сахилыг хүртжээ. Хэдий Бхактивинода Тхакур огоорлын амьдралыг сахиж байсан ч түүн рүү нийгмийн бүхий л давхарга хийгээд олон янзын цол гуншин бүхий хүмүүс тасралтгүй ирсээр байсан хийгээд тэрээр тэдэнд өөрийн бурханлаг сургаал болон адислалаа өгөөмрөөр хайрладаг байв. 1910 онд тэрээр зочид гийчдийг хүлээж авахаа больсон агаад энэ цаг мөчөөс эхлэн Бурханы мөнхийн тоглоом наадамд бүрнээ төвлөрөн төгс самадхийн төлөв байдалд орших болжээ. 1914 онд Шри Гададхарын халин одсон өдөр Бхактивинода Тхакур энэ ертөнцийг орхисон бөгөөд бүрнээ цэнгэл жаргалаар дүүрэн Голокийн орноо одсон юм. 1871 оны орчимд Шрила Бхактивинода Харидас Тхакурын самадхид зориулсан дөрвөн мөрт бичиж байжээ. Түүнд өгүлснээр вайшнав нь энэ ертөнцийг орхисныхоо дараагаар ч ертөнц дахинд нөлөөгөө үзүүлдэг тухай юм:

Вайшнав үхдэг хэмээн тайлбарлагч нь гарцаагүй төөрч будилсан нэгэн юм.

Яагаад гэвэл түүний амьдрал авиан дунд үргэлжилмүй

Үхсэнээрээ вайшнав нь амьдрах бөгөөд харин

Амьдран ахуйдаа вайшнав нь ариун гэгээн нэрийг ертөнц дахинаа хайрламуй.

Шрила Бхактивинода: “Тун удахгүй дэлхий нийтэд Хари Бурханы арин нэрийг номлох бодгаль залрах болно” хэмээн зөгнөн хэлсэн байдаг. Энэ нь Бурханы Адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадагийн тухай болох нь нэн тодорхой билээ. Би, түүний бурханлаг бадамлянхуан өлмийд өөрийгөө даатгасан бүхэнд болон ирээдүйд түүний бадамлянхуан өлмийд өөрийгөө даатгах хэн бүхний өмнө доор мэхийн мөргөмүү. Мөн эцэст нь дахин дахин түүний бадамлянхуан өлмийд хүлцэнгүйгээр мөргөн залбирнам. Тэрээр миний энэхүү анхны орчуулгын оролдлогыг Бурхан Кришна хүлээн авах адис ерөөлөө хайрлах болтугай. Мөн тэрээр намайг Вриндаваны зургаан Госвами, Бурхан Чайтанья хийгээд Радхарани нарт үйлчлэн зүтгүүлэх болтугай.

Ачьютананда Свами

1972 оны наймдугаар сарын 20.

Шрила Рупа Госвамийн одсон өдөр

Радха-Дамодарын сүм
Сева-кунжа, Вриндаван

БАГШ ШАВИЙН ХЭЛХЭЭ

ЗУРАГ 1

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта

Свами Прабхупада-ИСККОН-ы үндэслэгч-ачарья,

Кришнагийн ухамрыг Өрнөдөд түгээсэн аугаа их номлогч

ЗУРАГ 2

Шрила Бхактисиддханта Сарасвати Госвами Махараж- Бурханы адислалт

А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадагийн номын багш,

манай цаг үеийн аугаа чин бишрэлтэн

ЗУРАГ 3

Шрила Гауракишора дас Бабажи Махараж-

Шрила Бхактисиддханта Сарасвати Госвами Махаражийн

номын багш ба Шрила Бхактивинода Тхакурын ойрын шавь

ЗУРАГ 4

Шрила Бхактивинода Тхакур, Бурханы аугаа чин бишрэлтэн

Кришнагийн ухамсрыг дэлхий нийтэд түгээх үйлийн

үндсийг тавигч

Үндсэн залбирлууд

Шри гуру пранама

ом ажн̄ана-тимир̄андхасйа жн̄ан̄ан̄жана-шалакайа

чакишур унм̄илитам йена тасмаи ӣрй-гураве намах

ом-хандлага; *ажн̄ана*-мунхаг; *тимира*-харанхуйд; *андхасйа*-сохорсон нэгэн; *жн̄ана-ан̄жана*-бурханлаг мэдлэгийн тос; *шалакайа*-шалака гэж нэрлэгдэх эмчилгээний хэрэгсэл, цагаа унасан нүдэнд тос түрхэхэд ашигладаг; *чакишур*-нүд; *унм̄илитам*-нээсэн; *йена*-түүгээр; *тасмаи*-түүнд; *ӣрй-гураве*- номын багш танаа; *намах*-мөргөнөм

Би номын багш танаа гүн хүндэтгэлтэйгээр мөргөмүү. Та вээр мэдлэгийн бамбараар мунхагийн харанхуйг үлдэн хөөж, сохорсон харалган нүдийг минь нээн өгсөн билээ.

Шри Рупа пранама

ӣрй-чаитанйа-mano- 'бхй̄ш̄там̄ стх̄ап̄итам̄ йена бх̄-тале

свайам р̄упах̄ кад̄а мах̄йам̄ дад̄ати сва-пад̄ан̄тикам̄

ӣрй-чаитанйа- Бурхан Чайтаний; *манах*-ухаанд; *абх̄й̄ш̄там̄*-хүсдэг; *стх̄ап̄итам̄*-үндэслэсэн; *йена*-түүнд; *бх̄-тале*-дэлхийн бөмбөрцгийн гадаргуу дээр; *свайам*-өөрөө; *р̄упах̄*-Шрила Рупа Госвами; *кад̄а*-хэзээ; *мах̄йам̄*-надад; *дад̄ати*-өгдөг; *сва*-өөрийн; *пада*-бадамлянхуан өлмий; *антикам̄*-танаа ойр дотно.

Энэхүү материаллаг ертөнцөд Бурхан Чайтаньягийн хүсэл тааллыг гүйцээхээр уриалан дуудсан энэхүү хөдөлгөөнийг эхлүүлсэн Шрила Рупа Госвами хэзээ намайг өөрийн бадамлянхуан өлмийн доор өмөг түшиг олох боломжийг олгох вэ?

Мангалачарана

ванде 'хам̄ ӣрй-гурох̄ ӣрй-йута-пада-камалам̄

ӣрй-гур̄ун̄ вашӣнав̄ам̄и ча

úrĭ-rūnam sāgrajātam saḥa-gaṇa-raḡhunātxānvitām

там са-жйвам

sādvaitām sāvadhūtām pariḡjana-saḡitam

криṇa-чаитанйа-девам

úrĭ-rādhā-kriṇa-nādhān saḥa-gaṇa-lalitā-

úrĭ-viśākḡhānvitāmī ча

ванде- гүн хүндэтгэлтэйгээр мөргөнөм; *ахам-би*; *úrĭ-гуроḡ* -надад авшиг хайрласан номын багштан буюу сургаалаа хайрлагч номын багш; *úrĭ-йута-пада-камалам*-бүхий л эд баялагийн үндэс болсон бадамлянхуан өлмий; *úrĭ-гурūn* -Мадхавендра Пуригээс авахуулаад Шрила Бхактисиддханта Сарасвати Тхакур Прабхупада хүртэлх парампарад хамаарах номын багшуудын өмнө; *вайшṇавān*-бүхий л вайшнавчуудын өмнө; *ча-мөн*; *úrĭ-rūnam* -Шрила Рупа Госвамиын өмнө; *са-агра-жātam*- түүний ах Санатана Госвамиын; *saḥa-gaṇa-raḡhunātxānvitām*-Рагхунатха дас Госвами болон түүний дагалдагчидтай; *там*-тэдний өмнө; *са-жйвам*-Жива Госвамитай; *са-адvaitām*-Адвайта Ачарьятай; *са-авадхūtām*-Нитьянанда Прабхутай; *pariḡjana-saḡitam*-Шриваса Тхакур болон бусад чин бишрэлтэнгүүдтэй; *kriṇa-чаитанйа-девам*- Бурхан Чайтанья Махапрбхугийн өмнө; *úrĭ-rādhā-kriṇa-nādhān* -бүхий л давуу байдлыг шингээсэн Шри Кришна болон Радха нарын бадамлянхуан өлмийд; *saḥa-gaṇa*-дагалдагч нартай; *lalitā-úrĭ-viśākḡhānvitā*-Лалита болон Шри Вишакха нарыг дагалдан; *ча*-түүнчлэн.

Би вээр өөрийн номын багш хийгээд намайг чин бишрэлийн зам мөрөөр хөтөлсөн бүхий л сургаал номлол айлдагчдын бадамлянхуан өлмийд гүн хүндэтгэлтэйгээр мөргөмүү. Мөн би Шрила Рупа Госвами, Шрила Санатана Госвами, Рагхунатха дас Госвами, Жива Госвами –эдгээр зургаан Госвами болон тэдгээрийн дагалдагч нарын өмнө хүндэтгэл бишрэлээ өргөнөм. Түүнчлэн би Шри Адвайта Ачарья Прабху, Шри Нитьянанда Прабху, Шри Чайтанья Махапрабху, Шриваса Тхакур тэргүүтэй Түүний чин бишрэлтэн нарын өмнө гүн хүндэтгэлээ илэрхийлэн мөргөмүү. Эцэст нь би Бурхан Кришна, Шримати Радхарани, Лалита, Вишакха тэргүүтэй бүхий л гопи нарын бадамлянхуан өлмийд гүн хүндэтгэлтэйгээр мөргөн залбирмуу.

Шрила Прабхупадагийн пранама мантра

*нама ом вишну-пāдāйя кришна-прештхāйя бхū-тале
ирй̄мате-бхактиведāнта-свāмин ити нāмине*

"Би вээр, Түүний бадам лянхуан өлмийд өмөг түшиг олсны учир Бурхан Кришнад машид эрхэм Шри Шримад А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада танаа бишрэл хүндэтгэл бүхнээ өргөн мөргөмү".

намаḥ-мөргөмүү; ом-хандахуй; вишну-пāдāйя-Бурхан Вишнугийн өлмий дор орших түүнд; кришна-прештхāйя-Бурхан Кришнад машид эрхэм; бхū-тале-дэлхий дээр; ирй̄мате-гайхамшигт; бхактиведāнта-свāмин- А.Ч.Бхактиведанта Свами; ити-тэгж; нāмине-нэрлэгддэг.

*намас те сāрасвате деве гаура-вāñй-прачāриṇе
нирвейеша-й̄унйавāди-пāичāтйа-дей̄а-тāриṇе*

намаḥ-мөргөмүү; те-ганд; сāрасвати деве-Бхактисиддханта Сарасвати Госвамийн албат; гаура-вāñй-Бурхан Чайтаньягийн сургаал; прачāриṇе-номлогч; нирвейеша-имперсонализм; й̄унйавāди- хоосон чанарын номлолоос; пāичāтйа-барууны; дей̄а-орнууд; тāриṇе-аврагч.

"Ай Сарасвати Госвамийн шавь, номын багш танаа сөгдөн биширч мөргөмү. Та бээр Бурхан Чаитаньядевын сургаалыг өршөөнгүйгээр номлож имперсонализм болон хоосон чанарын гүн ухаан халдварласан барууны орнуудад ангижралын үйлийг бүтээнэм".

Шрила Бхактисиддханта Сарасвати пранати

нама ом вишну-пāдāйя кришна-прештхāйя бхū-тале

ирй̄мате бхактисиддхāнта-сарасватй̄ити нāмине

Би вээр Бурханы бадамлянхуан өлмийгөөс өөр өмөг түшиг үгүйн учир Бурхан Кришна танаа машид эрхэм Бурханы Адислалт Бхактисиддханта Сарасвати таны өмнө гүн хүндэтгэлээ илэрхийлэн мөргөмүү.

ирй̄-вāршабхāнавй-деви-дайтйā крпāбдхайе

кришна-самбандха-вижñāна-дāйине прабхаве намаḥ

úrī-vāṛṣhabhānavī-devī-daitāya- Шри Варшабханавидеви-дайита дас; амраг хайрт Шримати Радхаранийн албатад; *kṛpā-abdхайе-*адис хишгийн далай; *кришна-самбандха-*Кришнатай холбогдсон харьцаа холбооны тухай; *вижнāна-*практик мэдлэг; *дāйине-*дамжуулагчид; *прабхаве-*эзэнд; *намах-*мөргөмүү.

Би вээр Шримати Радхаранийн адислалыг хүлээсэн Шри Варшабханавидеви-дайита дас(Шрила Бхактисиддханта Сарасватийн өөр нэг нэр, сахилын нэр) таны өмнө гүн хүндэтгэлтэйгээр мөргөн залбирмуу. Тэрвээр трансцендент адис өршөөлийн далай бөгөөд хүмүүст Кришнагийн тухай эрдэм ухааныг тээн авчирнам.

мāдхурйаоажжвала-премāдхйа-úrī-рūпāнуга-бхактида-

úrī-гаура-каруṅā-йакти-виграхāйа намо 'сту те

*мāдхурйа-*амрагийн; *ужжвала-*гэрэл цацруулсан; *према-*хайраар; *āдхйа-*чимэглэсэн; *úrī-рūпā-ануга-*Шрила Рупа Госвамиин өлмийг даган; *úrī-гаура-*Бурхан Чайтанья Махапрабхугийн; *каруṅā-*өршөөлөөр; *йакти-*эрчим хүчний; *виграхāйа-*бэлэгдэл болсон; *намах-*мөргөмүү; *асту-* болтугай; *те-*танд.

Ай Бурхан Шри Чайтаньягийн өршөөл адислалын эрч хүчний хувилгаан минь ээ, таны өмнө гүнээ хүндэтгэн мөргөе. Шрила Рупа Госвамиин сургаалыг гуйвалтгүй мөрдөн та бээр Радха-Кришнагийн хайр дурлалаар чимэглэсэн чин бишрэлийн алба үйлийг хүмүүст тээн авчирнам бөлгөө.

намас те гаура-вāнй-úrī-мўртайе дйна-тāриṅе

рūпāнуга-вируддхāпасиддхāнта-дхвāнта-хāриṅе

*намах-*мөргөмүү; *те-*танд; *гаура-вāнй-*Бурхан Чайтанвьягийн сургаалаар; *úrī-мўртайе-*бэлэгдэл болсон; *дына-*унан доройтсон; *тāриṅе-*аврагч; *рūпā-ануга-*шрила Рупа Госвамиин сургаал дээр үндэслэсэн гүн ухаан; *вируддха-*эсрэг; *апасиддхāнта-*үндэслэлгүй нотолгоо; *дхвāнта-*харанхуйд; *хāриṅе-*үлдэн хөөгч танд бээр.

Би вээр Бурхан Чайтаньягийн сургаалын хувилгаан болсон таны өмнө гүнээ хүндэтгэн мөргөмүү. Ай унан доройтсон сүнснүүдийн аврагч минь ээ, та вээр Шрила Рупа Госвамиин айлдсан чин бишрэлийн албаны тухай эрдэм ухаантай зөрчилдсөн аливаа баталгаа нотолгоог үл тэвчдэг билээ.

Шрила Гауракишора пранати

намо гаура-кииорайа сакшиад-ваирайа-муртайе

випраламбха-расамбходе падамбужайа те намах

намах-мөргөмүү; гаура-кииорайа-Гауракишора дас Бабажи танаа; сакшиат-шууд; ваирайа-огоорлын; муртайе-бэлэгдэл болсон; випраламбха-хагацлын(Кришнагаас); раса-рашааны; амбходе- ай далай минь ээ; пада-амбужайа-бадамлянхуан өлмийд; те-таны; намах-мөргөмүү.

Би вээр огоорол цээрийн бэлэгдэл болсон Гауракишора дас Бабажи Махараж таны өмнө гүнээ хүндэтгэн мөргөнөм. Тэрээр Кришнаг хайрлах гүн гүнзгий хайраар бялхан байх бөгөөд Түүнээс хагацан салахуйг тэвчиж ядан шаналах бөлгөө.

Шрила Бхактивинода пранати

намо бхактивинодайа сач-чид-ананда-намине

гаура-йакти-сварупайа рупануга-варайа те

намах-мөргөмүү; бхактивинодайа-Шрила Бхактивинода Тхакур танаа; сач-чид-ананда-намине-Саччидананда нэрээр алдаршсан; гаура-Бурхан Чайтаньяд; йакти-эрч хүчний; сварупайа-бэлэгдэл болсон; рупа-ануга-варайа-Шрила Рупа Госвамиин бүхий л эрхэм дагалдагч нарт; те-танаа.

Би вээр Чайтанья Махапрабхугийн трансцендент эрч хүчний бэлэгдэл болсон Саччидананда Бхактивинода таны өмнө гүн хүндэтгэлээ илэрхийлэн мөргөмүү. Тэрээр Шрила Рупа тэргүүтэй Госвами нарын заасан замаар хэлбэрэлтгүйгээр замнадаг билээ.

Шрила Жаганнатха пранати

гаурāvирбхāва-бхūмес твам̐ нирдештā саж-жана-приях

ваишнāва-сāрвабхāумах̐ йрй-жаганнатхāйа те намах

гаура-Бурхан Чайтаньийн; авирбхāва-илрэл тодрол; бхūмех-газар нутаг; твам-та; нирдештā-зааж чиглүүлж өгсөн; сат-жана-бүх ариун гэгээнтнүүдэд; приях-

эрхэм; *ваишнава*-вайшнавуудын дундах; *с̄рвабхаумах*-үндсэн гол; *й̄рй̄-жаганны̄тх̄айа*-Жаганнатха дас Бабажи; *те*-танд; *намах*-мөргөмүү.

Би вээр Бурхан Чайтаньягийн илэрч заларсан газар нутгийг олж тогтоосон, бүх вайшнавуудын хүндэтгэлийг хүлээсэн Жаганнатха дас Бабажи таны өмнө гүн хүндэтгэлээ илэрхийлэн мөргөмүү.

Шри вайшнава пранама

в̄ай̄чх̄а-калтатарубх̄йаиш ча кр̄п̄а-синдхубх̄йа эва ча

патит̄ан̄м̄ п̄аванебх̄йо ваиш̄навебх̄йо намо намах

в̄ай̄чх̄а-калтатарубх̄йах-хүслийг биелүүлэгч мод лугаа адил; *ча*-ба; *кр̄п̄а*-өршөөл адислалын; *эва*-эргэлзээгүйгээр; *ча*-мөн; *патит̄ан̄м̄*-унан доройтсон сүнснүүд; *п̄аванебх̄йах*-тэднийг ариусгадаг; *ваиш̄навебх̄йах*-вайшнавуудад; *намах намах*-олонтоо мөргөмүү.

Би вээр Бурханы чин сүсэг бишрэлтэн, бүхий л вайшнавуудын өмнө гүн бишрэл сүсэгтэйгээр мөргөмүү. Тэд унан доройтсон болзолт сүнснүүдийг энэрэн нигүүлсэх сэтгэлээр дүүрэн бөгөөд бүхий л хүслийг биелүүлэх хүслийн мод лугаа адил билээ.

Шри Гауранга пранама

намо мах̄а-вад̄ан̄й̄айа крӣш̄на-према-прад̄айа те

крӣш̄н̄айа крӣш̄на-чайтан̄йа-н̄амне гаура-твише намах

намах-мөргөмүү; *мах̄а-вад̄ан̄й̄айа*-хамгийн өгөөмөр хийгээд өршөөнгүй түүнд; *крӣш̄на-према*-Кришнаг хайрлах хайр; *прад̄айа*-өгч чадах; *те*-Танд; *крӣш̄н̄айа*-Бурханы Анхдагч Бодгаль; *крӣш̄на-чайтан̄йа-н̄амне*-Кришна Чайтанья нэрээр; *гаура-твише*-Шримати Радхарани мэт алтан шаргал биетэй; *намах*-мөргөмүү.

Ай Бурханы хамгийн өршөөл энэрэлт хувилгаан минь ээ! Та вээр Шри Кришна Чайтанья Махапрабхугийн дүрээр заларсан Шри Кришна Өөрөө билээ. Таны бие Шримати Радхаранийн алтлаг өнгийг олсон агаад Кришнаг хайрлах цэвэр ариун хайрыг өршөөнгүйгээр түгээнэм. Гүн хүндэтгэлтэйгээр Таны өмнө мөргөн залбирмуу.

Шри Панча-таттва пранама

пайча-таттвайтмакам кришнам бхакта-рӯпа-сварӯпакам

бхактаватарам бхактакхийам намāми бхакта-йаактикам

пайча-таттва-айтмакам-таван трансцендент үнэнийг оруулаад; *кришнам*-Бурхан Кришна танаа; *бхакта-рӯпа*-чин бишрэлтний дүрээр; *сварӯпакам*-Өөрийн чин бишрэлтэн илрэлд; *бхакта-аватарам*-чин бишрэлтний хувилгаан; *бхакта-айкхийам*-чин бишрэлтнийг тэтгэж байдаг Дээд Бурханы эрчмийн.

Би вээр чин бишрэлтэн, чин бишрэлтний дүрт Бурханы хувилгаан, чин бишрэлтний шинж чанарыг шингээсэн Бурханы илрэл, цэвэр чин бишрэлтэн хийгээд чин бишрэл зүтгэлийн эрч хүч гэх зэрэг Өөрийн илрэл хувиллуудаас үл ялгарах Дээд Бурхан, Кришна Таны өмнө сөгдөн мөргөмүү.

Шри Кришна пранама

хе кришна каруṇā-синдхо дйна-бандхо жагат-пате

гопейма гопикā-кāнта рāдхā-кāнта намо 'сту те

хе-өө; *кришна*-Кришна; *каруṇā-синдхо*-Ай өршөөл адислалын далай минь ээ; *дына*-зовж шаналагсад; *бандхо*-найз; *жагат*-орчлон; *пате*-Ай Эзэн минь ээ; *гопа-ййма*-Ай малчдын эзэн минь ээ; *гопикā-кāнта*-ай гопи нарын дурлалт хархүү минь ээ; *рāдхā-кāнта*-Ай Радхаранийн амраг хайрт минь ээ; *намах*-мөргөмүү; *асту*-болтугай; *те*-Танд.

Ай Кришна, ай өршөөл адислалын далай минь ээ! Та вээр бүтээлийн эх булаг хийгээд зовж зүдэрсэн бүгдийн найз нөхөр билээ. Та бол Вражийн малчдын эзэн захирагч бөгөөд гопи нарын амраг хайрт нь ба тэдний дундаас Танд нэн эрхэм нь Радхарани юмаа. Гүн хүндэтгэлтэйгээр Таны өмнө сөгдөн мөргөмүү би.

Самбандхадхидева пранама

жайатām суратау пайгор мама манда-матер гатй

мат-сарвасва-падāмбхожау рāдхā-мадана-моханау

жайатām-алдар суу; *су-ратау*-хамгийн өршөөнгүй буюу нэг нэгэндээ ихэд элгэмсэг хань ижил; *пангох*-догolon; *мама*-намайг; *манда-матех*-тэнэг мулгуу; *гатī*-өмөг түшиг; *мат*-миний; *сарва-сва*-бүгд; *пада-амбхожау*-түүний бадамлянхуан өлмий; *рāдхā-мадана-моханау*-Радхарани хийгээд Мадана-мохана;

Бүгдэд өршөөнгүйгээр хандагч Радха болон Мадана-мохана нарын алдар бадартугай! Тэд догolon хазгар, болхи ухаант намайг чин үнэний зам мөрөөр хөтөлнөм. Миний хувьд бүхий ертөнц даяар Тэдний бадамлянхуан өлмийгөөс өөр юу ч үл орших бүлгээ.

Абхидхедхидева пранама

дйвйад-врндāраñйа-кална-друмадхāх

йрймад-ратнāгāра-симхāсана-стхау

йрймад-рāдхā-йрйла-говинда-девау

прештхāлйбхих севйāmāнау смарāми

дйвйат-гэрэл цацарсан; *врндā-араñйа*-Дриндаваны ой шугуйд; *кална-друма*-хүслийн мод; *адхāх*-доор; *йрймат*-маш үзэсгэлэнтэй; *ратна-āгāра*-үнэт эрдэнийн чулуун сүмд; *симхā-āsана-стхау*-ширээн дээр сууж буй; *йрймат*-маш үзэсгэлэнтэй; *рāдхā*-Шримати Радхарани; *йрйла-говинда-девау*-ба Шрила Говиндадеву; *прештха-āлйбхих*-хамгийн дотны дагалдагчид; *севйāmāнау*-түүнд үйлчлэн зүтгэдэг; *смарāми*-би дурсан санадаг.

Вриндаванд, хүслийн модод дор орших үнэт эрдэнийн чулуудаар хийгдсэн сүмд гэрэл цацарсан ширээн дээр Шри Шри-Радха-Говинда залрах бөлгөө. Тэдэнд хайраар үйлчлэн зүтгэх бараа бологсод, дагалдагсад нь Тэднийг тойрон хүрээлмүй. Би вээр Тэд бүхний өмнө хүлцэнгүйгээр мөргөн залбирмуу.

Прайожанадхидева пранама

йрймāн рāса-расāрамбхй вāmйй-ватā-татā-стхитāх

каршан-вену-сванаир гопйр гопйнāтхāх йрйе 'сту нах

úrīmān-үзэсгэлэнтэй; *rāsa*-раса бүжгийн; *rasa*-амтлаг харьцаа; *ārambhī*-эхлэлийг тавьсан; *vamīyī-vatā*-Вамшивата гэж нэрлэгдэх тэрээр; *tatā*-эрэг дээр; стхитах-зогсон буй; *karīṣan*-дур сэтгэлийг татагч; *veṇu*-лимбэний; *svanaiḥ*-авиагаар; *gopīḥ*-малчид; *gopīnātḥaḥ*-Шри Гопинатха; *úrīye*-адислал; *astu*-болтугай; *naḥ*-бидний.

Раса бүжгийн трансцендент амтны эх үндэс болсон Шри Шрила Гопинатха нь Вамшиватад, Ямуна мөрний эрэг дээр зогсон малчин бүсгүйчүүдийн бүхий анхаарлыг соронздон татаж, Өөрийн алдарт лимбэн дээр тоглон байна. Тэд бидэнд өөрсдийн адис өршөөлөө хайрлах болтугай.

Шри Радха пранама

tatā-kāñcana-gaurāṅgi rādhe vṛndāvaneyīvari

vṛṣabhānu-sute devi praṇamāmi hari priye

tatā-хайлсан; *kāñcana*-алт мэт; *гаура*-гэрэлтсэн арьс; *āṅgi*-ай Таны бие; *rādhe*-Ай Радхарани; *vṛndāvana-īīvari*-Ай Вриндаваны хатан хаан минь ээ; *vṛṣabhānu-sute* –ай Вришабхану хааны охин минь ээ; *devi*-ай дарь эх минь ээ; *praṇamāmi*-би хүндэтгэлээ илэхийлмүй; *hari priye*-ай Бурхан Кришнад машид эрхэм Та минь ээ.

Би вээр Түүний арьс нь хайлсан алт мэт өнгөтэй Вриндаваны хатан хаан Радхарани танаа бишрэл хүндэтгэлээ илэрхийлмүй. Та вээр Ай Вришабхану хааны охин минь ээ, Бурхан Кришнад машид эрхэм билээ.

Панча-таттва маха-мантра

(жайа) úrī-kṛiṣṇa-chaitānyā praḥu nitīānanda
úrī-advaita gādādhara úrīvāsādi-gaura-bhaktā-vṛnda

Шри Чайтанья Махапрабхуг Түүний бүрэн хувилгаан дүр Шри Нитьянанда Прабху, Түүний хувилгаан Шри Адвайта Прабху, Түүний дотоод эрчим Гададхара Прабху, Түүний хязгаарын эрчим Шриваса Прабху нар үргэлжид дагалддаг. Тэрээр Өөрөө Дээд Бурханы Бодгаль тул төвд нь зогсож байдаг. Эдгээр таттвагууд Шри Чайтанья Махапрабхуг үргэлжид дагалдан байдаг гэдгийг санаж байх хэрэгтэй. Иймээс ч Түүнд хүндэтгэл бишрэлээ илэрхийлэхийн тулд бид, *úrī-kṛiṣṇa-chaitānyā praḥu nitīānanda úrī-advaita gādādhara úrīvāsādi-gaura-bhaktā-vṛnda* хэмээн уншдаг. Кришнагийн ухамсрын хөдөлгөөний номлогчид учраас бид юуны өмнө Панча-таттва мантраг уншиж Шри Чайтанья Махапрабхууд хүндэтгэл

бишрэлээ илэрхийлдэг билээ. Зөвхөн ийнхүү уншсаныхаа дараагаар л бид Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе хэмээн давтан уншдаг. Харе Кришна *маха-мантраг* давтан уншигч хүн нь ариун гэгээн нэр алдарт арван төрлийн алдас доромжлолыг учруулж болзошгүй байдаг хэдий ч харин Панча-таттва мантраг (*жайа*) *и́рй-кри́на-чайта́нйа пра́бху нити́ананда и́рй-адвайта гада́дхара и́рйвāсāди-гаура-бхакта-врнда*) уншсанаар энэ алдас эндэл учирдаггүй. Шри Чайтанья Махапрабху унан доройтсон сүнснүүдийн учруулж болох алдас доромжлолд ач холбогдол өгдөггүй. Иймээс ч Түүнийг *махā-вадāнийāватāр* буюу хамгийн өгөөмөр Бурханы хувилгаан хэмээн нэрлэдэг. Ийнхүү *маха-мантраг* (Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама, Харе Харе) давтан уншсанаар бид илүү дээд үр дүнд хүрэхийн тулд эхлээд Шри Чайтанья Махапрабхугийн ивгээлд багтах хэрэгтэй. Үүний тулд Харе Кришна *маха-мантраг* уншихын өмнө Панча-таттва *мантраг* уншигтун. Энэ тохиолдолд Харе Кришна *мантра* түүнийг давтан уншигч хүнд хамгийн хүчтэй нөлөөгөө үзүүлэх болно.

Харе Кришна маха-мантра

ХАРЕ КРИШНА

ХАРЕ КРИШНА

КРИШНА КРИШНА

ХАРЕ ХАРЕ

ХАРЕ РАМА

ХАРЕ РАМА

РАМА РАМА

ХАРЕ ХАРЕ

Бурханы Адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын

тайлбар

Харе Кришна Харе Кришна, Кришна Кришна Харе Харе, Харе Рама Харе Рама, Рама Рама Харе Харе – г давтан уншсанаас үүсэх трансцендент авиа чичирхийлэл нь бидний трансцендент ухамсрыг дуудан сэрээх шилдэг арга юм. Амьд бурханлаг сүнс буюу бид анхнаасаа л Кришнаг ухамсарлагч амьтас гэлээ ч өнөөгийн энэ цаг үед бидний ухамсар материаллаг ахуйн нөлөөллийн улмаас бузардан бохирдсон

(жая) йāмуна-тйра-вана-чāрй*

Радхын амраг хайрт Кришна вээр
Вриндаваны ой шугуйд

Амраг хайрын тоглоом цэнгэлээ өрнүүлмүй.
Вражийн малчдын хайрыг булаасан тэрвээр
Аугаа уул Говардханыг хялбараар өргөсөн билээ.
Яшода ээжийн хайртай хүү,
Вражийн оршин суугчдын баяр баясгалан тэрээр
Ямуна мөрний эрэг дагуухь ой шугуйгаар
Ямагт хэрэн зугаацаж явмуй.

Шрила Прабхупада энэ дууг дуулах маш их дуртай байсан юм. Тэрээр энэ дууг лекц эхлэхийнхээ өмнө дуулдаг байв. Аллахабад, Горакхпурт лекц хийж байх үедээ энэ дууны эхний хоёр мөрийг дуулмагцаа транс буюу гүн бясалгалд орж байлаа. Хэсэг хугацааны дараа орчноо мэдрэх чадвартай болуут тэрээр: ”одоо зүгээр л Харе Кришнаг” дуулцгаагтун гэж билээ. Шрила Прабхупада хэлэхдээ, энэ дуу бол “Вриндаваны маш тодхон дүрслэл хийгээд түүнд Шримати Радхарани, Вриндаван, Говардхан, Яшода ээж, Вриндаваны малчид бүгд багтсан байдаг” хэмээн ярьдаг байв.

Сиддхи-лаласа
Бурханлаг төгс төгөлдөрт хүрэх тэсч ядсан хүсэл
(«Шаранагати»-гаас)

Энэ дуугаа Шрила Бхактивинода Тхакур “Сиддхи-лаласа” хэмээн нэрлэжээ. *Лаласа* гэдэг нь “тэсч ядан хүсэх, угтан баясах” хэмээсэн утгатай ба *сиддхи* нь “төгс төгөлдөр” гэсэн утгатай. Төгс төгөлдөрт хүрэх гэсэн тэсч ядсан хүсэл, тэсч ядан баясахыг *сиддхи-лаласа* гэж нэрлэдэг. Чин бишрэлтэнгийн хувьд материаллаг цэнгэлд тэмүүлэх, диваажингийн гаригт төрөх, ид шидийн хүч чадвар болон ангижралд тэмүүлэх хүсэл сонирхол өчүүхэн ч үгүй болсон байдаг. Тэрээр бүр ангижралын дээд дөрвөн хэлбэрт ч хүрэхийг хүсдэггүй. Энэхүү ангижралын дөрвөн хэлбэр нь: Бурхан мэт баян чинээлэг болох, Бурхан Вишну мэт бие галбиртай болох, Бурханы хүрээлэлд үргэлж орших хийгээд бурханлаг тэнгэрт Бурхантай хамт нэг гариг дээр хамт амьдрах юм. Цэвэр чин бишрэлтэн нь цор ганц зүйлийг л тэсч ядан хүсдэг бөгөөд энэ нь Бурханд ашиг хонжоо харалгүйгээр үйлчлэн зүтгэхэд оршдог. Чухамхүү ийм л төгс төгөлдөрт хүрэхээр тэмүүлэх хэрэгтэй.

1

кабе гаура-ване, сурадхунй-тате,
‘хā рāдхā хā кришнā’ боле’
кāндийā берā’бо, дехо-сукха чхāри’,
нāнā латā-тару-тале

2

йва-пача-грхете, мāгийā кхāйбо,
пибо сарасватй-жале

*пулине пулине, гарā-гари дибо,
кори 'криṇа-колāхала*

3

*дхāма-бāсī жане, праṇати корийā,
мāгибо крпāра лейиа
ваишṇаба- чараṇа-реṇу гāйи мāкхи',
дхори' авадохṽта-беиā*

4

*гауда-бража-жане, бхеда нā декхибо,
хоибо баража-бāсī
дхāмера сварṽпа, спхурибе найане,
хоибо рāдхāра дāсī*

1. Хэзээ би тав тухтай байдал, амар жимэр ахуйг мартан “Радха! Кришна!” хэмээн нулимсаа урсган хашгирч ороонго ургамалд бүрхэгдсэн модод доор орших Навадвипа дахь Ганга мөрний эрэг дагуу хэрэн хэсүүчлэж явах болоо ?

2. Өглөг хишиг цуглуулан явахуйдаа би бүр *чандалын* гэрээс ч хоол хүнс хүсэн гуйх бөгөөд Сарасватийн уснаас ундлан явах болно. Онгод хөөрөлд автан мөрний эрэг дэхь газар дээгүүр өнхрөн би чангаар “Кришна! Кришна!” хэмээн дуудах болно.

3. Ариун Навадвипын оршин суугчдын өмнө сөгдөн мөргөөд би тэднээс ядаж дусал ч атугай өршөөл хишгээ хайрлахыг гуйна даа. Би гуйлгачны ноорхой хувцас өмсөн явж, өөрийн биеэ вайшнавуудын бадамлянхуан өлмийн тоосоор цацах болно.

4. Би Вражабхуми болон Навадвипын оршин суугчдын хоорондох ялгааг олж хардаггүй бөгөөд өөрөө би Вражийн суугч болуу. Бурханы орны жинхэнэ байгаль надад нээгдэж би Шримати Радхаранийн үйлчлэгч бүсгүй болно.

Кабе ха'бе боло
(«Шаранагати»-гаас)

1

*кабе ха'бе боло се-дина āmār
(āmār) апарāдха гхучи', иṽддха нāма ручи,
крпā-бале ха бе хрдойе саṅчāр*

2

*трṅāдхика хīна, кабе ниже мāни,
сахишṅутā-гуṇа хрдойете āни,*

сакале м̄анада, āпани ам̄ан̄и,
хо'йе āсв̄адибо н̄ама-раса-с̄а р

3

дхана жана āра, кобит̄а-сундар̄и,
болибо н̄а ч̄ахи дехо-сукха-кар̄и
жанме-жанме д̄ао, охе гаурахари!
ахаитук̄и бхакти чараṇе том̄р

4

(кабе) корите ӣр̄и-криṣṇа-н̄ама учч̄араṇа,
пулакита дехо гадгада бачана
баибарṇ̄и-а-бепатху, ха'бе сан̄гхат̄ана,
нирантара нетре ба'бе ай̄ру-дх̄р

5

кабе навадв̄ипе, сурадхун̄и-таṭе,
гаура-нит̄ий̄ананда боли' нишкапаṭе
н̄ачий̄а г̄аий̄а, бер̄аибо чхут̄е,
б̄атулера пр̄а̄йа чх̄арий̄а бич̄р

6

кабе нит̄ий̄ананда, море кори' дой̄а,
чх̄р̄а̄й̄абе мора вишайера м̄й̄а
дий̄а море нижа-чараṇера чх̄й̄а,
н̄амера х̄аṭете дибе адхик̄р

7

кинибо, лут̄ибо, хари-н̄ама-раса,
н̄ама-расе м̄ати'хоибо биба̄йа
расера расика-чараṇа парай̄а,
корий̄а можибо расе аниб̄р

8

кабе ж̄й̄абе дой̄а, хоибо удойа,
нижа-сукха бхули' суд̄ина-хрдойа
бхакативинода, корий̄а бинойа,

ири-ажна-тахала корибе прачар

1. Хэзээ энэ өдөр ирэхийг хэлж өгөөч надад? Би алдас эндлийг үйлдэхээ больж миний зүрхэнд Бурханы ариун гэгээн нэрэнд татагдах амт хэзээ бий болох вэ?

2. Хэзээ би өөрийгөө зам дээр хэвтэх өвснөөс ч доогуурт тавьж, бусдад хүндэтгэлээ үзүүлдэг болох вэ? Хэзээ би зүрх сэтгэлдээ тэвчээртэй байдлыг хөгжүүлж, хуурмаг бардам зангаас хагацан ангижрах вэ? Зөвхөн тэр цагт л би ариун гэгээн нэрийн цэвэр тунгалаг рашааны салшгүй амтыг мэдэрч чадахсан билээ.

3. Би материаллаг найраг шүлгэнд магтан дуулсан эд баялаг, дагалдагч шавь нар, үзэсгэлэнтэй сайхан эмэгтэй гэх мэт материаллаг цэнгэл жаргал авчрах юуг ч хүсэхгүй. Ай Бурхан Гаурахари минь ээ, Танаас гуйя, миний зүрхэнд амьдралаас амьдрал дамжин мөнхөд оршин байсан Таны бадамлянхуан өлмийд тэмүүлэх хольцоогүй цэвэр бишрэл сүсгийг хайрлаач.

4. Хэзээ Шри Кришнагийн бурханлаг нэр алдрыг давтан дуудахуйд миний бие онгод хөөрөлд автан чичрэн дагжиж, дуу хоолой минь догдлол хөөрлөөс болж тасалдан чичирхийлэх вэ? Хэзээ арьс минь цайвартаж, онгод хөөрлийн чичирхийлэл бүх биеэр минь тархах вэ? Хэзээ тогтоон барьж дийлэмгүй нулимс нүднээс минь урсан асгарах вэ?

5. Хэзээ би галзуурсан хүн мэт үнэн сэтгэлээсээ “Өө Гаура! Өө Нитьянанда!” хэмээн дуудаж, Навадвипа дахь Ганга мөрний эрэг дагуу гүйж явахсан болоо? Хэзээ би бүхий л оюун ухаанаа орхин гээж, ухаангүй амьтан мэт дуулан бүжиглэж эхлэх вэ?

6. Хэзээ Бурхан Нитьянанда надад адис өршөөлөө хайрлаж, намайг материаллаг хий хуурмагаас ангижруулах вэ? Хэзээ Тэрээр надад Өөрийн бадамлянхуан өлмийн нөмөр нөөлгийг хайрлаж, ариун гэгээн нэрийн худалдааны өргөн захад нэвтрэх эрхийг олгох вэ?

7. Би Харигийн ариун нэрийн *расыг* худалдаж мөн хулгайлан авах ч болно доо. Тэгээд тэр ариун гэгээн нэрний ариун рашааны гайхамшигт амтанд согтон мансуурч ухаан мэдрэлгүй унах болно. Энэ л *расаар* цэнгэн жаргаж чадах аугаа сүнснүүдийн өлмийд хүрэлцээд би ариун гэгээн нэрийн амтат рашааныг тасралтгүйгээр амтлан хүртэнэ дээ.

8. Хэзээ надад унан доройтсон хөөрхий амьтсыг энэрэн хайрлах сэтгэл төрөх вэ? Хэзээ энэ Бхактивинода өөрийн хувийн жаргалыг умартаж, өрөвч нинжин сэтгэлийг тээн бүгдийг Шри Чайтанья Махапрабхугийн ариун захиасыг биелүүлэхийг хүлцэнгүйгээр хүсэн ертөнц даяар хэсэн явахсан болоо?(Шри Чайтанья Махапрабху бүхий л хүмүүст хандаж: “*боло кришна, бхажо кришна, коро кришна ишкхй*” -Кришнагийн ариун гэгээн нэрийг дуулагтун, Кришнад мөргөгтүн, үйлчлэгтүн, Кришнагийн тухай өгүүлсэн ведийн ном судрыг уншигтун” Чайтанья-бхагавата, Мадхья, 13.9).

Шуддха-бхаката («Шаранагати»-гаас)

бхажана-анукӯла
бхаката-севā, парама-сиддхи,
према-латикāра мӯла

2

мāдхава-титхи, бхакти-жананī,
жатане пāлана кори
кришā-басати, басати боли',
парама āдаре бори

3

гаур āмāра, же-саба стхāне,
корало бхрамаᅇа ранге
се-саба стхāна, херибо āми,
праᅇайи-бхаката-санге

4

мрданга-бāдйа, йуните мана,
абасара садā жāче
гаура-бихита, кйртана йуни',
āнанде хрдойа нāче

5

жугала-мўрти, декхийā мора,
парама-āнанда хойа
прасāда-себā, корите хойа,
сакала прапанчa жайа

6

же-дина грхе, бхажана декхи,
грхете голока бхāйа
чараᅇа-сйдоху, декхийā гангā,
сукха сā сймā пāйа

7

туласй декхи', журāйа прāᅇа,
мāдхава-тошаᅇй жāни'

*гаура-прийа, ййāка-севане,
жйивана сārтхака мāни*

8

*бхакативинода, кришнa-бхажане,
анукūла пāйа жсāхā
прати-дибасе, парамa-сукхе,
свйкāра коройе тāхā*

1. Цэвэр ариун чин бишрэлтний бадамлянхуан өлмийн тоос нь чин бишрэлийн үйл зүтгэлд таатай нөлөөг үзүүлмүй. Мөн вайшнавт үйлчлэхүй нь дээдийн дээд төгс төгөлдөр хийгээд бурханлаг хайрын эмзэг ялдам нахианы үндэс суурь нь билээ.

2. Жанмаштами, Экадаши гэх мэт ариун гэгээн баярын өдрүүд нь тэдгээрт гүн хүндэтгэлтэйгээр хандагч хэн бүхний хувьд чин бишрэл сүсгийнх нь эх юм. Хүндэтгэл, хайр дүүрнээр би өөрийн амьдран суух газар орноо Шри Кришнагийн ариун тоглоом наадам өрнөж асан тэр газарт сонгон авсан билээ.

3. Хүндэт чин бишрэлтэнгүүдтэй хамтаар би Бурхан Гаурасундара аялан явж Өөрийн тоглоом наадгайгаа илрүүлэн байсан бүх газар нутгаар дайран өнгөрмүй.

4. *Мридангийн* дуу авиаг сонсмогц миний ухаан бодол дотор айзамт *киртанд* нэгдэх хүсэл төрөх бөгөөд Бурхан Гаурачандрын тоглоом наадмын тухай өгүүлсэн дууг сонсмогц миний зүрх онгод хөөрөлтэйгээр бүжиглэдэг билээ.

5. Бурханлаг хос Шри Шри Радха-Кришнагийн *муртийг* толидон харснаар би өгүүлж барамгүй баяр хөөрийг амсдаг бөгөөд Бурханы хайрласан *прасадыг* амтлаад би дэлхий ертөнцийн бүхий л хий хуурмагийг ялан дийлдэг билээ.

6. Миний гэр оронд Бурхан Харид мөргөн бишрэх хийгээд үйлчлэн зүтгэх үед гэр маань чухамдаа Голока Вриндавана болон хувирахыг би хардаг бөгөөд Бурхан Шүтээнийг угаасан *чаранамритаг* хүртэн ахуйдаа би Бурханы бадамлянхуан өлмийнөөс урсан гарсан Гангын ариун усыг хардаг билээ. Тиймээс ч миний аз жаргалд хэмжээ хязгаар үгүй байдаг.

7. Ариун мод *туласи нь* миний сүнсний тайвшрал буюу. Учир нь тэрээр Бурхан Кришнад баяр хөөрийг бэлэглэдэг болохыг би сайтар мэдэх билээ. Мөн би Бурхан Чайтаньягийн нэн дуртай *шакийг* хүндэтгэснээр амьдрал маань утга учиргүй биш юм шүү гэдэгт гүнээ итгэдэг билээ.

8. Асар их баяр хөөртэйгээр Бхактивинода өдрөөс өдөрт Шри Кришнад үйлчлэн зүтгэхүйд тааламжтай байх бүхнийг амьдралдаа хэрэгжүүлмүй.

Бхога-арати
("Титавали"-гаас)

(Тхакур Бхактивинодын гэр,
Сурабхи Кунжа, Годрума)

бхажса бхаката-ватсала и́рй-гаурахари
и́рй-гаурахари сохи гош᳚᳚᳚᳚-бихāрй,
нанда-жайоматй-читта-хāрй

2

белā хо'ло, дāмодара, айса эхано
бхога-мандире боси'корахо бхожана

3

нандера нидеийе баусе гири-бара-дхāрй
баладева-саха сакхā баусе сāри сāри

4

и́уктā-и́йāкāди бхāжи нāлитā кушмā᳚᳚᳚᳚
дāли дāлнā дугдха-тумбй дадхи мочā-кхā᳚᳚᳚᳚

5

мудга-борā мāша-борā ро᳚᳚᳚᳚ гхртāнна
и́ашкулй пиш᳚᳚᳚᳚ кхйр пули пāйасāнна

6

карпūра амрта-кели рамбхā кхйра-сāра
амрта расāлā, амла двāдаййа пракāра

7

лучи чини сарпурй лā᳚᳚᳚᳚ расāбалй
бхожана корена крш᳚᳚᳚᳚ хо'йе кутūхалй

8

рā᳚᳚᳚᳚᳚᳚ па́кка анна вивидха бйāйжана
парама йнанде крш᳚᳚᳚᳚ корена бхожана

9

чхале-бале лā᳚᳚᳚᳚ кхāй и́рй-мадхумā᳚᳚᳚᳚
багала бāжйй āра дейа хари-боло

10

рā᳚᳚᳚᳚᳚᳚ га᳚᳚ хери' найанера ко᳚᳚
трпта хо'йе кхāй крш᳚᳚᳚᳚ жайодā-бхаване

11

*бхожанāнте пийе кришṇа субāсита бāри
сабе мукха пракхāлой хо 'йе сāри сāри*

12

*хаста-мукха пракхāлийā жата сакхā-гаṇе
āнанде бийīрāма баладева-сане*

13

*жамбула расāла āне тāmбūла-масāлā
тāхā кхейе кришṇа-чандра сукхе нидрā гелā*

14

*бийīлāкха йикхи-пуччха-чāмара дхулāйя
анūрба йаййāйя кришṇа сукхе нидрā жāйя*

15

*жаййоматй-ājñā не 'йе дханишṭхā-āнйто
йирй- кришṇа-прасāда рāдхā бхунṅже хо 'йе прйто*

16

*лалитāди сакхй-гаṇа аваййеша пāйя
мане мане сукхе рāдхā- кришṇа-гуṇа гāйя*

17

*хари-лйлā эк-мāтра жсāхāра прамода
бхогāрати гāй тхāкур-бхакативинода*

1. Өөрийн чин бишрэлтэнгүүддээ үргэлж эелдэг зөөлөн хандагч Шри Гаурахарид мөргөгтүн. Тэрээр Вражийн нуга талаар тоглон наадах, Нанда, Яшодын зүрх сэтгэлийг хулгайлагч Дээд Бурхан, Кришна Өөрөө билээ.

2. “Миний энхрий Дамодара- хэмээн Яшода ээж Кришнаг дуудан, - их орой болчихлоо. Гэртээ харь, хоолоо идэх цаг боллоо” гэнэ.

3. Говардхан уулыг өргөгч Кришна, Нанда Махаражийн захиран заасны дагуу Өөрийн суудлаа эзлэж, Түүний араас Кришнагийн ах Шри Баладевын хамт малчин жаалууд зэрэгцэн сууцгаана.

4. Тэднийг бүхэл бүтэн найр хүлээн байна: *шукта*, бүх төрлийн навчис, амтат шарсан хоол болон *жута* хэмээх ногоон навчаар хийсэн салат ярайх бөгөөд тэдний араас хулуу хийгээд жимстэй сагс, чечевиц ба өтгөрүүлсэн сүүгээр хийсэн

жигжигхэн дөрвөлжин бин бүхий сагснууд эгнэж, цаана нь хурган гуаны сүүнд битүү чанасан өтгөн тараг, гадилын модны цэцгээр хийсэн хоолнууд ирийнэ.

5. Дараа нь тэдэнд *мунг дал* болон *урад далаар* хийсэн шарсан дөрвөлжин хуушуур, *гхи* бүхий чапати, цагаан будаа, мөн сүү, элсэн чихэр, *кунжутаар* хийсэн элдэв амттанууд, цагаан будааны гурилаар хийсэн бин, өтгөрүүлсэн сүү, сүүнд чанаж болгосон хуушуур, амтат будаа зэргийг тараана.

6. Үүний дараагаар анхилуун үнэртний тусламжбайгаар амтат рашаан мэт болсон амтлаг будаа, гадилууд, гайхалтай амттай бяслаг тараан өгөх бөгөөд үүний дараагаар тамаринд болон лаймын үр(нимбэгний нэгэн төрөл, орч), нимбэг, амтат зүрж, гранат зэргээр хийсэн арван хоёр төрлийн исгэлэн хоол байна.

7. Энэхүү хоолнуудыг элсэн чихэртэй цагаан гурилаар хийсэн *пури*, хөөсрүүлсэн цөцгийтэй *пури*, амтлаг будаанд болгосон далаар хийсэн хуушуур, ладду зэрэг хоолнууд сэлгэнэ. Кришна нэн тааламжтайгаар энэ бүх хоол хүнсийг зооглоно.

8. Хэмжиж баршгүй онгод хөөрөл, баяр баясгалантайгаар Шримати Радхаранийн бэлдсэн будаа, карригаар амталсан ногоо, амттангууд, жигэнэмэгүүдийг зооглон байна.

9. Кришнагийн хөгжилтэй найз брахман Мадхумангала (“Бхакти-расамрита-синдху” өгүүлснээр, хооллох үед Мадхумангала бусад малчин жаалуудаас илүүтэй ихээр иддэг бөгөөд ялангуяа *ладдуг* ихээр иддэг гэжээ. Гэсэн хэдий ч тэрээр цадаж ханахгүй болохоороо Кришнад хандан: “Надад жаахан *ладду* өгчих, тэгвэл би баярлаж, Чиний найз Радхарани мөн Чамд сэтгэл хангалуун байх өөрийн адис ерөөлөө хайрлана шүү” гэдэг байв.) *ладдуд* маш дуртай нэгэн бөгөөд худал үнэн хэлж байгаад түүнийг гуйж гувшсаар авчихна. Түүнийгээ идэж байх үедээ тэрээр “Харибол!Харибол!” хэмээн хашгирч, суганыхаа доохонтой нуруугаа алгдан инээдтэй авиа гаргана.

10. Нүднийхээ булангаар Радхарани болон Түүний найз охид, *гопи* нарыг сэм харж, Кришна нэн их тааламжтайгаар Яшода ээжийн гэрт хооллоно.

11. Хооллосныхоо дараагаар Кришна сайхан үнэрт сарнайн усыг уух бөгөөд дараа нь бүх малчин жаалууд зэрэгцэн зогсоод амаа зайлцгаана.

12. Амаа зайлж, гараа угаачихаад өгүүлж барамгүй жаргалыг амталсан малчин жаалууд Бурхан Балараматай хамтаар амрахаар явцгаана.

13. Энэ үеэр Жамбула, Расала нэрт малчин жаалууд Кришнад олон янзын амтлагч, катеху(идээлэх ханд, орч), бетелийн самраар хийсэн *панг* авч ирж өгөх бөлгөө. *Паныг* амтлаад аз жаргалдаа умбасан Шри Кришначандра унтахаар явна.

14. Кришна тансаг ор хөнжилдөө амтат нойронд унтахаар хэвтэх үед Түүний албат Вишалакша Түүнийг тогосын өдөн дэвүүрээр сэвэх ажээ.

15. Яшода ээжийн гуйснаар Дхаништха *гопи* Кришнагийн тавган дахь хоолны үлдэгдлийг Шримати Радхараанид аваачиж өгнө. Тэрээр нэн тааламжтайгаар түүнийг зооглох ажээ.

16. Харин Лалита-деви болон өөр бусад *гопи* нар Түүний хоолны үлдэгдлийг хүртээд асар их баяр хөөртэйгээр өөрсдийн зүрхэнд Радхарани, Кришна нарыг магтан дуулсан дууг дуулна.

17. Бурхан Харигийн тоглоом наадам амьдралынх нь цорын ганц баяр баясгалан болсон Тхакур Бхактивинода энэхүү “Бхога-арати” нэрт дууг дуулан байна.

Гаура арати
 (“Гитавали”-гаас)

1

*жайа жайа горāчāндер āратико ѓобхā
жāхнавī-таṭа-ване жага-мана-лобхā*

(дахилт)

*гаурāнгер āратик ѓобхā
жага-жана-мана-лобхā*

2

*дакхиңе нитāичāнд, бāме гадāдхара
никаṭе адвайта, ѓринивāса чхатра-дхара*

3

*босийāчхе горāчāнд ратна-симхāсане
āрати корен брахмā-āди дева-гаңе*

4

*нарахари-āди кори' чāмара дхулāйя
сайжайя-мукунда-бāсу-гхои-āди гāйя*

5

*ѓанкха бāже гхаңṭа бāже бāже каратāла
мадхура мрданга бāже парама расāла*

(дахилт)

*ѓанкха бāже гхаңṭā бāже
мадхур мадхур мадхур бāже*

6

*баху-коти чандра жини' вадана ужжвала
гала-деѓе бана-мāлā коре жхаламала*

7

*ѓива-ѓука-нāрада преме гада-гада
бхакативинода декхе горāра сампада*

1. Бурхан Чайтаньягийн гайхамшигт *арати* ёслолын яруу алдар бадартугай, яруу алдар бадартугай. Энэхүү Гаура-арати нь Жахनावийн/Ганга/ эрэг дээрхи ой шугуйд болж буй агаад орчлонгийн бүхий л амьд оршнолуудын зүрх сэтгэлийг соронздон татмуй.

2. Бурхан Чайтаньягийн баруун талд Бурхан Нитьянанда зогсох бөгөөд зүүнтээ нь Шри Гададхара зогсон байх ажээ. Зэрэгцээд Шри Адвайта зогсож, харин Шриваса Тхакур, Чайтанья Бурханы толгой дээр шүхэр барин зогсох авай.

3. Үнэт эрдэнэсийн чулуудаар чимэглэсэн ширээн дээр Бурхан Чайтанья залрах ба Брахма Тэнгэрээр тэргүүлүүлсэн сахиулсан тэнгэрүүд *арати* ёслолыг үйлдэн байна.

4. Нарахари Саракара болон Бурхан Чайтаньягийн бусад дагуулууд Түүнийг *чамараар*/сарлагийн сүүлээр хийсэн дэвүүр, орч/ дэвүүрдэн байх агаад Санжая Пандит, Мукунда Датта, Васу Гхош тэргүүтэй чин бишрэлтэнгүүд аялгуут сайхан *киртаныг* хөтлөн дуулмуй.

5. Дунгийн эгшиг дуурьсаж, хонх, *каратал* хангинаж, *мридангийн* хэмнэлт цохилт сонсогдон байна. *Киртаны* аялгуу нь эгэлгүй тансаг амттай агаад түүнийг сонсогч бүхэнд аугаа их цэнгэл ташаалыг авчрах ажээ.

6. Сая сая сарны туяанаас ч илүүтэйгээр Бурхан Чайтаньягийн нигуур гэрэлтэн байх ба хүзүүнд нь зүүсэн ойн анхилуун цэцэгсийн хэлхээ нүд гялбам гэрэл туяаг сацруулан байна.

7. Энд Шива Тэнгэр, Шукадева Госвами, Нарада Муни нар байх агаад трансцендент онгод хөөрлийн улмаас тэдний хоолой чичирхийлэн байна. Ийнхүү Бхактивинода Тхакур, Бурхан Шри Чайтаньягийн аугаа байдлыг толидон харах бөлгөө.

Шри Нама-киртан

Ариун гэгээн нэрийг магтан дуулахуй
("Титавали"-гаас)

*йайоматй-нандана, браджа-баро-нāгара,
гокула-райджана кāна
гопй-парйāна-дхана, мадана-манохара,
кāлийа-дамана-видхāна*

2

*амала харинāм амийа-вилāсā
випина-пурандара, навйна нāгара-бора,
бамйи-бадана сувāсā*

3

*бража-жана-пāлана, асура-кула-нāймана,
нанда-годхана-рāкховāлā
говинда мādхава, наванйта-таскара,
сундара нанда-гопāлā*

4

*джāмуна-таṭа-чара, гопй-басана-хара,
рāса-расика, крпāмойа
йрй-рāдхā-валлабха, брндабана-наṭабара,
бхакативинод-āййрайа*

1. Каана нэрт Бурхан Кришна, Яшода ээжийн хайртай хүү нь билээ. Тэрээр, Вражийн трансцендент амраг хархүү бөгөөд Гокулын оршин суугчдын баяр баясгалан, *гопи* нарын амьдралынх нь гэрэл гэгээ ба дурлалын тэнгэр Купидоныг өөрийг нь дурлуулан татах увьдастай хийгээд аварга могой Калийг нэгэнтээ асар ихээр шийтгэж байлаа.

2. Бурхан Харигийн энэхүү ариун гэгээн алдар нэр нь бурханлаг тоглоом наадмын амтат балаар дүүрэн билээ. Вражийн арван хоёр ойн Эзэн Тэрээр байнгын залуугаараа мөнх орших амой. Түүнтэй дүйцэх амраг үгүй бөгөөд Тэрээр, тун ч эгэл бусаар хувцаслах билээ. Өөрийн салшгүй лимбэн дээрээ Тэрээр үргэлжид тоглон наадах бүлгээ.

3. Вражийн оршин суугчдын авран хамгаалагч, бурхангүй *асурын* удмыг устган дарагч Кришна бээр Нанда Махаражийн үхэр сүргийг хариулах бөгөөд газар дэлхий, үхэр болон бурханлаг мэдрэхүй зэрэгт хамаг л жаргалыг хайрлах бөлгөө.

4. Ямуна мөрний эрэг орчмоор Кришна, ямагт хэрэн зугаалж явах бөгөөд голын уснаа угаал үйлдэж байсан гоолиг бүсгүйчүүдийн хувцсыг хулгайлж байлаа. *Раса* бүжгийн амтанд мансууран согтох Кришна, Вража нутгийн шилдэг бүжигчин юмаа. Өршөөл хишиг нь өгөөмөр Тэрээр Өөрийг нь энхрий ялдмаар хайрлах Шри Радхын амраг билээ.

Бхактивинод Тхакур надад Түүнээс өөр баяр баясгалан Түүнээс ондоо өмөг түшиг үгүй.

Туми Сарвешварешвара («Шаранагати»-гаас)

1

туми сарвейиварейивара, бражендра-кумāра!

томāра иччхāйа бийве сржана самхāра

2

тава иччхā-мато брахмā корена сржана

тава иччхā-мато бишну корена пāлана

3

тава иччхā-мате йиива корена самхāра

тава иччхā-мате мāйй срже кārāгāра

4

тава иччхā-мате жйвер жанамā-мараṇа

самрддхи-нипāта дуккха сукха-самгхатāна

5

*мичхе маййā-баддха жйва айшā-пайе пхире’
тава иччхā бинā кичху корите нā пāре*

6

*туми то’ракхака ар пāлака амāра
томāра чараṇа бинā аййā нāхи ара*

7

*нижа-бала-чештā-прати бхарасā чхāрийā
томāра иччхāй айчи нирбхара корийā*

8

*бхакативинода ата дйна акинчана
томāра иччхāй тā’ра жйбана мараṇа*

1. Ай Вражийн хааны залуу хүү минь ээ, Та вээр Эзэн бүгдийн Эзэн нь билээ. Таны тааллаар л орчлонгийн бүтээл хийгээд усталт явагдмуй.
2. Таны тааллаар л Брахма Тэнгэр бүтээн бий болгож, Бурхан Вишну бүтээлийг тогтоон барьж байдаг билээ.
3. Таны таалалд захирагдан Шива Тэнгэр бүгдийг устган сөнөөх ба мөн Таны тушаалаар *майя* энэхүү ертөнц-шоронг бий болгодог билээ.
4. Таны тааллаар амьд бодгаль бүр төрөх хийгээд үхдэг бөгөөд мөн Таны тааллаар бидэнд амжилт, азгүйдэл, аз жаргал, уй гуниг ирдэг билээ.
5. *Майягийн* хальсанд наалдан, материаллаг хүслийн торонд орооцолдон өчүүхэн жижиг сүнс энэ ертөнц дээр ямар нэгэн зүйлд хүрэхийг чармайн тэмцэх авч түүний бүхий л оролдлого дэмий хоосон байдаг. Тэрээр Таны соёрхолгүйгээр юуг ч үйлдэж үл чадах билээ.
6. Та бол миний хамгаалагч, тэтгэгч. Надад Таны бадамлянхуан өлмийгөөс өөр ямар нэг өмөг түшиг найдвар үгүй билээ.
7. Одоо би өөрийн ямар нэг зүйлийг гүйцэтгэж чадах чадвар хийгээд, хүчин чадалд үл итгэх бөгөөд зөвхөн Таныхаар л болтугай хэмээн санадаг.
8. Бхактивинода нь бүхий л азгүйчүүд дотроос хамгийн азгүй нь бөгөөд түүний бардам зангаас юу ч үлдээгүй билээ. Одоо тэрээр өөрийн амьдрал хийгээд үхлээ ганцхан Танд л найдан даатгамуй.

Охе! Вайшнава Тхакура
(«Шаранагати»-гаас)

1

охе!

ваишṇаба тхāкура, дойāра сāгара,

э дāсе корунā кори'
дийā пада-чхайā, йодхо хе āмайā,
томāра чараᅇа дхори

2

чхайа бега доми', чхайа доша йодхи',
чхайа гуᅇа дехо' дāсе
чхайа сат-санга, дехо' хе āмāре,
босхечхи сангера айе

3

экакй āмāра, нāхи пāйа бала,
хари-нāма-санкйртане
туми крпā кори', йраддхā-бинду-дийā,
дехо' криᅇа-нāма-дхане

4

криᅇа се томāра, криᅇа дите пāро,
томāра йакати āчхе
āми то' кангāла, 'криᅇа' 'криᅇа' боли',
дхāи тава пāчхе пāчхе

1. Ай Вайшнава Тхакур! Ай адис өршөөлийн далай минь ээ, өөрийн тань албат намайг өрөвдөн хайрлаач, таны бадамлянхуан өлмийн нөмрийг надад хайрлаж бүх бохир бузар болгоноос намайг ариусгаж хайрла. Би хүлцэнгүйгээр таны өлмийг барьж байя.

2. Намайг зургаан төрлийн дутагдлаас ангижруулж, миний зургаан янзын сэрэл хөөрлийг тогтоон хазаарлаж өөрийн тань албатад зургаан төрлийн сайн чанар хайрлаач. Ай мөн надад зургаан төрлийн ариун гэгээн харьцааг илгээгээч. (Зургаан төрлийн дутагдалд: хэтэрхий их идэх буюу шаардлагатай хэмжээнээс илүүтэйгээр мөнгө хурааж хуримтлуулах, материаллаг зорилгод хүрэхийн тулд хэт их хүчин чармайлт гаргах, материаллаг үйл ажлын тухай дэмий хоосон зүйл ярих, шастирт өгүүлсэн дэг жаяг, дүрэм журамд хэт ихээр уягдан татагдах эсвэл үндэслэлгүйгээр түүнийг үл хэрэгсэх, бурханлаг сонирхол үгүй хүмүүстэй харьцах, материаллаг амжилтанд хүрэхийг улайран хүсэх

Зургаан төрлийн сэрэл хөөрөл нь ухааны, хэлний, ходоодны, бэлэг эрхтний шавдалт шаардлагууд болон уур хилэн, дэмий ярих хүсэл

Зургаан төрлийн сайн чанар нь энтузиазм буюу урам зориг, тэвчээр, итгэл, чин бишрэлийн алба зүтгэлд таатай аливаа зүйлийг хийх хатуу шийдвэр, чин бишрэлтэн бусчуудтай харьцахаас татгалзах, өмнө үеийн *ачарья* нарын замаар үргэлжид замнахыг эрмэлзэх

Зургаан төрлийн бурханлаг харьцаа нь чин бишрэлтэнгүүд нь бэлэг өгөх болон хүлээн авах, өөрсдийн нарийн нандин үзэл бодлоо хуваалцах, чин бишрэлийн алба зүтгэлтэй холбоотой асуултуудын итгэл үнэмшилтэйгээр асуух, бусдыг бурханлаг хоол хүнсээр дайлах болон чин

бишрэлтний дайллага цайллаганд оролцох) Найдвар горьдлогод дүүрэн автаж би тантай харьцах тэр л цаг мөчийг хүлээмүй.

3. Надад Бурхан Харигийн ариун нэрийг дуулах хүч үгүй бөгөөд ийм ч учраас танаас өршөөл адисыг хүсэн гуйя: надад үнэлж баршгүй үнэт эрдэнэ болсон Кришнагийн ариун нэрийг өчүүхэн жаахан итгэлийн хамт хайрлаач.

4. Танд Кришна байна. Түүнийг надад өгөх эрх мөн Танд байна. Үнэндээ бол би өрөвдөлтэй хөөрхийлөлтэй амьтан бөгөөд “Кришна! Кришна!” хэмээн дуудаж зүгээр л таныг даган гүйе.

Вибхавари Шеша
(“Кальяна-калпатару”-гаас)

1

*вибхāварī йеша, āлока-правеиша,
нидрā чхāри’ утхо жйива
боло хари хари, мукунда мурāри,
рāма кршина хайагрйива*

2

*нрсимха вāмана, йрй-мадхусудана,
бражендра-нандана йийāма
пўтанā-гхātана, каиṭабха-ийātана,
жāйа дāййāратхи-рāма*

3

*йаййодā дулāла, говинда-гопāла,
врндāвана пурандара
гопй-прийа-жана, рāдхикā-рамаṇа,
бхувана-сундара-бара*

4

*рāвāñāнтакар, мāкхана-таскара,
гопй-жана-вастра-хāрй
бражера рāкхāла, гопа-врнда-пāла,
читта-хāрй бамйй-дхāрй*

5

*йогйндра-бандана, йрй-нанда-нандана,
бража-жана-бхайа-хāрй*

*навйна нїрада, рўпа манохара,
мохана-бамїї-бихārī*

6

*йайодā-нандана, камса-нисудана,
никуñжа-рāса-вилāсї
кадамба-кāнана, рāса-парāйаᅇа,
брнда-випинна-нивāсї*

7

*āнанда-вардхана, према-никетана,
пхула-їмара-жожжака-кāма
гопāнганā-гаᅇа, читта-винодана,
самаста-гуᅇа-гаᅇа-дхāма*

8

*жāмуна-жївана, кели-парāйаᅇа,
мāнаса-чандра-чакора
нāма-судхā-раса, гāо криᅇа-жаїа,
рāкхо вачана мана мора*

1. Үдшийн харанхуй өнгөрч, үүрийн гэгээ туслаа. Сүнснүүдээ(жива)сэрцгээгтүн, нойроо орхигтун. Ангижралыг хайрлагч Бурхан Харигийн ариун гэгээн нэрийг магтан дуулагтун. Тэрээр дээд цэнгэл эдлэгч хийгээд бүгдийг Өөртөө соронздон татмуй. Тэрээр Мура шулмын дайсан, морь тэргүүнт Бурханы хувилгаан Хаягрива билээ.

2. Мадху шулмыг дарагч Бурхан Хари/Кришна/ нь хүн-арслан дүрт Нрисимха дүрээр заларсан бөгөөд мөн Упендра нэрт одой-брахманы дүрээр ч заларч байлаа. Тэрээр Нанда Махаражийн хайртай хүү бөгөөд арьсных нь өнгө хар бараан билээ. Тэрээр Путана шулмыг устгаж, мөн Кайтабху чөтгөрийг дарсан билээ. Дашаратхын хааны хүү Бурхан Рама болон илрэн заларсан Бурхан Харигийн алдар бадартугай.

3. Тэрээр Яшода ээжийн хайртай хүү бөгөөд газар дэлхий, үхэр, бурханлаг мэдрэхүйд цэнгэл жаргалыг хайрламуй. Мөн тэрээр үнээдийг хамгаалагч, Вриндаваны ойн Эзэн нь билээ. Тэрээр Радхикагийн дурлалт хархүү бөгөөд *гопи* нарт нэн эрхэм. Бүхий ертөнц даяар Түүнээс үзэсгэлэнтэй нь үгүй билээ.

4. Рамачандра дүрээр залрахдаа Тэрээр чөтгөрийн хаан Раванаг устган дарж, Кришна дүрээр залрахдаа настай *гопи* нарын цөцгийг хулгайлж, Ямуна мөрний уснаа угаал үйлдэж байсан залуухан *гопи* нарын хувцсыг нуун тоглодог байв. Тэрээр Вражийн малчин байсан бөгөөд бусад малчдынхаа хамгаалагч нь байлаа.

Мөн тэрээр зүрх сэтгэлийг булаан хулгайлагч хийгээд Өөрийн лимбэнээс хэзээд үл салах билээ.

5. Бурхан Кришна нь Нанда Махаражийн хайртай хүү бөгөөд Түүнд *йогчдын* аль шилдэг нь мөргөн залбирдаг билээ. Тэрээр Вражийн суугчдын зүрхнээс айдас хүйдсийг нь үлдэн хөөх бөгөөд биеийнх нь өнгө дөнгөж бүрэлдэн бий болж буй аадрын үүл мэт юм. Тэрээр бүгдийг Өөрийн гоо үзэсгэлэнгээрээ соронздон татмуй.

6. Тэрээр Яшодын хайртай хүү бөгөөд Камса хааныг устган дарагч билээ. Тэрээр Вриндаваны ой дунд тоглон, *кадамба* модны доор бүжиглэн наадаж, Вражийн шугуйд *раса* бүжгээр цэнгэн жаргамуй.

7. Тэрээр Өөрийн чин бишрэлтэнгүүдийн онгод хөөрлийг улам улмаа нэмэгдүүлэн байдаг. Мөн Тэрээр хайр дурлалын эх булаг хийгээд тэдний хайрын дур хүслийг бадраахын тулд цэцгэн сумаар *гопи* нарыг шидэлж асан трансцендент Купидон билээ.

8. Бурхан Кришна нь Ямуна мөрний амь сүнс нь хийгээд хайр дурлалын тоглоом надгайд үргэлжид автан байх агаад зөвхөн сарны гэрлийг унд хоолоо болгодог *чакора* шувуу мэт *гопи* нарын ухаан бодлынх нь саран билээ. Ай ухаан минь ээ, миний үгийг хүлээн аваад энэхүү рашаан мэт амтаар дүүрэн ариун гэгээн нэрсийг дуулан Шри Кришнаг магтан алдаршуулагтун.

Видьяра виласе («Шаранагати»-гаас)

1

*видйāра вилāсе, кātāину кāла,
парама сāхасе āми
томāра чараṇа, нā бхажину кабху,
экхона йāраṇа туми*

2

*порите порите, бхарасā бāрило,
жñāне гати хабе мāни'
се āшā бипхала, се жñāна дурбала,
се жñāна ажñāна жāни*

3

*жаḍа-видйā жато, мāйāра ваибхава,
томāра бхажане бāдхā
моха жанамийā, анитийā сомсāре,
жйбаке карайе гāдхā*

4

*сеи гāдхā хо 'ие, самсāрера божхā,
бахину анека кāла
бāрдхакйе эххано, йактира абхāве,
кичху нāхи лāге бхāло*

5

*жйвана жāтанā, хоило эххано,
се видйā авидйā бхело
авидйāра жвāлā, гхатило бишама,
се видйā хоило йело*

6

*томāра чарана, бинā кичху дхана,
сомсāре нā āчхе āра
бхакативинода, жада-бидйā чхāрй',
тувā пада коре сāра*

1. Өөртөө гүнээ итгэн би зөвхөн материаллаг эрдэм мэдлэгээр олж авсан тэр бүхнээр оролдож, үүнээсээ асар их цэнгэлийг амтлан байдаг билээ. Би Таны бадамлянхуан өлмийд мөргөн залбирч байгаагүй авч энэ цаг мөчөөс эхлэн Та миний цорын ганц өмөг түшиг боллоо.

2. Би асар их зүйлийг уншаад л уншаад л байсан бөгөөд миний найдвар горьдлого өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж байсан юм. Учир нь материаллаг мэдлэгийг хуримтлуулахыг жинхэнэ зам мөр хэмээн би боддог байлаа. Гэвч миний найдвар горьдлого нуран уналаа; миний энэ бүх мэдлэг чухамдаа юу ч биш юм гэдгийг би ойлгосон юм. Харин одоо би энэ мэдлэг нь мунхаг харанхуйн үндэс болохыг тов тодорхой харж байна.

3. Ертөнцийн эгэл мэдлэг нь Бурханы хуурмаг эрч хүчний/*майа*/ илрэлээс өөр юу ч биш бөгөөд тэрээр Танд үйлчлэхүйд саад болдог гол зүйл юм. Энэ мэдлэг нь мөнхийн сүнсийг илжиг болгон хувиргадаг ба учир нь тэр мэдлэг нь энэхүү цаг зуурын ертөнцөд гүн батаар уягдах татагдал уягдлыг бий болгодог.

4. Материаллаг ахуйн ачааг нуруун дэрээ мөн ч олон жил тээсэн олон олон илжигүүдийн нэг би билээ. Одоо би хэдийнээ өтөлж хөгширсөн бөгөөд надад цэнгэн жаргах хүч чадал үгүй хийгээд надад юу ч баяр хөөрийг авч ирэхгүй боллоо.

5. Миний амьдрал тэвчиж баршгүй зовлон болон хувирсан бөгөөд мэдлэг маань мэдлэг биш болон хуврсан агаад намайг мунхагийн харанхуйн энэхүү гал тэвчиж боломгүйгээр шарах бүлгээ. Миний олж авсан ертөнцийн эгэл мэдлэг нь одоо харин хурц сум мэт санагдмуй.

6. Ай Бурхан минь ээ, Таны бадамлянхуан өлмийгөөс өөр үнэт эрдэнэ үгүй билээ. Бүхий л ертөнцийн эгэл мэдлэгийг холын холд шидэж орхиод Бхактивинода Таны бадамлянхуан өлмийг амьдралынхаа утга учраа болгож байна.

**Шрила Нароттама
даса Тхакурын дуунууд**

ЗУРАГ /Нароттам/

Вайшнаве вигьяпти

Вайшнавт өргөх залбирал
("Партхан"-аас)

1

*эи-бāро карунā коро ваишнāва госāи
патита-пāвана томā бине кехо нāи*

2

*жāхāра никатe геле пāпа дūре жāй
эмона дойāла прабху кебā котхā пāй*

3

*гаṅgāра парāйā хоиле пāйчāте пāван
дарīане павитра коро – эи томāра гуṅ*

4

*хари-стхāне апарāдхе тāре хари-нāм
томā стхāне апāрадхе нāхи паритрāṅ*

5

*томāра хрдойе садā говинда-виīрāм
говинда кохена-мора ваишнāва парāṅ*

6

*прати-жанме кори аййā чаранера дхӯли
нароттаме коро дойā āпанāра боли’*

1. Ай вайшнав-госвами танаас сөгдөн гуйя, надад өршөөл адислалаа хандуулаач. Танаас өөр унан доройтсон сүнснүүдийг ариусган цэвэрлэх хэн ч үгүй билээ.

2. Тантай ганц удаа уулзах нь бүхий л нүгэл хилэнцийг арилган зайлуулдаг тул өөр хаанаас ч гэлээ тан шиг ийм өгөөмөр бодгалийг олж чадна гэж үү ?

3. Ариун Гангын усаар ариусан цэвэршихийн тулд хүмүүн түүний усанд олонтоо угаал үйлдэх ёстой. Харин гэтэл таныг унан доройтсон сүнснүүд дөнгөж хармагц л ариусан цэвэршдэг тийм л аугаа хүчирхэг билээ та.

4. Бурхан Харид алдас доромжлолыг учруулсан хэнийг ч ариун гэгээн нэр авардаг байхад харин таныг гутаан доромжилвол тэр хүмүүнд ямар ч аврал үгүй билээ.

5. Таны зүрхэнд үргэлжид Бурхан Говинда тухлан байдаг хийгээд үүний хамт Бурхан Говинда: “Вайшnavууд Миний зүрхэнд оршмуй” хэмээн өгүүлнэм билээ.

6. Дараа дараагийн амьдралдаа хичнээн удаа төрсөн ч би зөвхөн таны бадамлянхуан өлмийн тоосоор өөрийн биеэ цацан түрхэхийг хүсүү. Нароттама таны мэдлийнх гэдгийг мэдтүгэй; Та түүнд өршөөл энэрлээ хайрлана уу.

Ишта-деве вигьяпти
Хайртай Бурхандаа өргөх залбирал
(“Прартхана”-гаас)

1

*хари хари! бипхале жанаме гонāину
манушйа-жанаме пāийā рāдхā- кришнā нā бхажийā,
жāнийā йунийā биша кхāину*

2

*голокера према-дхана, хари-нāма-санкйртана,
рати нā жанмило кене тāй
самсāра-бишйāнале, дибā-ниийи хийā жвале,
журāите нā коину упāй*

3

*бражендра-нандана жеи, йачй-сута хоило сеи,
баларāма хоило нитāи
дйна-хйна жата чхило, хари-нāме уддхāрило,
тāра йāкшй жажāи мāдхāи*

4

хā хā прабху нанда-сута, вршабхāну-сутā-жута,

*коруна карохо эи-баро
нароттама-даса кой, на тхелихо ранга пай,
томā бине ке ачхе амара*

1. Ай Бурхан Хари минь ээ, амьдрал маань утга учиргүй дэмий хоосон өнгөрч, бүхий л амьдралынхаа туршид би санаатайгаар хор ууж байжээ. Учир нь би хүн болж төрчихөөд Радха-Кришнад мөргөж байсангүй.

2. Голока Вриндаваны бурханлаг хайрын үнэт эрдэнэ нь Бурхан Харигийн ариун нэрийг хамтаар магтан дуулах хэлбэрээр Дэлхий дээр буун заларсан билээ. Гэтэл яагаад энэхүү дуулал намайг үл татна вэ? Өдөр шөнөгүй ертөнцийн хий хуурмагийн хор зүрхийг минь түлэх бөгөөд харин би энэхүү зовлон шаналалаас ангижрах сайхан боломжийг ашигласангүй.

3. Вражийн хааны хүү Бурхан Кришна нь Шачийн хүү(Бурхан Чайтанья) болон заларсан агаад, харин Баларама Нитай болон заларсан билээ. Бурханы ариун гэгээн нэр нь нүгэлт Жагай, Мадхай гэх мэт бүхий л унан доройтсон, азгүй сүнснүүдийг аврах бүлгээ.

4. Вришабханугийн охины дэргэд үргэлж хамт байх ай Бурхан Кришна, ай Нандын хүү минь ээ, надад өршөөл энэрлээ хандуулаач. “Ай Бурхан минь ээ, намайг Өөрийн тань улаан туяат бадамлянхуан өлмийн дэргэдээс бүү хөөн туугаач. Учир нь би Танаас өөр хэнийг ч үл хайрлах билээ” хэмээн Нароттама дас өгүүлэн байна.

Лаласамайи прартхана ("Прартхана"-гаас)

1

*'гаурāнга'болите хабе пулака-йарйра
'хари хари' болите найане ба 'бе нйра*

2

*āра кабе нитāи-чāндер коруна хоибе
самсāра-бāсанā мора кабе тучча ха 'бе*

3

*вишайа чхāрийā кабе йуддха ха 'бе мана
кабе хāма херабо йрй-брндāбана*

4

*рyпа-рагхунāтха-паде хоибе āкути
кабе хāма бужхабо се жугала-пйрити*

5

рӯпа-рагхунātха-наде раху мора айиа
п̄р̄артханā коройе садā нароттама-дāса

Бурханы Адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын
тайлбар

Энэхүү дууны зохиогч нь Бурхан Чайтаньягаас эхлэлтэй багш шавийн хэлхээнд хамаарах Гаудия-вайшнав *сампрадаигийн ачарья*, аугаа чин бишрэлтэн Нароттама дас Тхакур юм. Нароттама дас Тхакур бүх вайшnavуудад хүлээн зөвшөөрөгдсөн маш олон дуу бичсэн ба тэрээр дуунуудаа ердийн бенгали хэл дээр бичдэг боловч эдгээр дуунуудад агуулагдах гүн гүнзгийн утга санааныхаа үрээр тэд маш их үнэ цэнийг олсон юм.

Энэ дуундаа тэрээр: *‘гаурāнга’болите хабе пулака-йарйра* хэмээн өгүүлжээ. Хэрэв хүн *санкиртан* хөдөлгөөний үндсийг тавигч Бурхан Гаурангийн нэрийг дөнгөж уншмагц бие нь чичирхийлэн дагжиж байвал тэрээр ариун нэрийг давтан дуудах үйлийн төгс төгөлдөрт хүрчээ гэсэн үг. Энэ байдлыг дууриаж хэрэггүй хэдий ч Нароттама дас Тхакур: “Би Бурхан Гаурангийн нэрийг дуулж эхэлмэгц миний бүх бие чичирхийлэн дагжих тэр азтай цаг мөч хир хурдан ирэхсэн бол?” хэмээн асууж байна. Энэ чичирхийлэл илрэх үед, - *‘хари хари’ болите найане ба’бе нйра*: “Харе Кришна *мантраг* дуулах үед хоёр нүднээс минь нулимсан цутгал асгармуй”.

Дараа нь тэрээр: *“āра кабе нитāи-чāндер корунā хоибе”* хэмээн өгүүлжээ. Бид бүгдээрээ Бурхан Нитьянандаас адис өршөөлөө хайрлахыг гуйн залбирдаг. Нитьянанда анхдагч номын багш хэмээн тооцдог ба ийм ч учраас Гаурангад ойртон дөхөхийн тулд эхлээд Бурхан Нитьянандын өршөөлийг хүртэх хэрэгтэй. Харин Бурхан Нитьянандын учир шалтгаангүй өршөөлийг хүртсэн хүнийг хэрхэн таних вэ? Нароттама дас Тхакурын өгүүлж буйгаар, Бурхан Нитьянандын өршөөлийг хүртсэн хүн нь материаллаг хүсэл нь бүрэн үгүй болсон байдаг. *āра кабе нитāи-чāндер корунā хоибе самсāра-бāсанā мора кабе туччха ха’бе. самсāра-бāсанā* гэдэг нь “материаллаг цэнгэлийг тэсч ядан хүсэх” гэсэн утгатай ба Нароттама дас өөртөө: хэзээ энэ тэсч ядсан хүсэл үгүй болох вэ? хэмээн асууж байна. Ерөнхийдөө бид бие махбодид оршин буй цагт өөрсдийн олон тооны материаллаг хэрэгцээг хангах хэрэгтэй болдог ч үүнийг харин цэнгэл эдлэхийн тулд бус харин өөрийн ахуйг тогтоон барьж байхын тулд л гүйцэтгэх хэрэгтэй.

Цааш нь Нароттама дас өгүүлэхдээ: *рӯпа-рагхунātха-наде хоибе āкути* – “надад зургаан Госвामीн бичсэн ном судрыг судлах тэсч ядсан хүсэл хэзээ бий болох вэ?” хэмээн өгүүлжээ. *āкути нь* “хүчтэй тэмүүлэл” гэсэн утгатай. Чин бишрэл зүтгэлийн загалмайлан эцэг Рупа Госвами нь чин бишрэл зүтгэлийн тухай өгүүлсэн гайхамшигтай сургаал, дүрэм журмуудыг агуулсан “Бхакти-расамрита-синдху” номыг бичсэн юм. Энэхүү асуудлуудыг “Чайтанья-чаритамрита” болон бусад ном судруудад тусгайлан авч үзсэн буй. Энэхүү сургаал захиасуудын товч агуулга бидний “Бурхан Чайтаньягийн сургаал” номонд агуулагдаж байгаа. Радха-Кришнагийн хайр сэтгэлийн холбоо харьцааг ойлгохын тулд зургаан Госвामीн

сургаал зааврыг даган баримтлах хэрэгтэй. Нароттама дас Тхакур Радха-Кришнагийн хайр сэтгэлийн харьцааг өөрийн ухааны хүчин чадалд найдан өөрсдөө ойлгон танихыг бидэнд зөвлөөгүй. Энэхүү *жугала-пйрити* буюу ханийн хайр сэтгэлийг зөвхөн зургаан Госвамийн сургаалыг удирдлага болгосноор ойлгож чадна.

Хүний ухаан материаллаг санаа бодлоор дүүрэн байсан цагт тэрээр Вриндаваны хаант улсад нэвтрэн орж чадахгүй хэдий ч Нароттама дас Тхакурын өгүүлснээр: *вишайа чхāрийā кабе йуддха ха'бе мана кабе хāма херабо йрй-брндāбана* – “миний ухаан бүрнээ ариусч, материаллаг түгшүүр хийгээд хүслээсээ ангижирсан цагт би Вриндаван болон Радха-Кришнын хайр сэтгэлийн харьцааг танин ойлгож чадна. Тэр цагт л миний бурханлаг амьдрал амжилтынхаа оргилд хүрэх болно” гэжээ.

Нама-санкиртана

1

*хари харайе намах кришна йāдавāйа намах
йāдавāйа мādхавāйа намах кейшавāйа намах*

2

*гопāла говинда рāма йрй-мадхусūdана
гиридхāрй гопйнāтха мадана-мохана*

3

*йрй-чаитанйа-нитйāнанда йрй-адваита-сйтā
хари гуру вашинаба бхāгавата гйтā*

4

*йрй-рūпа санāтана бхаттā-рагхунāтх
йрй-джйва гопāла-бхаттā дāса-рагхунāтх*

5

*эи чхаи госāир кори чараṇа вандан
джāхā хоите бигхна-нāйй абхйишṭа-пūраṇ*

6

*эи чхай госāи джāр-муи тāр дāс
тā-сабāра пада-реṇу мора пайча-грāс*

7

*тāдера чараṇа-себи-бхакта-сане бāс
джанаме жанаме хой эи абхилāи*

8

эи чхай госāи жабе браже коилā бāс

рāдхā-кршнā-нитйā-лīлā корилā пракīйī

9

*āнанде боло хари бхажа брндāбан
īрī-гуру-вашиңаба-паде мажсīйī ман*

10

*īрī-гуру-вашиңаба-пāда-падма кори āйī
нāма-санкīртана кохе нароттама дās*

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын тайлбар

Энэхүү дууг Шрила Нароттама дас Тхакур бичсэн бөгөөд Бенгали болон Ориссын чин бишрэлтэнгүүдийн дунд маш их нэрд гарсан дуу юм. Чайтанья Бурхан Гаи мужид Шри Ишвара Пуригээс бурханлаг сахил хүртээд буцан ирснийх нь дараагаар шавь нар нь Түүнд урьдны дүрмийн багшийн дүр төрхөөс юу ч үлдээгүйг мэдэв. Учир нь Тэрээр Бурханыг хайрлах хайранд согтон мансуурсан, түүнд бүрнээ автсан нэгэн болж хувирсан байлаа. Ердийнх шигээ дүрэм зүйн талаар тайлбарлахын оронд Чайтанья Бурхан өгүүлбэрийг задлан шинжилж санскрит үг, үсэг болгоныг Дээд Бурханы Бодгаль, Кришнатай холбон тайлбарлаж байв. Энэхүү дүрмийн задлан шинжилгээний арга нь Шрила Жива Госвамиин “Хари-намамрита-вйакаран”(“Шри Харигийн рашааны амтат ариун гэгээн нэрийн дүрэм”) номонд цаашдын хөгжлөө олсон юм. Гэвч Чайтанья Бурханы шавь нар багшийнхаа ухаан санаа самуурсан хэмээн бодоцгоож, Түүнийг эмчлэхийг чармайн, ухаан санааны эмгэгийг анагаах Вишнугийн тос бальзамыг толгойд нь түрхэж өгч байлаа. Эцэст нь тэд Түүнээс асуусан нь: “Та, бүх зүйлс бол Кришна хийгээд бидний цорын ганц хийх ёстой зүйл бол Түүний ариун нэрийг давтан унших хэмээн батлаж байна. Тэгээд үүнийг хэрхэн яаж хийх болж байна?”. Энэ асуултын хариу болгож Чайтанья Бурхан алгаа ташин Кришнагийн ариун нэрийг шууд дуулж эхэлсэн байна. Ийнхүү Тэрээр *нама-санкиртан* хөдөлгөөний эхлэлийг тависан байдаг. Бурхан Чайтаньягийн дуулж байсан ариун нэрүүд энэхүү дууны эхний хоёр мөрөнд агуулагдаж байгаа билээ. Нароттама дас болон бусад *ачарья* номын багштанууд эдгээр нэрсийг, үйл явдлыг хадгалан үлдээхийн тулд өөрсдийн зохиол бүтээлийн эхэн хэсэгт дурьдсан байдаг.

Дараа нь Нароттама дас Тхакур Бурхан Чайтанья хийгээд Нитьянанда, Шри Адвайта болон Сита(Адвайта ачарийн эхнэр) нарын ариун нэрийг магтан дуулсан байна. Бурхан Хари, номын багш, “Шримад Бхагавад гита” нар нь трансцендент түвшинд оршдог бөгөөд иймээс тэдэнд адилхан хүндэтгэл бишрэлийг үзүүлдэг. Үүний дараагаар Шрила Нароттама зургаан Госвамиин нэрийг давтан дуудсан байна. “Би вээр тэдний өлмийн өмнө бишрэл хүндэтгэлээ илэрхийлмүү, хэмээн дуулаад, учир нь тэдний ариун өлмий хүн төрөлхтнийг олон олон жилийн туршид шаналган зовоосон зовлон зүдгүүрээс нь ангижруулах чадалтай билээ. Би бол энэ зургаан Госвамиин зарц албат агаад тэдний бадамлянхуан өлмийн тоос миний хувьд таван төрлийн хоол зууш болмуй. Миний цор ганц хүсэх зүйл гэвээс нэг төрлөөс нөгөө төрөлд тэдний бадамлянхуан өлмийд үйлчлэн байж, чин

бишрэлтнүүдийн хүрээллийг хэзээ ч орхин одохгүй байх билээ”. Зургаан Госвами Вриндаванд амьдран ахуйдаа Шри Шри Радха-Кришнагийн мөнхийн трансцендент тоглоом наадмыг дүрслэн өгүүлсэн байдаг. Бурхан Чайтаньяг дэлхийд залран ирэхээс урьд Бурхан Кришнагийн тоглоом наадам өрнөж байсан жинхэнэ газар тодорхой бус байсан юм. Иймээс Бурхан Чайтанья эдгээр зургаан Госвамид энэхүү ариун газар нутгуудыг олон тогтоож, тэнд сүм барин босгохыг захин даалгасан билээ. *Раса* бүжиг болж өнгөрсөн тэр газрын ойролцоо Шри Радха-Дамодарын сүмийг барьж босгосон ба Шрила Рупа Госвами тэргүүтэй зургаан Госвами маань тэнд байнга хуран цуглаж, Шри Шри Радха-Кришнагийн гайхамшигтай тоглоом наадмыг эрдэм мэдлэг талаас нь тайлбарласан зохиол бүтээлүүдийн сэдвээр хэлэлцэн ярилцдаг байжээ. Нароттама дас Тхакур: “Жинхэнэ номын багш хийгээд чин бишрэлтэнд үйлчлэн зүтгэхэд өөрийгөө даатгаад, асар их онгод хөөрөлтэйгээр Харигийн ариун нэрийг чангаар дуулагтун” хэмээн бүгдийг уриалан дуудсан байна. Дууныхаа төгсгөлд тэрээр: “Гуругийн бадамлянхуан өлмийн болон ариун гэгээн вайшнавуудын өршөөл хишигт найдан Нароттама дас Харе Кришна Харе Кришна Кришна Кришна Харе Харе Харе Рама Харе Рама Рама Рама Харе Харе хэмээн Бурхан Харигийн *санкританыг* дуулан магтаж байна ” гэжээ.

Сакхи-вринде вигьяпти
Сакхи нарт хандсан залбирал
(“Прартхана”-гаас)

1

*рāдхā-кришнā прāнā мора жугала-кишора
жйване мараңе гати āро нāхи мора*

2

*кāлиндйā кўле кели-кадамбера вана
ратана-бедйā упара босāбо ду’жана*

3

*ийāма-гаурй-анге дибо(чўвā) чанданера гандха
чāмара дхулāбо кабе хери мукха-чандра*

4

*гāтхийā мāлатйр мāлā дибо дохāра гале
адхаре тулийā дибо карпўра-тāмбўле*

5

*лалитā виийāкхā-āди жата сакхй-брнда
āжнāйā корибо себā чараңāравинда*

1. Бурханлаг хос, Шри Радха-Кришна нь миний амьдралын гэрэл гэгээ билээ. Би урт удаан насална уу эсвэл одоо яг үхлийн ирмэг дээр байх зэргээс үл хамаарч надад Тэднээс өөр ямар нэг өмөг түшиг үгүй билээ.

2. Ямуна мөрний эрэг дэхь *кадамба* модон ойд би бурханлаг хосыг гэрэл цацарсан үнэт эрдэнийн чулуудаар үйлдсэн ширээн дээр залан суулгамуй.

3. Би Тэдний хар бараан хийгээд алтлаг цайвар биесийг *чуин* үнэр анхилсан зандан модны өтгөрүүлсэн тосоор арчин тосолж Тэднийг *чамараар* сэвүүрдэх болно. Ай хөөрхий хэзээ би Тэднийхээ саран мэт гэрэлт нигуурыг толидон харахсан бэ?

4. Би Тэдний хүзүүнд *малати* цэцгийн хэлхээ зүүн өгч, камфарын анхилам үнэр оруулсан *тамбулыг* Тэдний бадамлянхуан ам юунд нь өргөн баруюу.

5. Лалита, Вишакхаар ахлуулсан бүхий л *сакхи* нарын зөвшөөрөлтэйгээр би Радха-Кришнагийн бадамлянхуад өлмийд үйлчлэн зүтгэх болно.

6. Шри Кришна Чайтанья Прабхугийн албатын албат болсон Нароттама дас бурханлаг хос танаа энэхүү үйлчлэлээрээ үйлчлэн зүтгэхийг тэсч ядан хүснэ.

Сапаршада-бхагавата-вираха-жанита-вилапа

Бурхан болон Түүний дагалдагч нараас хагацан салж уйлахуй

(“Прартхана”-гаас)

1

*же āнило према-дхана коруңā прачур
хено прабху котхā гелā āчāрйа-тхāкур*

2

*кāхā мора сварūп рўпа кāхā санāтан
кāхā дāса рагхунāтха патита пāван*

3

*кāхā мора бхаттā-жуга кāхā кавирāж
эка-кāле котхā гелā горā натā-рāж*

4

*пāшāне кутибо мātхā анале пāйибо
гаурāнга гуңера нидхи котхā геле пāбо*

5

*се-саба сангйра санге же коило билās
се-санга нā пāийā кāнде нароттама дās*

1. Өршөөл, энэрлээр дүүрэн тэрээр бидэнд энэхүү үнэт эрдэнэ болсон бурханлаг хайрыг хайрласан билээ, -Шриниваса Ачарья та хаашаа одоо вэ?

2. Миний Сварупа Дамодара, Рупа Госвами нар хаана байна ? Санатана хаана байна ? Унан доройтсон сүнснүүдийг аврагч Рагхунатха дас маань хаачив?

3. Хаана байна, миний Рагхунатха Бхатта, Гопал Бхатта нар ? Хаана байна, Кришнадас Кавиража? Хаашаа одчихов гэнэт, аугаа бүжигчин Бурхан Гауранга?

4. Би толгойгоо чулуугаар хага цохичихоод, ус руу үсрэх минь! Бүхий л гайхамшигт чанарын хувилгаан болсон Бурхан Гаурангаг би хаанаас олох вэ?

5. Эдгээр бүх чин бишрэлтэнгүүдийн дунд тоглоом наадмаа өрнүүлэн байх, тэднийг бүгдээр нь хүрээлүүлэн явах Бурхан Гаурангад ойртон дөхөж үл чадах Нароттама дас зүгээр л уйлан уйлсаар байна.

*Саварана-шри-гаура-махима
Шри Гаурангийн алдар бадартугай
("Партхана"-гаас)*

1

гаурāнгера дутти пада, жās дхана сампада, се жāне бхакати-раса-сār

гаурāнгера мадхура-лйлā, жās карҗе правейиллā,

хрдойа нирмала бхело тār

2

же гаурāнгера нāма лой, тārа хой премодой,

тāре муи жāи болихārи

гаурāнга-гуҗете жхуре, нитйа-лйлā тārе спхуре,

се жана бхакати-адхикārй

3

гаурāнгера санги-гаҗе, нитйа-сиддха кори'мāне,

се жāй бражендра-сута-пāйй

йрй-гауда-мандала-бхūми, жебā жāне чинтāмāни

тārа хой бража-бхūме бās

4

гаура-према-расārҗаве, се таранге жебā дубе,

се рāдхā-мāдхава-антаранга

грхе бā ванете тхāке, 'хā гаурāнга' бо'ле дāке,

нароттама мāге тārа санга

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын тайлбар

Энэхүү дуундаа Нароттама дас Тхакур бие нь алтлаг шар өнгөтэй учраас Гауранга хэмээн нэрлэгдсэн Бурхан Чайтаньяг магтан алдаршуулжээ. Хэрэв хүн цайвар шаргал арьстай бол түүнийг *гаура* гэж нэрлэдэг. Бурхан Чайтаньийн арьс маш их өнгөлөг цайвар, хайлуулсан алт мэт байсан учраас Түүнийг мөн Гаурасундара гэж нэрлэжээ. Нароттама дас Тхакур өгүүлэхдээ: *гаурāнгера дутти пада, жār дхана сампада, се жāне бхакати-раса-сār*. Бурхан Чайтаньийн бадамлянхуан өлмийд өөрийгөө даатгасан хэн бүр чин бишрэл зүтгэлийн жинхэнэ мөн чанарыг танин ойлгож чадна. Чин бишрэл зүтгэлийн мөн чанарыг танин ойлгох нь нэн хүнд хийгээд ердийн хүний хувьд энэ нь ойлгогдошгүй зүйл юм.

“Бхагавад-гита”-д өгүүлснээр, амьдралын төгс төгөлдөрт хүрэхээр тэмүүлэгсэд дотроос цөөхөн хэд нь түүнд хүрдэг хийгээд үүний дүнд өөрийн “би”-гээ таньдаг. Ийм олон мянган өөрийгөө танин ухамсарласан сүнснүүдээс зөвхөн нэг нь л Кришнаг танин ойлгож болох юм гэсэн байдаг. Гэвч Түүнийг мэдэхгүйгээр Кришнад хэрхэн үйлчилж болох билээ? Иймээс Кришнад үйлчлэн зүтгэх чин бишрэл зүтгэл тийм ч амар хялбар олддог зүйл биш. Харин аз болоход Бурхан Чайтаньягийн өлмийгөөр(*гаурāнгера дутти пада*)даган замнах хүн бүр буюу Түүний заан өгсөн замаар замнан, зүгээр л Харе Кришна *маха-мантраг* давтан уншиж байсан цагт чин бишрэлийн алба зүтгэлийн мөн чанарыг төвөггүй таньж чадна. Иймээс ч Нароттама дас Тхакур хүн бүрийг Бурхан Чайтаньягийн бадамлянхуан өлмийн нөмрийг өөрийн өмөг түшиг болгох болон Түүний дагалдагч болохыг залбиран гуйж байна. Учир нь зөвхөн тэр цагт л чин бишрэл зүтгэлийн мөн чанарыг таньж чадна.

Бурхан Чайтаньягийн тоглоом наадам бүгдэд баяр хөөрийг авчирдаг. Чухам учир нь Бурхан Чайтанья Махапрабхугийн хөдөлгөөний үндсэн оролцогчид дуулж, бүжиглэж, *кришна-прасад* зооглодог. Бурхан Чайтанья өөрийн оршин суух газар орноо Жаганнатха-Пуриг болгож асан тэр үед Тэрээр өдөр бүр тэнд дуулан бүжиглэж, дараа нь *прасад* авчирахыг хүсэж, түүнийг чин бишрэлтэнгүүдэд тараадаг байв. Энэ нь бүгдэд маш ихээр таалагддаг байсан ба өдөр бүр зуу зуун хүн Бурхан Чайтаньятай дуулж бүжиглэхээр ирдэг байлаа. Ориссын захирагч, сүмийн эзэн, Махаража Пратапарудра сүмийн үйлчлэгч нарт Бурхан Чайтаньягийн чин бишрэлтэнгүүдэд хэдий хэмжээгээр л хүснэ, тэр хэмжээгээр нь *прасад* өгч байхыг тушааж байжээ. Тийнхүү Түүний тоглоом наадамд оролцох нь аугаа их цэнгэл таашаалыг авчирдаг: дуул, бүжиглэ, *прасад* ид. Хэрэв хүнд Бурхан Чайтаньягийн тоглоом наадам таалагдаад зүгээр л дуулан бүжиглэж прасад идэх аваас түүний зүрх бохир бузраасаа бүрнээ ариусна. Энэ хөдөлгөөнд нэгдсэн хүн бүр, дуулж, бүжиглэж, *кришна-прасад* идэх бөгөөд зүрх нь дамжиггүйгээр бүхий л материаллаг бохирдол бузраасаа ариусан цэвэрлэгдэнэ. Нароттама дас Тхакур, *гаурāнгера мадхура-лйлā, жār карҢе правейшилā, хрдойа нирмала бхело тār* – буюу өөрийн зүрхээ ариусган цэвэрлэхийг хүссэн хүн Кришнагийн ухамсрын хөдөлгөөн буюу Бурхан Чайтаньягийн хөдөлгөөнд нэгдэх ёстой хэмээн шударгаар батлан өгүүлжээ.

Бурхан Чайтанья нь маш өгөөмөр хийгээд Шри Кришна Чайтаньягийн буюу Гаурасундарын ариун нэрийг давтан уншиж эхэлсэн хэн бүрт Бурханыг хайрлах хайр заавал хөгжин бий болно. Ном ёсоороо бол чин бишрэлтэнгүүд эхлээд *шри-кришна чаитанья прабху нитийананда* хэмээн дуулдаг. Учир нь зүрх сэтгэл ариусч эхлэхийн тулд Бурхан Чайтанья, Бурхан Нитьянанда болон Тэдний дагалдагч нараас адис өршөөлийг хүсэн мөргөн залбирах хэрэгтэй. *Лилā* гэдэг нь “тоглоом, цэнгэл” гэсэн утгатай. Тоглоом наадам нь дагалдагчидгүйгээр байх боломжгүй ба ийм ч учраас Бурхан Чайтаньяг үргэлжид Нитьянанда, Адвайта, Гададхара, Шриваса болон өөр бусад олон чин бишрэлтэнгүүд дагалддаг. *Тār* гэдэг нь “түүнийг”, *хой* гэдэг нь “дуудах”, *премодой* гэдэг нь “Бурханыг хайрлах хайрын хөгжил” гэсэн утгатай. Зүгээр л *шри-кришна чаитанья прабху нитийананда* хэмээн дуулах хүн бүр хурдан хугацаанд Бурханыг хайрлах хайрыг хөгжүүлж эхэлдэг. Бурхан Чайтаньягийн ариун нэрийг дуулан, бүжиглэх тийм хүмүүсийг өөгшүүлэн дэмжиж, Нароттама дас Тхакур: “Хурай!” хэмээн хашгирч тийнхүү тэрээр: *жāи болихāри* буюу “гайхамшигтай, аугаа гайхамшиг!” хэмээн өгүүлэн байна.

Дараа нь тэрээр: *гаурāнга-гунете жхуре, нитийа-лилā тāре снхуре* –хэрэв хүн бүгдэд сайн сайхныг авчрагч Бурхан Чайтаньягийн тоглоом наадмын ач холбогдол, бүхий л утга учрыг ойлговол, хэрэв тэрээр онгод хөөрлийг амсаж, заримдаа нулимсаа барьж чадалгүй уйлж байх аваас тэрээр маш хурднаар *нитья-лила* гэж нэрлэгдэх Радха-Кришнын тоглоом наадмыг танин ойлгож чадна. Радха-Кришна нарын хоорондын хайр сэтгэлийн харилцаа цаг зуурын бус. Энд, энэ материаллаг ертөнцөд, охид, залуусын хооронд мөн л хайр сэтгэлийн харьцаа үүсдэг ч тэр нь мөнх бус билээ. Тийм харьцаа нь сайндаа хэдэн сараар эсвэл хэдэн жилээр үргэлжилдэг ч дараа нь энэхүү хайр сэтгэл гэж нэрлэгдэх тэр зүйлд төгсгөл ирнэ. Ийм харьцаа нь мөнх бус. Харин хэн мөнхийн хайр дурлалыг эрж хайнав, тэрээр Радха-Кришнагийн тоглоом наадамд оролоцохуй үйлийг хүлээж авах хэрэгтэй. Бурхан Чайтаньягийн хөдөлгөөний бүхий л ач холбогдлыг зүгээр л ойлгосноор хүн Радха-Кришнагийн мөнхийн тоглоом наадмыг ойлгож түүний оролцогч нь болж чадна. Тийнхүү Радха-Кришнагийн трансцендент мөнхийн тоглоом наадмыг ойлгож чадсан хүн чин бишрэл зүтгэлийн хамгийн дээд төгс төгөлдөрт хүрнэ.

Дараагийн мөр нь - *гаурāнгера санги-гане*. Энэхүү *санги-гане* хэмээх үг нь “дагалдагчид” гэсэн утгатай. Бурхан Чайтанья хэзээ ч ганцаараа байдаггүй. Түүнтэй хамт үргэлжид дагалдагчдынх нь хэн нэг нь байж байдаг. Бурхан Чайтаньяг ганцааранг нь зурсан нэг ч зураг байхгүй бөгөөд бид ямар ч зураг аваад харсан түүн дээр Бурхан Чайтаньятай хамт үгүй ядахнаа гэхэд заавал Бурхан Нитьянанда эсвэл Гададхара Пандит байдаг. Бурхан Чайтаньяг хаана ч явсан тэр газарт үргэлжид мянга мянган чин бишрэлтэнгүүд хуран цугладаг. Энэ бүх чин бишрэлтэнгүүд ялангуяа Түүний ойр дотнын чин бишрэлтэнгүүд нь бүгд *нитья сиддхи* нар байсан юм. Төгс төгөлдөр чин бишрэлтэнгүүдийн гурван төрөл байдаг. Тэдгээрийн нэг дэхэд *садхана-сиддхи* нар хамаардаг. Зохицуулах зарчим, дүрэм журмуудыг хэлбэрэлт гуйвалтгүйгээр даган мөрдөж байж төгс төгөлдөрт хүрэгсэдийг тийнхүү нэрлэдэг. Өөрөөр хэлбэл зохицуулах зарчмуудыг даган мөрдсөөр хүрч буй тэрхүү төгс төгөлдөр байдлыг *садхана-сиддхи* хэмээн нэрлэдэг.

Хоёр дахь хэлбэрийн чин бишрэлтэнгүүдийг *крипа-сиддхи* нар хэмээн нэрлэнэ. Тэд зохицуулах зарчмуудыг хатуу баримталдаггүй боловч өөрийгөө үл хэрэгссэн үйлчлэн зүтгэлийнхээ ач тусаар номын багшийнхаа юмуу эсвэл Кришнагийн өршөөл ивгээлээр маш хурднаар төгс төгөлдөрт хүрдэг. Үүнийг *крипа-сиддхи* гэдэг. *Нитья-сиддхи* гэдэг нь материаллаг байгальтай хүрэлцсэнээр хэзээ ч бохирдон бузартдаггүй бодгалиудыг хэлнэ. *Садхана-сидхи* ба *крипа-сиддхи* нар нь нэгэн цагт материаллаг байгальтай хүрэлцсэнээр бохирдон бузардсан байдаг байхад харин *нитья-сиддхи* нар нь хэзээ ч түүнтэй хүрэлцдэггүй. Чайтанья Махапрабхугийн бүх дагалдагсад цөмөөрөө *нитья-сиддхи* нар буюу мөнхийн төгс төгөлдөр бодгалиуд байсан юм. Нитьянанда Прабху бол Кришнагийн шууд илрэл Баларама, Адвайта Прабху нь Маха-Вишну(Тэрээр мөн вишну-таттвад хамаардаг), Гададхара Прабху нь Радхаранийн илрэл, Шриваса нь Нарадын хувилгаан юм. Тэд бүгдээр *нитья-сиддхи* буюу төгс төгөлдөр сүнсүүд. Материалаг бохир бузар бүхэн хэзээ ч тэдэнд нөлөөлдөггүй. Бурхан Чайтанья Махапрабху нь Кришна Өөрөө агаад трансцендент тул Түүний бүх дагалдагсад *нитья-сиддхи* буюу мөнхийн трансцендент байдаг гэдгийг ойлгох хэрэгтэй. *се жай бражендра-сута-пайи*. *Бражендра-сута* нь Кришна юм. Бурхан Чайтаньягийн дагалдагч нар нь мөнхийн эрх чөлөөтэй юм гэдгийг зүгээр л танин ухамсарлаад Бурхан Кришнагийн трансцендент гариг орноо шуудхан хүрэлцэн очиж болно.

Шри-гауда-мандала-бхуми. *Гауда* нь Баруун Бенгали юм. Бурхан Чайтанья Баруун Бенгалид буюу Навадвипад заларсан бөгөөд чухам Энэтхэгийн энэ хэсэгт Түүний *санкиртан* хөдөлгөөн маш эрчимтэй хөгжин дэлгэрчээ. Энэ муж нь онцгой ач холбогдолтой бөгөөд учир нь Вриндаванаас ялгаа үгүй. Тэрээр Вриндавантай яг л адил. Навадвипад амьдрана гэдэг нь Вриндаванд амьдарсантай утга нэг юм. Нароттама дас Тхакур: *ири-гауда-мандала-бхуми, жеба жайне чинтамани* хэмээн өгүүлжээ. *Чинтамани* буюу трансцендент гариг орон юм. *Тара хой бража-бхуме ба*. Хэрэв хүн Навадвипа нь Вриндаванаас ялгарах зүйл үгүй юм гэдгийг ухамсарлан ойлгосон цагт тэрээр аль хэдийнээ Вриндаванд оршин амьдарч буй хэрэг. Тэрээр Бенгалид эсвэл материаллаг ертөнцийн аль нэг улс оронд амьдарч байна хэмээн бодох ёсгүй. Учир нь Бурхан Чайтаньягийн тоглоом наадам өрнөсөн газар орон бүхэн Вриндавантай ижил тэнцүү ач холбогдолтой.

Бурхан Чайтаньягийн тараан түгээж байсан Бурханыг хайрлах хайрыг энэхүү дуунд далайтай(*раса-арнава*) зүйрлэжээ. Ямар далайн тухай өгүүлж байна вэ? Энд давст далайн тухай буюу усыг нь уух боломжгүй далайн тухай өгүүлээгүй. Энэ дуунд өгүүлэгдэж буй далайн ус нь маш гайхамшигтай амтай бөгөөд түүнээс нэг л дуслыг амсах аваас дахин дахин уух хүсэл төрдөг ажээ. Энэ нь амандаа хүргэх ч аргагүй жирийн нэг далайн ус бишээ. Ийм л учраас энэ далайг *расарнава* гэжээ. Түүн дээр үргэлж давалгаа долгион байх агаад тэрээр хэзээ ч хөдөлгөөнгүйгээр оршин байдаггүй. Учир нь тэрээр хий хоосон биш бөгөөд хэлбэр дүрсгүй бус. Ердийн далай нь үргэлжийн долгион хөдөлгөөнтэй байдаг шиг Бурхан Чайтаньягийн бидэнд авч ирсэн Кришнаг хайрлах хайрын трансцендент далайд байнга давалгаан, авиан давалгаан нүргэлж байдаг. Энэ далайн хамгийн гүн рүү нь шунгах хэрэгтэй. Энэхүү нууцыг танин ойлгож, Бурхан Чайтаньягийн эхлүүлсэн хайрын трансцендент хөдөлгөөний далайн гүн рүү улам улам шунгахаар шийдсэн

хүн шууд Радха-Кришнагийн чин бишрэлтэнгүүдийн ойрын дагуулуудын нэг нь болдог.

Иймээс Нароттама дас Тхакур дууныхаа төгсгөлд: *грхе бā ванете тхāке, 'хā гаурāнга' бо'ле дāке* гэжээ. Үүний тулд заавал гуйлгачин, өглөг гуйгч болох, мөн гэр бүл, амьдарч буй орчин нийгмээ орхих албагүй. Тэрээр гэр бүлтэн, брахмачари, ванапрастха, санньясагийн өөрт илүү тохирох байр сууриа хадгалан үлдэж болно. Ванапрастха, санньяса нь хот суурин газарт амьдрах ёсгүй гэж тооцдог. *Ванете* гэдэг нь “ой” гэсэн утгатай. Эрт дээр цагт бурханлаг ухамсар бүхий хүмүүс нь хотын үймээнт амьдрлаас холдон хөндийрөхийг хүсч ойд очиж суурьшдаг байв. Харин одоо үед энэ нь боломжгүй. Орчин үеийн хүн нь ойд одох чадваргүй бөгөөд үүний тулд тодорхой бэлтгэл хэрэгтэй ба энэ бэлтгэл тэдэнд үгүй юм. Ийм учраас ер нь түүнд өөрийн найз нөхөдтэйгээ харьцаатай байж, эхнэр, хүүхдүүтэйгээ хамт амьдрахыг зөвлөдөг. Үүнд муу зүйл үгүй бөгөөд ганц л зүйл нэн чухал: энэ нь Бурхан Чайтаньягийн зааж өгсөн Кришнагийн ухамсрын зам мөр дээр гарах хэрэгтэй. Энэ огтхон ч хүнд үйл биш. Үүний тулд хүн Бурхан Чайтаньягийн хөдөлгөөнд нэгдэж, дуулж, бүжиглэж, *кришна-прасад* амтлан зооглож эхлэх хэрэгтэй. Тэрээр зүгээр л Харе Кришна *мантраг* давтан уншиж, бүжиглэж, *кришна-прасад* амтлах болно. Үүнийг хүн бүр хийж чадах ба үүн дотор орчлонгийн эгэл амьдралас огоорсон санньяси хүн ч хамаарна, - үүнд хүнд бэрх юм үгүй. Иймээс Нароттама дас, хүний байр суурь ямар байх нь, *брахмачари, грихастха, санньяси* байх нь ямар ч ач холбогдолгүй. “Хэрэв чи амьдралдаа эдгээр зарчмуудыг даган мөрдөх аваас би тантай хамт, таны хүрээлэл дунд байхыг хүснэ. Яагаад гэвэл чи Бурхан Чайтаньягийн чин бишрэлтэн шүү дээ”. Ийм үгээр Нароттама дас Тхакур өөрийн дуугаа төгсгөж байна.

Шри Гуру-вандана
Шри Гуруд өргөх мөргөл
(“Према-бхакти-чандрика”-гаас)

1

*и́рй-гуру-чара́на-па́дма, кевала-бхакати-са́дма,
бандх муи са́вадхāна мате
д́жāхāра прасāде бхāи, э бхава торийā д́жāи,
кри́шна-пра́пти хой д́жāхā ха'те*

2

*гуру-мукха-па́дма-ва́кйа, читтете корийā аикйа,
āр нā кориха мане āййā
и́рй-гуру-чара́не рати, эи се уттама-гати,
же прасāде нūре сарва āййā*

3

*чакху-дāн дило жеи, жанме жанме прабху сеи,
дивйа-д́жнāн хрде прокāййито
према-бхакти д́жāхā хоите, авидйā винāййа д́жāте,*

веде гай джайхара чарито

4

*ирй-гуру карун-синдху, адхама джанара бандху,
локанатх локера дживана
ха ха прабху коро дойа, дехо море пада-чхайа,
эбе джайа гхушук трибхувана*

1. Номын багшийн бадамлянхуа өлмий нь цэвэр чин бишрэлийг олж хүртэх цорын ганц арга зам билээ. Би хүндэтгэл бишрэлтэйгээр түүний бадамлянхуан өлмийд мөргөн забирнам. Зөвхөн номын багшийн өршөөл хишгээр бид материаллаг ахуйн их далайг туулан гарч Кришнагийн өршөөл хишгийг хүртэж чадмуй.

2. Миний цорын ганц хүсэл гэвээс номын багшийн мань бадамлянхуан амнаас урсан гарсан сургаал бүхэн миний ухамсрыг ариусган цэвэрлээсэй хэмээн хүснэм. Номын багш таны бадамлянхуан өлмийд шимтэн татагдах нь бурханлаг төгс төгөлдөрт хүрэх хамгийн шилдэг арга бөлгөө. Зөвхөн таны өршөөл хишгээр бүхий хүсэл биелмүй.

3. Тэрээр надад харах чадварыг маань буцаан өгч, зүрхэнд минь трансцендент мэдлэг ухааныг суулган өгсөн билээ. Ийм ч учраас тэрээр нэг амьдралаас нөгөө амьдралд эзэн минь хэвээр байх болмуй. Тэрээр онгод хөөрлөөр бялхсан *премаг* анхилуулан тархааж, мунхагийн түнэр харанхуйг үлдэн хөөх бөгөөд ведийн судар бичээсүүд түүний гайхамшигт чанарыг магтан дуулдаг билээ.

4. Ай номын багштан минь ээ, ай өршөөл хишгийн далай, ай унан доройтсон сүнснүүдийн нөхөр минь ээ, та минь чин бишрэлтэн нарын зааварлагч хийгээд захирагч нь билээ. Ай эзэн минь ээ! Надад өршөөл энэрлээ хайрлаж, таны бадамлянхуан өлмийн нөмөрт хоргодон байхыг минь болгоон соёрхоно уу. Таны алдар нэр бүх гурван ертөнц даяар дуурсан түгэх болтугай!

Саварана-шри-гаура-пада-падме-прартхана
Шри Гаурангийн бадамлянхуан өлмийд өргөх мөргөл
(“Прартхана”-гаас)

1

*ирй-кришна-чайтанья-прабху дойа коро море
том-бин-ке дой-лу жагат-самсаре*

2

*патита-павана-хету тава аватара
мо сама патита прабху на пайбе ара*

3

ха ха прабху нитй-нанда, прем-нанда сукхи

крп̄абалокана коро āми боро дүжхк̄и

4

*дой̄а коро с̄ит̄а-пати адваита гос̄аи
тава крп̄а-бале п̄аи чаитан̄иа-нит̄аи*

5

*х̄а х̄а свар̄уп, сан̄атана, р̄упа, рагхун̄атха
бхат̄т̄а-жуга, ӣр̄и-ж̄й̄ва х̄а прабху локан̄атха*

6

*дой̄а коро ӣр̄и-āч̄ар̄й̄а прабху ӣр̄инив̄аса
р̄āмачандра-сан̄га м̄āге нароттама-д̄āса*

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын тайлбар

Энэхүү дуундаа Нароттама дас Тхакур Бурхан Чайтаньяд хандан: “Ай Бурхан минь ээ, надад өршөөл адислалаа хануудлаач. Учир нь бүхий л гурван ертөнцөд Өршөөлт Танаас илүү өгөөмөр нь үгүй билээ” хэмээн мөргөн залбирчээ. Ийм залбирлыг өргөсөн нь зөвхөн Нароттама дас Тхакур төдийгүй Рупа Госвами байсан юм. Бурхан Чайтаньятай анх Праягт (Аллахабадад)уулзаад Шрила Рупа Госвами: “Ай Бурхан минь ээ, Та бүхий л Бурханы хувилгаадууд дотроос хамгийн өгөөмөр нь билээ. Учир нь Та Кришнаг хайрлах хайр буюу Кришнагийн ухамсрыг тараан түгээж буй билээ” хэмээн өгүүлсэн байдаг. Кришна Өөрөө дэлхий дээр оршин байх үедээ Тэрээр биднийг Түүнд өөсрдийгөө даатгахыг хүссэн хэдий ч Өөрөө тийм өгөөмрөөр тараан түгээгүй юм. Тэрээр урьдчилгаа нөхцөл тавьсан бөгөөд тэр нь: “Эхлээд Надад өөрийгөө даатгачих” гэжээ. Гэвч Бурхан Чайтанья Өөрөө Кришна Бурхан мөн боловчиг ийм тийм ямар ч нөхцөл тавиагүй. Тэр Кришнаг хайрлах хайрыг зүгээр л өгч байсан бөгөөд “Үүнийг авцгаа!” хэмээн өгүүлж байв. Иймээс ч Бурхан Чайтаньяг хамгийн өгөөмөр хувилгаан хэмээн тооцдог. Нароттама дас Тхакур өгүүлэхдээ: “Надад өршөөнгүй хандаач. Энэ галав эринд амьдарч буй хүмүүс нь хэрхэн доош унан доройтсоныг сайтар ойлгоод Та тэдэнд машид өгөөмрөөр мөн бүрэн хэмжээний өршөөл энэрэлтэйгээр ханднам билээ. Харин би бол хамгийн ихээр унан доройтсон нь юм. Над шиг тийм ихээр доош унасан нь үгүй” гэжээ. *Патита-п̄ивана-хету тава ават̄ара* – “Та зөвхөн унан доройтсон болзолт сүнснүүдийг засч залруулахын тулд буун морилсон билээ. Гэвч би Танд нэг зүйлийг сануулья: Та надаас илүүтэйгээр унан доройтсон хэнийг ч олохгүй. Ийм учраас надаас эхэлж хайрлана уу”.

Дараа нь тэрээр Бурхан Нитьянандад хандан: *х̄а х̄а прабху нит̄ийāнанда, прем̄āнанда сукх̄и* - “Хүндэт Нитьянанда Бурхан минь ээ, Та баяр хөөр, бурханлаг

жаргал цэнгэлээр дүүрэн хийгээд үргэлжид аз жаргалтай харагднам билээ. Ийм учраас би таныг зорин ирлээ. Учир нь би бүхий л азгүйчүүд дотроос хамгийн азгүй нь юм. Хэрэв Та над руу харц хандуулвал магадгүй би яг Тан шиг аз жаргалтай болж болох юм” хэмээн мөргөн залбирчээ. Дараа нь тэрээр Адвайта Прабхуд хандан мөргөлөө өргөсөн байна. *Дойй коро сītā-пати адвайта госāи.* Адвайта Прабхугийн эхнэрийг Сита гэдэг бөгөөд иймээс ч Түүнийг *сītā-пати* гэж нэрлэдэг. Нароттама дас Тхакур Түүнд хандан: “Ситагийн нөхөр эрхэм Адвайта Прабху минь ээ, надад өршөөл адисаа хайрлаач. Хэрэв Та надад өршөөнгүйгээр хандвал Бурхан Чайтанья, Нитьянанда нар мөн намайг өршөөн адислах буй заа” гэж залбирлаа өргөжээ. Үнэн хэрэгтээ чухамхүү Адвайта Прабху л Бурхан Чайтаньяг энэ ертөнцөд буун залрахыг хүсэн гуйсан билээ. Зөвхөн мэдрэхүйгээ хангах үйлэнд автан живсэн, Кришнагийн ухамсар үгүй бүх унан доройтсон сүнснүүдийг хараад Адвайта Прабху тэднийг энэрч хайрлах сэтгэл эрхгүй төрсөн байна. Үүний хамт Тэрээр Өөрөө тэдэнд туслаж чадахгүй гэдгээ ойлгосны үндсэн дээр Бурхан Кришнад хандан: “Та өөрөө заларч соёрхооч. Зөвхөн Та л энэхүү унан доройтсон сүнснүүдийг аварч чадна” хэмээн мөргөн залбирчээ. Түүний гуйлтыг хүлээн авснаар Бурхан Чайтанья энэ ертөнцөд заларсан юм. Ийм учраас Нароттама дас Тхакур Адвайта Прабхуд хандан: “Хэрэв Та надад өршөөнгүйгээр хандвал Бурхан Чайтанья, Нитьянанда нар заавал надад Өөрсдийн адис өршөөлөө хайрлана” гэж гуйн залбирсан нь тийм гайхах зүйл биш юм. Дараа нь тэрээр Госвами нарт хандан мөргөн залбирч байна: *хā хā сварūп, санāтана, рўпа, рагхунāтха.* *Сварūп* гэдэг нь Бурхан Чайтаньягийн хувийн дагалдагч, бичиг хэрэг эрхэлсэн Сварупа Дамодарыг хэлж байгаа бөгөөд тэрээр үргэлжид Чайтанья Махапрабхутай хамт байж, Түүний бүхий л хүслийг биелүүлж байсан юм. Бурхан Чайтаньягийн ойрын хоёр дагуул болох Сварупа Дамодара, Говинда нар Бурханыг үргэлж дагалдан явдаг байв. Иймээс Нароттама дас Тхакур Сварупа Дамодарт, дараа нь Бурхан Чайтаньягийн ойрын дагуулууд болох зургаан Госвамид: Шри Рупа Госвами, Шри Санатана Госвами, Шри Рагхунатха Бхатта Госвами, Шри Гопал Бхатта Госвами, Шри Жива Госвами, Шри Рагхунатха дас Госвами нарт хандан мөргөн залбирчээ. Энэ зургаан Госвами нь Кришнагийн ухамсрыг өргөжүүлэн хөгжүүлэх хувийн захиас даалгаврыг авсан ба Нароттама дас Тхакур мөн л тэднээс түүнд адис өршөөлөө хайрлахыг гуйн залбирч байна.

Зургаан Госвамийн залгамжлагч, дараагийн *ачарья* нь Шриниваса Ачарья байлаа. Нароттама дас Тхакур нь түүнтэй бараг нэг цаг үед төрсөн боловч багш шавийн хэлхээгээр бол тэрээр түүний яг дараагийн эгнээнд бичигддэг. Нароттама дасын нэн ойрын найз бол Рамачандар Чакраварти байсан ба Нароттама дас мөн л: “Би үргэлжид Рамачандратай хамт байхыг хүсэн байна” хэмээн залбирчээ. Тэрээр үргэлжид чин бишрэлтэнгүүдийн хүрээлэлд байхыг эрхэмлэн хүсэж байна. Чухамдаа энэ нь чин бишрэлийн маш чухал үндсэн үйлүүдийн нэг юм: бид үргэлжид бурханлаг сургаал номлол айлдагчдын буюу *ачарья* нарт хандан өршөөл адисаа хайрлахыг болон цэвэр чин бишрэлтэнгүүдтэй үргэлж хамт байлгаж өгөхийг хүсэн залбирах хэрэгтэй. Тэгсэн цагт бидэнд өөрсөддөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлэх, Бурхан Чайтанья, Бурхан Кришнагийн адис өршөөлийг хүртэхүйд амар хялбар болох билээ. Энэ тухай Нароттама дас Тхакур өөрийн дуундаа оруулан дуулжээ.

Манах-шикша
Ухааныг сурган номлохуй
(“Прартхана”-гаас)

1

*нитāи-пада-камала, коṭи-чандра-суийītала,
же чхāйāй жагата журāй
хено нитāи бине бхāи, рāдхā-криṣṇа пāите нāи,
дрдха кори' дхаро нитāир пāй*

2

*се самбандха нāхи жā'р, бртхā жанма гело тā'р,
сеи пāиу боро дурāчāр
нитāи нā болило мукхе, мажило самсāра-сукхе,
видйā-куле ки корибе тāр*

3

*аханкāре матта хоийā, нитāи-пада пāсарийā,
асатйере сатйа кори мāни
нитāийер коруṇā хабе, браже рāдхā-криṣṇа пāбе,
дхаро нитāи-чараṇа ду'кхāни*

4

*нитāийер чараṇа сатйа, тāхāра севака нитйа,
нитāи-пада садā коро āша
нароттама боро дукхй, нитāи море коро сукхй,
рāкхо рāнгā-чараṇера пāйāи*

**Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын
тайлбар**

Таны өмнө Нароттама дас Тхакурын бас нэгэн гайхамшигтай дуу байна. Тэрээр энэ дуундаа нитāи-пада-камала(камала гэдэг нь бадамлянхуа, пада нь өлмий гэсэн утгатай) буюу Бурхан Нитьяландын бадамлянхуан өлмийн тухай өгүүлжээ. Энэ өлмий нь хүн бүрт нэг биш хэдэн сая сарны гэрлийн тээн авчрах амар тайван байдлыг олж болох өмөг түшиг юм. Хэдэн сая сарны туяа нь ямархан тайвшралыг авчрахыг төсөөлөх гээд оролд доо! Энэ эрчимтэйгээр там руу халин одох

материаллаг ертөнц нь(жагат) цаг үргэлж түймрийн галд автан байдаг. Энд бүгд амар тайвныг үл мэдэн хатуу бэрх тэмцлийг хийсээр байна. Хэрэв хүмүүс амар тайвныг хүсэх аваас тэд сая сая сарны туяа мэт гэрэлтүүлэн гийгүүлэгч Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмийн нөмөрт хоргодох хэрэгтэй. Журāйā гэдэг нь “хөнгөрөх” гэсэн утгатай. Оршихуйн төлөөх энэхүү тэмцлийг зогсоох, материаллаг зовлон зудгүүрийн түймрийг даран унтраахыг үнэхээр хүсэгч хүнд Нароттама дас Тхакур, Бурхан Нитьянандын нөмөр нөөлгийг хайгтун гэж зөвлөжээ.

Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмийн нөмөрт хоргодсон хүн чухам юу олж хожих вэ? Нароттама дас Тхакур: хено нитāи бине бхāи – хүн Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмийн нөмөрт үл хоргодвол рādхā-кршṇа пāите нāи- түүнд Радха-Кришнад ойртоход нэн хүнд бэрх болно гэж өгүүлжээ. Кришнагийн ухамсрын хөдөлгөөний зорилго нь биднийг Радха-Кришнад ойртон дөхөхөд туслах болон Дээд Бурханы зүгт, Түүний дээдийн цэнгэл хайрлагч бүжгэнд нэгдэхэд туслахад оршино. Радха-Кришнагийн бүжигт оролцогсдын дунд үнэхээрийн байлцахыг хүссэн хүн Нароттама дас Тхакурын зөвлөгөөг дагаж, Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмийн нөмөрт хоргодох ёстой.

Цааш нь тэрээр: се самбандха нāхи гэжээ. Самбандха гэдэг нь “холбоо” ба “хүрэлцэл” гэсэн утгатай. Нитьянандатай холбоо тогтоогоогүй тэр хүн хүний бие махбодид л олох тэр сайхан боломжийг алдаж буй юм. Энэ тухай Нароттама дасын өөр нэгэн дуунд: хари хари бипхале жанама гоñāину- Хэн бээр Нитьянандатай холбоо үл тогтооно, мөн тийнхүү Радха-Кришнад ойртохыг үл эрмэлзнэв тэрээр дэмий хоосон амьдралаа өнгөрөөж буй билээ. Бртхā гэдэг нь “үр ашиггүй”, жанма нь “амьдрал”, тā’р гэдэг нь “түүний”, самбандха гэдэг нь “харилцаа” хэмээсэн утгатай. Энэхүү үнэлж баршгүй бэлэг болсон хүний бие махбодийг хүлээж авчихаад Нитьянандатай харилцаа тогтоохыг үл эрмэлзэгч хүн нь өөрийн амьдралаа үрэн таран хийж байгаа хэрэг юм. Чухам яагаад ? сеи паṅу боро дурāчār. Сей гэдэг нь “тийм”, паṅу нь “амьтан”, дурāчār гэдэг нь “бузар булай үйлийг хийгч” буюу “хамгийн бузар булай үйлийг үйлдэгч” гэсэн утгатай. Хэрэв хүн юуны өмнө Бурхан Чайтанья болон Нитьянандын өршөөл адислалыг хүлээн авч , өөртөө Кришнагийн ухамсрыг хөгжүүлэхийг үл чармайх аваас тэрээр үр ашиггүйгээр өөрийн амьдралаа сүйтгэж буй хэрэг бөгөөд учир нь зүгээр л өөрийн амьтан адгуусны дур сонирхлыг өөгшүүлэн дэмжиж, мэдрэхүйгээ ханган цэнгүүлж л амьдарч буй юм. Нароттама дасын өгүүлснээр бол амьтдыг сурган гаршуулж болдог ч амьтантай эгээ адилхан хүн нь өөрийн адгуусны дур сонирхлыг илрүүлэн гаргадаг бөгөөд энэ нь магадгүй энэ ертөнц дээрхи хамгийн аймшигтай зүйл байж болох юм. Учир нь гэвэл тийм хүнийг тогтоон барих ямар ч боломжгүй билээ. Ердийн муур, нохой, тэр ч бүү хэл барыг ч сурган номхруулж болдог ч замаасаа хазайн гарсан хүний хийх ёстой тийм үйлийг хийхийг үл хүсэгч буюу өөрөөр хэлбэл өөртөө Кришнагийн ухамсрыг үл хөгжүүлэгч хүн нь өөрийн хөгжингүй оюун ухааныг адгуусны дур сонирхлоо хангахад ашиглаж эхэлдэг ба тийм хүнийг хазаарлан барина гэдэг маш хүнд. Улс оронд ямар ч хууль дүрэм тогтоосон ч тэд хулгайч хүнийг ариун шударга хүн болгон хувиргаж чадахгүй, түүнийг хориглон барих боломжгүй. Учир нь түүний зүрх сэтгэл бохирдсон байдаг.

Засаг төр гэмт хэрэгтнийг гэсгээн шийтгэдэг гэдгийг хүн бүр сайн мэддэг хийгээд үүний зэрэгцээ ариун судар номуудад тамд тэднийг ямаршуу шийтгэл цээрлүүлэлт хүлээж буй тухай өгүүлсэн байгаад ч чөтгөр мэт хүмүүс нь хэдий тэд судар бичигт өгүүлснийг сонссон ч тогтоол шийдвэрийн заалтыг дурдсан ч тэднийг яагаад ч тогтоон хориглох боломжгүй.

Тэд чухам юу хийдэг юм бэ? нитāи нā болило мукхе. Нитьянанда гэж чухам хэн болохыг мэдэхгүй бөгөөд тэд хэзээ ч Бурхан Нитьянанда хийгээд Бурхан Чайтаньягийн нэрийг давтан дууддаггүй. Мажило самсāра-сукхе. Мажило гэдэг нь “автах” гэсэн үг. Тийм хүмүүс нь материаллаг мэдрэхүйгээ хангах үйлэнд автан зууралдсан байдаг. Бурхан Чайтанья, Нитьянанда гэж хэн болох нь тэдний сонирхлыг нэг их татдаггүй. Ийм учраас тэднийг материаллаг оршихуйн болото улам улам уян татдаг. Видйā-куле ки корибе тār – хэрэв хүн Нитьянандатай ямар ч холбоо тогтоолгүй, Кришнагийн ухамсрын зам мөр дээр гарахгүй бол түүнийг академик боловсрол буюу видйā, нэр нөлөөтэй гэр бүлд төрөх эсвэл аугаа том улс гүрэнд төрөх буюу кулагийн аль нь үл аврах бөлгөө. Ямар ч нэртэй гэр бүлд төрлөө гэсэн ясар ч аугаа том улс оронд төрсөн байлаа ч гэсэн, ямар ч гайхамшигтай боловсрол мэдлэгийг эзэмшсэн байлаа гэсэн үхэх мөчид түүний үйл байгалийн хуулийн дагуу таслан зогсдог ба энэ үйлтэйгээ тохирохуйц шинэ бие махбодийг тэрээр хүлээн авна.

Чухам яагаад энэхүү хүн мэт адгууснууд амьдралын ийм хэлбэр маягийг даган мөрдөнө вэ? Ахайкāре матта хоййā, нитāи-пада пāсарийā. Тэд материаллаг амьдралын тухай буруу төсөөлөлтэй байдаг учраас тэдний оюун ухаан самуурч Бурхан Нитьянандатай холбоотой өөрсдийн мөнхийн харьцаагаа мартдаг. асатйере сатйа кори мāни – тийм мартамхай хүмүүс нь хуурмаг эрчмийг бодит оршдог мэтээр хүлээн авдаг. Асатйере – энэ нь байхгүй тэр зүйл буюу өөрөөр х элбэл майя. Майя гэдэг нь үнэн хэрэгтээ үл орших тэр зүйлийг хэлдэг бөгөөд цаг зуурхны хуурмаг зүйл юм. Нитьянандатай холбоо үл тогтоосон хүмүүс нь энэхүү хуурмаг биеийг бодитоор оршдог мэтээр хүлээн авдаг.

Цааш нь Нароттама дас Тхакур өгүүлэхдээ: нитāийер коруṇā хабе, браже рāдхā-кршṇа пāбе – “Хэрэв та үнэхээр Радха-Кришнатай харьцахыг хүсч тэмүүлж байвал, эхлээд Бурхан Нитьянандын адислалыг хүртэх хэрэгтэй. Тэрээр чамд Өөрийн адис ерөөлөө хайрласан зөвхөн тэр цагт чи Радха-Кришнад ойртон дөхөж чадна”. Дхаро нитāи-чараṇа ду’кхāни. Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмийгөөс бат бөхөөр атгаж авахыг Нароттама дас зөвлөжээ.

Дараа нь тэрээр дахин: *нитāийер чараṇа сатйа* хэмээн өгүүлсэн байна. *Майягаас* атган барьсан хүн Нитьянандын бадамлянхуан өлмийг ямар нэг *майя* мэтээр бодох нь гүн гүнзгий эндүүрэл юм. *Нитāи чараṇа сатйа*- Нароттама дас Нитьянандын бадамлянхуан өлмий нь хуурмаг зүйл биш харин бодит оршдог хэмээн батлан өгүүлжээ. *Тāхāра севака нитйа* – Нитьянандад трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйд автсан хүн нь мөн л трансцендент юм. Кришнагийн ухамсарт оршин байж, өөрийгөө Нитьянандад трансцендент хайраар үйлчлэн зүтгэхүйд зориулсан тэр хүн нь шууд л бүх зүйлс мөнх, тайлбарлаж баршгүй

жаргал цэнгэлээр дүүрэн байдаг бурханлаг ертөнцөд эзэлдэг өөрийн трансцендент байр сууриндаа буцан очдог. Иймээс Нароттама дас, *нитāи-пада садā коро āша* – Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмийгөөс цаг үргэлж сайтар атган барихыг чармайгтун хэмээн зөвлөжээ.

Нароттама боро дукхī. Нароттама дас Тхакур, *ачарья*, тэрээр маш их азгүй амьтан хэмээн өгүүлсэн байна. Үнэн хэрэгтээ бол тэрээр бид бүгдийг төлөөлөн зүгээр л азгүй хүний дүрд тоглож байгаа хэрэг л дээ. Тэрээр: “Ай Бурхан минь ээ, би маш азгүй хүн” хэмээн өгүүлжээ. *Нитāи море коро сукхī* - “Ийм учраас намайг аз жаргалтай болгож өгөөч гэж Бурхан Нитьянандаа танаа мөргөн залбирч байна”. *Рākхо рāнгā-чараңера нāйша* – “Намайг Өөрийн тань бадамлянхуан өлмийд хоргодохыг болгоон соёрхоно уу”.

Шри Рупа Манжари пада
Шри Рупа Манжарийн өлмий
(“Прартхана”-гаас)

1

*йрī-рūпа-май̄жарī-пада, сеи мора сампада,
сеи мор бхажана-пūжана
сеи мора прāна-дхана, сеи мора āбхарана,
сеи мор жīванера жīвана*

2

*сеи мора раса-нидхи, сеи мора вāнчхā-сиддхи,
сеи мор ведера дхарамы
сеи брата, сеи тапа, сеи мора мантра-жапа,
сеи мор дхарамы-карама*

3

*анукūла хабе видхи, се-паде хоубе сиддхи,
ниракхибо э дуи найане
се рūпа-мāдхурī-рāйи, прāна-кувалайа-йāйи,
прапхуллита хабе нийи-дине*

4

*тувā адарīана-ахи, гарале жāрало дехī,
чиро-дина тāпита жīвана
хā хā рūпа коро дойā, дехо море пада-чхāйā,
нароттама лошло йāраңа*

1. Шри Рупа Манжарийн(Рупа Госвамийн мөнхийн дүр төрх нь бурханлаг ертөнцөд Вриндаваны нэгэн гопи юм.) өлмий нь миний жинхэнэ эд баялаг билээ. Түүнд би өөрийн *бхажан* болон *пужаг* зориулан өргөмүй. Энэ өлмий нь миний зүрхний гүний нандин эрдэнэ, амьдралын маань гэрэл гэгээ, гоёл чимэглэл маань бөлгөө.

2. Тэр өлмий нь миний хувьд бүхий л *расын* эх булаг хийгээд бүх хүсэл мөрөөдлийн маань биелэл билээ. Тэр өлмий нь Ведийн сургаал номын мөн чанар, миний ам тангараг, тэвчил наминчлал, *мантра* уншлагын эцсийн зорилго бөгөөд миний шашин номын үйлийн утга учир нь амой.

3. Энэ өлмийд агуулагдах хүчний ачаар миний үйл надад чин бишрэлийг маань сэрээн өгөх бөлгөө. Тийнхүү би бурханлаг төгс төгөлдөрт хүрч өөрийн энэ нүдээрээ алив юмсыг ямар л байх ёстой яг тэр байдлаар нь харж чадах билээ. Шри Рупа Манжарийн гайхамшигт бурханлаг өлмий нь гэрэл цацарсан саран мэт өдөр шөнөгүй оршин байж миний зовон шаналсан сүнсийг амрааж, зүрхний маань бадамлянхуа дээр гэрэлтэн байх бөлгөө.

4. Сүнс маань чамаас хагацан салахын хоронд бохирдон хордож, амьдрал маань уй гуниг, зовлон шаналлаар дүүрч цалгина. Ай Рупа Манжари, надад өршөөл адисаа хайрлаач, бадамлянхуан өлмийнхөө нөмөр сүүдрийг надад өгөн соёрхооч. Таны өлмий Нароттама дасын цорын ганцхан өмөг түшиг билээ.

Васанти-раса

Хавар цагийн хайр сэтгэлийн наадам цэнгээн
(“Прартхана”-гаас)

1

брндāбана рамйа-стхāна, дибйа-чинтāмаñи-дхāма,
ратана-мандира манохара
āбрта кāлиндй-нйре, рāжа-хамса кели коре,
тāхе йобхе канака-камала

2

тāра мадхие хема-нйтха, аштa-дале бештита,
аштa-дале прадхāнā нййикā
тāра мадхие ратнāсане, боси' āчхен дуи-жане
ийāма-санге сундарй рāдхикā

3

о-рўпа-лāваñйа-рāййи, амийā поричхе кхаси',
хāсьа-парихāса-самбхāшаñе
нароттама-дāса кой, нитйа-лйлā сукха-мой,
садāи спхурука мора мане

1. Вриндаван нэрт гайхамшигт газар орон нь тэр чигтээ бурханлаг гүн ухааны чулуудаас бүтсэн, гэрэлт чулуудаар хийгдсэн олон олон үзэсгэлэнт сайхан сүмүүдтэй бурханлаг ертөнц дэхь трансцендент нутаг орон билээ. Тэр трансцендент газарт Ямуна мөрөн урсах бөгөөд түүний усанд *ража-хамса* нэрт хун шувууд хөвөн тоглох бөлгөө. Энэхүү бурханлаг мөрний мандал дээр зуу зуун дэлбээт тансаг алтан өнгөт бадамлянхуа цэцэг оршмуй.

2. Энэ бадамлянхуа цэцэгний төв дунд нь найман дэлбээгээр хүрээлэгдсэн алтлаг сэнтий орших бөгөөд тэрхүү найман дэлбээнд нь Лалита, Вишакха тэргүүтэй найман гол *сакхи* орших ажээ. Харин үнэт чулуудаар чимэглэсэн өндөрт орших алтан сэнтий дээр бурханлаг хос залрах бөлгөө. Тэнд Бурхан Шьямагийн хамт үзэсгэлэнт Радхика сууж байна.

3. Шри Радха, Говиндын яриа хүүрнэл нь инээмсэглэл, инээд хөөрөөр дүүрэн байх бөгөөд Тэдний шагшим гайхамшигтай дүр төрх ариун рашааны цуглаланг тархаан түгээх бөлгөө. “Трансцендент баяр хөөрөөр дүүрэн энэхүү мөнхийн тоглоом цэнгэл нь миний зүрхэнд үргэлжид орших болно” хэмээн Нароттама дас өгүүлж байна.

Бусад ачарья-вайшнавуудын дуунууд

ЗУРАГ

Кришнагийн бадамлянхуан өлмийд өргөх залбирал

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада

Америкийн эргийг чиглэн Атлантын далайг гатлан явж буй хөлөг онгоцны тавцан дээр 1965 оны есдүгээр сарын 10-ны баасан гаригт Шрила Прабхупада өөрийн өдрийн тэмдэглэлдээ ийм нэгэн зурвасыг бичиж үлдээжээ: “Өнөөдөр хөлөг онгоц давлагаанд хөдлөн ганхсангүй. Бие маань арай дээрдэж байгаа бололтой. Гэвч би Вриндавантай мөн миний Эзэн Шри Говинда, Гопинатха, Радха-Дамодартай хагацан салахуйн шаналлыг амсаж байна. Миний цорын ганц тайвшрал бол “Чайтанья-чаритамрита” бөгөөд түүнийг уншиж би Бурхан Чайтаньягийн *лилагийн* ариун рашаанаар цэнгэн жаргаж байна. Би зөвхөн Шри Бхактисиддханта Сарасватийн хүсэлтийг биелүүлэхээр Бхаратабхумиг орхин одож байна. Түүний хүсэлтэнд Бурхан Чайтаньягийн таалал илрэлээ олсон билээ. Байвал зохихуйц чанаруудын сүүдэр ч үгүй би Бурхан Адислалт Түүний заавар тушаалыг биелүүлэхээр аз сорин явж байна. Вриндаванаас алсад оршин ахуйдаа би зөвхөн Түүний өршөөлд найдан байгаа билээ”. Гурван өдрийн дараагаар яг л энэ мэт цэвэр чин бишрэл сүсэгтэйгээр Шрила Прабхупада дараахь залбирлыг бичжээ:

(дахилт)

крӣṇа та̄ба нӯṅṅа ха̄бе бх̄а̄и

э-нӯṅṅа корӣбе жа̄бе р̄а̄дх̄а̄р̄а̄ṅṅӣ кхус̄ӣ ха̄бе

дхрӯва а̄ти болӣ том̄а̄ т̄а̄и

1

ӣр̄ӣ-сиддх̄а̄нта сарасват̄ӣ, ӣач̄ӣ-сута̄ прӣя̄ а̄ти,

крӣṇа-себ̄а̄й̄а̄ жа̄ра̄ тула̄ н̄а̄и

сеӣ се мох̄а̄нта-гуру, жа̄га̄тер̄ ма̄дхе̄ уру,

крӣṇа-бхак̄тӣ дей̄ т̄х̄а̄ӣ т̄х̄а̄ӣ

2

*тāра иччхā балавāн, пāйичāтйете тхāн тхāн,
хой жāте гаурāнгер нāм
пртхивйите нагарāди, āсамудра нада надй,
сакалеи лой кршнa нāм*

3

*тāхале āнанда хой, табе хой диг-вижай,
чайтанйер крпā атиийай
мāййā душтa дукххй, жагате сабāи сукхй,
вашинавер иччхā пурна хой*

4

*се кārжа же корибāре, āжнā жади дило море,
жогйa нахи ати дйна хйна
тāи се томāра крпā, мāгитечхи анурупā,
āжи туми сабār правйна*

5

*томāра се йакти пеле, гуру-себāйя басту миле,
жйбана сāртхак жади хой
сей се севā пāиле, тāхале сукхй хале,
таба санга бхāгйате милой*

6

*эвам жанам нипатитам прабхавāхи-кўпе
кāмāбхи кāмам ану йах прапатан прасангāt
кртвātмасāt сураршиңā бхагаван грхйтаҳ
со 'хам катхам ну висрже тава бхртйa-севām*

7

*туми мор чира сātхй, бхулийā мāйār лātхи,
кхāийāчхи жанма-жанмāнтаре
āжи пунаҳ э сужога, жади хой жогāжого,
табе пāри тухе милибāре*

8

*томāра милане бхāи, āбār се сукха пāи,
гочāране гхури дин бхор
ката бане чхутāчхути, бане кхāи лутāпути,
сеи дин кабе хабе мор*

9

*āжи се субидхāне, томāра смараṇа бхела,
баро āйīā дāколām тāи
āми томāра нитйа-дāса, тāи кори эта āйīā,
туми бинā анйа гати нāи*

(дахилт)

Ай ах дүү нар минь ээ, та бүхэнд шударга үнэнийг хэлье: Шримати Радхарани танд сэтгэл ханамжтай болох тэр цагт л Дээд Бурхан Кришна танд аз хийморийг илгээх болно.

1. Шри Шримад Бхактисиддхантa Сарасвати Тхакур нь Шачидевийн хүү Бурхан Гаурангад машинд эрхэм билээ. Дээд Бурхан Шри Кришнад чин бишрэлээр үйлчлэн зүтгэхүйн үйлэнд түүнтэй эн зэрэгцэх нь үгүй. Тэрээр аугаа их ариун гэгээн номын багштан бөгөөд ертөнцийн бүх эгэл хүмүүст Кришнад тэмүүлэх гүн гүнзгий чин бишрэл сүсгийг хайрласан билээ.

2. Түүний халуун хүсэл мөрөөдлийн хүчээр Бурхан Гаурангийн ариун гэгээн нэр барууны бүх орнуудад тов тодорхой болох билээ. Гацаа тосгон, том жижиг хотууд, далайд, тэнгист, том жижиг гол мөрөнд ч хаа сайгүй Бурхан Кришнагийн ариун нэрийг магтан дуулах болно.

3. Шри Чайтанья Махапрабху Өөрийн хэмжээ хязгааргүй өршөөлөөр дэлхийн бүх өнцөг буланг байлдан дагуулж, трансцендент онгод хөөрлийн цутгалан газар дэлхийд халин асгармуй. Тийнхүү бүхий л нүгэлт, азгүй хөөрхий амьд оршнолууд аз жаргалыг олж авсан тэр цаг мөчид вайшнавуудын хүсэл мөрөөдөл биелэх болно.

4. Миний Гуру Махаража надад энэ үүрэг даалгаврыг хариуцуулан өгсөн ч надад энэ хариуцлагатай үйлийг хийх чанар үгүй хийгээд түүнийг биелүүлэх чадвар ч мөн үгүй билээ. Би бол унан доройтсон өчүүхэн нэгэн тул ай Бурхан минь ээ, би Танаас адис өршөөлөө хайрлахыг хүсэн гуйж байна. Надад энэхүү үүрэг даалгаврыг гүйцэтгэн биелүүлэх чадварыг хайрлаач. Зөвхөн Та л надад туслаж чадах бөгөөд учир нь Танаас илүү авьяаслаг, мэргэн нь үгүй билээ.

5. Та Өөрийн хүч чадлаа хайрласан тэр хүн амьдралдаа бүрнээ амжилтанд хүрэх болно. Учир нь номын багшдаа үйлчлэн зүтгэснээр тэрээр Туйлын Үнэнийг танин ойлгоно. Энэхүү үйлчлэн зүтгэлийг үйлдэх боломж бүхий тэр хүн аз жаргалаар дүүрэн бялхдаг билээ. Хэрэв түүнийг аз хийморь ивээвэл тэрээр Тантай харьцах сайхан боломжийг олж авах болно.

6. “Ай Бурхан минь ээ, ай Дээд Бурханы Бодгаль минь ээ, зүрхэндээ нэг нь нөгөөгөөр солигдон байх олон олон материаллаг хүслийг тээн би бүхий л хүмүүсийг явдаг тэр л жимээр алхалмуй. Тийнхүү алхам алхмаар могойгоор дүүрэн үл эзэгдэх нүх тийш дөхөн байна би. Гэвч Таны албат Нарада Муни өршөөнгүйгээр намайг өөрийн шавиа болгож, хэрхэн трансцендент түвшинд хүрэх тухай заан сургасан билээ. Иймээс түүнд үйлчлэхийг би өөрийн нэгдүгээр зэргийн үүрэг хэмээн ойлгоном. Би хэрхэн яаж энэ үйлчлэл зүтгэлээ орхих билээ ? ”. (Энэ үгийг Прахлада Махаража Бурхан Нрисимхад хандан өгүүлсэн байдаг. Шримад-Бхагаватам, 7.9.28).

7. Ай Бурхан Кришна минь ээ, Та миний мөнхийн дагуул бөгөөд Таныг мартаж орхисноор би *майягийн* цохилтонд өртөн нэг амьдралаас нөгөө амьдралд зовж зүдрэн байна. Гэвч хэрэв өнөөдөр надад Тантай дахин учрах боломж тохиох аваас би хэзээ ч Таныг үл орхином.

8. Эрхэм найз минь ээ, Чамтай дахин хамт байх хувь тохиовол би өгүүлж баршгүй аз жаргалтай болохсон. Өглөө эрт нуга талаар хэрэн хэсүүчилж, Вражийн ой дундуур гүйж, тоглон наадахсан. Бурханлаг онгод хөөрөлд автаж, газар дээгүүр өнхрөн бөмбөрөх болно. Ай чухам хэзээ энэ гэрэлт өдөр ирэх вэ?

9. Чиний тухай ийм бодол өнөөдөр надаас үл сална. Үүнээс гайхамшигтай нь үгүй билээ. Гүн гүнзгий уйтгар гунигт автан би Таныг дуудан байна. Би Таны мөнхийн албат бөгөөд иймээс ч Таны хүрээллийг тэсч ядан хүснэ. Ай Бурхан Кришна минь ээ, Та бол амжилтанд хөтлөх цорын ганц зам билээ.

Маркине бхагавата-дхарма Бхагавата-дхармаг Америкт номлохуй

Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада

1965 оны есдүгээр сарын 17нд Бурханы адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада Энэтхэгийн хилийн чанадад бүх дэлхий даяар Шри Чайтаньягийн сургаалыг номлох тухай зааврыг зүрхэндээ тээн “Жаладута” хөлөг дээр суун Бостон хотноо ирсэн юм. Бостоны сүрлэг өндөр байшингуудын бүүргэр дүр төрхийг хараад тэрээр энэ заавар тушаалыг биелүүлэх нь ямархан хүнд болохыг ойлгосон. Мөн түүнийг Бурханд итгэх итгэл үгүй Барууны хүмүүсийг энэрэн өрөвдөх сэтгэл эзэмдсэн юм. Очсоныхоо маргааш өдөр тэрээр энэхүү түүхэн залбирлыг бенгали хэл дээр бичсэн бөгөөд түүндээ тэрээр бүхий л унан доройтсон сүнснүүдийг аврахыг хүсэн Кришнад хүлцэнгүйгээр залбиран мөргөжээ.

1

*баро-крп̄а каиле крӣна адхаме прати
ки л̄агий̄аниле хетх̄а коро эбе гати*

2

*āchхе кичху к̄аржа таба эи аном̄ане
нахе кено āнибен эи угра-стх̄ане*

3

ражас тамо гуҥе эр̄ саба̄и а̄чханна
ба̄судеб-катх̄а ручи нахе се прасанна

4

табе жади таба кр̄п̄а хой ахаитук̄и
сакал-и самбхава хой туми се каутук̄и

5

ки бх̄аве бужх̄але т̄а̄р̄а бужхе сеи раса
эта кр̄п̄а коро прабху кори низжа-ба̄ӣа

6

том̄ара иччх̄а̄й̄а саба хой ма̄й̄а-ба̄ӣа
том̄ара иччх̄а̄й̄а на̄й̄а ма̄й̄а̄р пара̄ӣа

7

таба иччх̄а̄ хой жади т̄а̄дера уддх̄а̄р
бужхибе нӣй̄чаи табе катх̄а се том̄а̄р

8

бх̄а̄гаватер катх̄а се таба ават̄а̄р
дх̄ӣра ха̄й̄а̄ ӣмуне жади ка̄не ба̄р ба̄р

9

ӣр̄н̄ват̄а̄м̄ сва-катх̄а̄х̄ крӣна̄х̄
пӯн̄й̄а-ӣрава̄на-к̄ӣртана̄х̄
хрд̄й̄ ан̄та̄х̄-стхо х̄й̄ абхадра̄н̄и
видхуноти сухрт̄ са̄т̄а̄м̄

на̄ӣт̄а-пра̄й̄е̄ш̄в̄ абхадрешу
нит̄й̄а̄м̄ бх̄а̄гавата-сева̄й̄а̄
бхагават̄й̄ уттама-ӣлоке
бхактир бхавати на̄ӣт̄х̄ик̄ӣ
та̄да̄ ражас-тамо-бх̄а̄ва̄х̄
ка̄ма-лобдх̄а̄дай̄а̄ӣ ча̄ й̄е
чета̄ этаир̄ ан̄а̄виддхам̄
стхита̄м̄ са̄т̄т̄ве̄ прас̄й̄д̄ати

эвам прасанна-манасо
бхагавад-бхакти-йогатах
бхагават-таттва-вижñāнаṃ
мукта-сангасйа жñāйте

бхидйате хрдайа-грантхий
чхидйанте сарва-самйийāх
кхиййанте чāsйа кармāñи
дриṭṭа эвātманййиваре

10

ражас тамо хате табе пāибе нистār
хрдайер абхадра саб гхучибе тāхār

11

ки ко'ре бужхāбо катхā баро сеи чāхи
кхудра āми дйна хйна коно ймакти нāхи

12

атхача энечхо прабху катхā болибāре
же томār иччхā прабху коро эи бāре

13

акхила жагат-гуру! бачана се āмār
алаñкрта корибār кхаматā томār

14

таба крпā ха'ле мор катхā йуддха хабе
йунийā сабāра йока дуркхха же гхучибе

15

āнийāчхо жади прабху āмāре нāчāте
нāчāо нāчāо прабху нāчāо се-мате
кāшṭхера путтали жатхā нāчāо се-мате

16

бхакти нāи беда нāи наме кхуб даро

“бхактиведанта” ням эбе сартхак коро

1. Миний эрхэм хайрт Кришна минь ээ, Чи энэ өчүүхэн сүнсэнд эгэлгүй өршөөнгүй хандавч би чухам Чи яагаад намайг ийш нь авч ирснийг огтхон ч үл мэднэм. Одоо Чи юу л хүснэ түүнийгээ надаар хийлгэж болно.

2. Гэвч Чамд энд ямар нэг ажил байна хэмээн би тааварлаж байна. Эс бөгөөс чи яахин намайг энэ аймшигт газар луу авч ирэх билээ?

3. Энд амьдрагч хүмүүсийн ихэнхи нь мунхаг харанхуйн, шунал тачаалын материаллаг гунын хальсан дор орших ажээ. Материаллаг үйлэнд бүрнээ автсан тэд өөрсдийгөө их аз жаргалтай мэтээр бодох бөгөөд өөрсдийн амьдралдаа сэтгэл бүрэн ханамжтай байх бөлгөө. Иймээс ч тэд Васудевын трансцендент илгээлтийг үл хэрэгсэх ажээ. Тэд түүнийг ойлгож чадах эсэхэд би огт итгэхгүй байна.

4. Гэвч Чиний учир шалтгаангүй өршөөлөөр боломжгүй бүхэн болж бүтдэг гэдгийг би сайн мэдэх билээ. Учир нь Чи бол хамгийн авьяаслаг шидтэн шүү дээ.

5. Тэд чин бишрэл зүтгэлийн үл салам сайхан амтыг мэдэрч чадах болов уу? Ай Бурхан минь ээ, би зөвхөн Чиний адис өршөөлд найдна. Таны сургаалын жинхэнэ үнэнд энэ хүмүүсийг итгүүлэхэд минь туслахыг Танаас гуйя.

6. Таны тааллаар бүхий л амьд оршнолууд хуурмаг эрч хүчний нөлөөн дор оршдог билээ. Мөн Таны тааллаар хэрэв Та хүсвэл тэд худал хуурмагийн гав гинжнээс ангижран суларч чадна.

7. Танаас гуйя, тэднийг авраач. Тэд Таны илгээлтийг Та зөвхөн тэдэнд ангижралыг хайрлахыг хүссэн тохиолдолд л ойлгож чадах билээ.

8. “Шримад-Бхагаватам”-ын үг бол Таны хувилгаан билээ. “Бхагаватам”-ыг байнгад, хүлцэнгүйгээр сонссоны ачаар ямар ч эрүүл саруулаар сэтгэгч хүн Таны илгээлтийг ойлгож чадна.

9. “Шримад-Бхагаватам”-д(1.2.17-21) өгүүлснээр: “Шри Кришна, Бурханы Бодгаль нь Параматма буюу Дээд Сүнс дүрээр амьд оршнол бүрийн зүрхэнд залардаг ба үнэнч зүтгэлтэй чин бишрэлтнийг туслан тэтгэгч буюу өөрөөр хэлбэл өө сэвгүй худал хуурмаггүй Таны илгээлтийг сонсох амтыг өөртөө хөгжүүлэх болон түүнийг зөв зүйтэйгээр, сонсох болон давтан уншсан цагт чин бишрэлтний зүрхнээс материаллаг хүсэл сонирхлыг нь ариусган цэвэрлэдэг . “Бхагаватам”-ыг тогтмол сонсож, цэвэр чин бишрэлтэнд үйлчлэн зүтгэснээр хүн зүрхийг нь түгшээн байдаг тэр бүхнээс бараг бүрэн ангижирдаг. Тэр цаг мөчид трансцендент дуунд магтан дуулагдсан алдар суу нь бадарсан Бурханд хайраар үйлчлэн зүтгэх үйл эргэлт буцалтгүй болно. Хүний зүрхэнд ийм хайраар үйлчлэн зүтгэхүй байдал ноёлож эхэлмэгц шунал тачаалын/*ражас*/, мунхаг харанхуйн/*тамас*/гуна түүнд өөрийн нөлөөгөө үзүүлэхээ болих ба тачаангуй хүсэл хийгээд хүсэл шунал /*кама*/ түүний зүрхнээс эгнэгт арилдаг. Тийнхүү буяны *гунад* батжин, Бурханд хайраар үйлчлэн зүтгэх үйлээр амилсан чин бишрэлтэн нь материаллаг харилцаа холбоог таслан зогсоож, ангижралд/*мукти*/ хүрч, Бурханы Бодгалийн тухай эрдэм ухааныг хүртмүй. Ингэж зүрхэн дэхь уяа хүлээсийг таслах ба бүхий л аюул занал эгнэгт дайжин одно. Хүн, жинхэнэ эзэн бол Сүнс юм хэмээх ойлголтонд хүрсэн цагт үр дүнгийнх нь төлөө үйлдсэн үйлийн гинж/*карма*/ мултран унадаг”.

10. Тэрээр мунхаг харанхуйн, шунал тачаалын *гунын* нөлөөнөөс ангижрах бөгөөд түүний зүрхэнд нуугдан байсан бүхий л таагүй болгон буцалтгүйгээр устан арилмуй.

11. Хэрхэн яаж би Кришнагийн ухамсрын эрдэм ухааныг тэдэнд хүргэх вэ? Би бол азгүй, өчүүхэн, унан доройтсон нэгэн билээ. Ийм учраас би Таны адислалыг хүсэн гуйж байна. Зөвхөн Таны адислалаар л би тэднийг итгүүлж дөнгөнө. Харин надад энэ даалгаврыг гүйцэтгэх хүч чадал үгүй билээ.

12. Ямартай ч ай Бурхан минь ээ, Таны тухай энэ хүмүүст яриулахын тулд л Та намайг ийш нь авч ирсэн. Одоо Бурхан минь ээ, энэ оролдлого амжилтаар төгсөх үү, азгүйтлээр төгсөх үү гэдэг зөвхөн Танаас хамаарах билээ. Бүх зүйл Таны тааллаар л болно.

13. Ай бүх дэлхий ертөнцийн номын багш минь ээ! Таны илгээлтийг би зөвхөн давтаж л чадна. Хэрэв Та хүсч байвал тэд намайг ойлгох тэр бүхнийг хийгтүн.

14. Зөвхөн Таны учир шалтгаангүйгээр өршөөлөөр миний үг цэвэр тунгалаг байдлыг олж чадах билээ. Хүмүүсийн зүрхэнд нэвтэрч орсноор энэ трансцендент илгээлт тэднийг аз жаргалаар бялхаана гэдэгт би итгэлтэй байна. Тийнхүү хүмүүс өөрсдийн бүхий л зовлон, шаналлаас ангижирна.

15. Ай Бурхан минь ээ, би бол Таны гар дахь хүүхэлдэй билээ. Та намайг энд хэдийнээ бүжиглүүлэхээр авч ирсэн болохоор намайг бүжиглэхийг соёрхогтун, бүжиглүүлэгтүн. Ай Бурхан минь ээ, Өөрийн хүсч байгаагаараа л Та намайг бүжиглүүл.

16. Надад чин бишрэл сүсэг, эрдэм мэдлэг үгүй ч би Кришнагийн ариун нэрэнд гүн бат итгэж байна. Намайг Бхактиведанта гэж нэрлэсэн. Харин одоо хэрэв Та хүсвэл энэ нэрний жинхэнэ утга утга учрыг бататгахад минь тусална уу.

Хамгийн зол муутай, өчүүхэн дорд
А.Ч.Бхактиведанта Свами.
“Жаладута” хөлгийн тавцан дээр бичив,
пирс Найрамдлын ???,
Бостон, Массачусетс муж, АНУ.
1965 оны есдүгээр сарын 18.

Шри Гуру-парампара
Шрила Бхактисиддханта Сарасвати Госвами Прабхупада

1

криṣṇа хоите чатур-мукха, хой криṣṇа-севонмукха,

брахмā хоите нāрадера мати

нāрада хоите вйāса, мадхва кохе вйāса-дāса,

пūrṇапражñа падманāбха гати

2

нрхари мādхавā-бамīе, акшобхйā парамахамсе,

иṣиийа боли 'аңгйкāра коре

*акшобхйера йишия жайа-тйртха нāме паричайа,
тāра дāсйе жнāнасиндху торе*

3

*тāхā хоите дайāнидхи, тāрā дāса видйāнидхи,
рāжендра хоило тāхā ха 'те
тāхāра кинкора жайа-дхарма нāме паричайа,
парампарā жāно бхāло мате*

4

*жайадхарма-дāсйе кхйāти, йрй пурушоттама-жати,
тā ха 'те брахмāйя-тйртха сūри
вйāсатйртха тāра дāса, лакимйпати вйāса-дāса,
тāхā ха 'те мādхавендра пурй*

5

*мādхавендра пурй-бара, йишия-бара йрй-ййивара,
нитйāнанда, йрй-адваита вибху
ййивара-пурйке дханйа, корилен йрй-чаитанйа,
жагад-гуру гаура махāпрабху*

6

*махāпрабху йрй-чаитанйа, рādхā-кршнā нахе анйа,
рūпāнуга жанера жйивана
вийивамбхара прийанкара, йрй-сварūпа дāмодара,
йрй-госвāмй рūпа-санāтана*

7

*рūпа-прийа махāжана, жйива, рагхунātха хана,
тāра прийа кави кршнāдāса
кршнāдāса-прийа-бара, нароттама севā-пара
жāра пада вийиванātха-āййа*

8

*вийиванātха-бхāкта-сātха, баладева жаганнātха,
тāра прийа йрй-бхактивинода
махā-бхāгавата-бара, йрй-гауракийора-бара*

īxārā парамхамса, гаурйнгера нижа-бамйа,

тāдера чаране мама гати

āми себā-удāсйна, нāмете тридандй дйна,

īрй-бхактисиддханта сарасватй

1. Бүтээл дөнгөж эхлэж байхад Дээд Бурхан Шри Кришна чин бишрэл зүтгэлийн тухай эрдэм ухааныг дөрвөн тэргүүнт Брахмад дамжуулсан билээ. Брахмагаас энэ бурханлаг мэдлэг Деварши Нарадад дамжин ирсэн ба Деварши Нардын шавь нь их мэргэн Кришна Двайпаяна Вьяса болсон юм. Тэрээр түүнд бүх ведийн судар бичээсийг бичин үлдээхийг даалгажээ. Арвангуравдугаар зуунд Вьясадева Бадарикашрамд *шуддха-двайтаын ведантын* сургуулийг үндэслэгч Шрипада Мадхвачарья дээр зочлон очив. Тэрээр түүнээс Ведантын гүн ухааныг мэдэхийг хүсэв. Ийн Мадхвачарья өөрийгөө Кришна Двайпаяна Вьясагийн албат хэмээн нэрлэжээ. Пурнапрагья Тиртха/Мадхва/ нь Падманабха Тиртхийн гуру буюу номын багш байсан бөгөөд түүний цорын ганц өмөг түшиг байсан юм.

2. Нрихара Тиртха, Мадхава Тиртха нар нь өөр нэгэн ойрын шавь нар нь байв. Мадхава Тиртха аугаа *парамхамса* Акшобхья Тиртхаг шавиа болгон авчээ. Акшобхья Тиртхийн ойрын шавь нь Жаятиртха байсан бөгөөд Жаятиртха өөрийн шавь Гьянасиндхууд үйлчлэн зүтгэж байсан юм. ????

3. Гьянасиндхугаас чин бишрэлийн албаны урлагийн тухай мэдлэгийг Даянидхи хүлээн авсан ба түүний албат нь Видьянидхи/Видьядхиража Тиртха/ байжээ. Видьядхиража Тиртхийн шавь нь Ражендра Тиртха болсон хийгээд Ражендра Тиртхийн шавь нь Жаядхарма буюу Вижаядхважа Тирта байлаа. Багш шавийн гинжин хэлхээний дэс дараалал ийм бөлгөө.

4. Аугаа санньяси Шри Пурушоттама Тиртха өөрийн гуру Вижаядхважа Тиртхад/Жаядхарма/ үйлчлэн зүтгэснээр мэдлэгийг хүртсэн ба Пурушоттама Тиртхийн ойрын шавь нь Субрахманья Тиртха байсан юм. Түүний албат нь аугаа их Вьясатиртха /Вьяса Рай/ байв. Вьясатиртхагийн албат нь Лакшмипати Тиртха байсан бөгөөд түүний шавь нь Мадхавендра Пури Госвами байлаа.

5. Мадхавендра Пуригийн ойрын шавь нь Ишвара Пури байсан ба түүний өөр хоёр шавь нь яруу алдарт Бурханы хувилгаан Шри Нитьянанда, Адвайта Ачарья нар байсан юм. Бүхий л ертөнц даяны бурханлаг сурган номлогч Шри Чайтанья Махапрабху мөн л Ишвара Пуриг Өөрийн номын багшаа болгон хүлээж авсан бөгөөд тийнхүү түүнд асар их адис өршөөлийг хайрласан билээ.

6. Шри Чайтанья Махапрабху Шри Шри Радха-Кришнагаас ялгаа үгүй. Тэрээр Шри Рупа Госвамийн мөрөөр замнагч вайшнавчуудын амь амьдрал юм. Шри Сварупа Дамодара Госвами, Рупа Госвами, Санатана Госвами нар нь асар их баяр хөөрийг Вишвамбхара/Шри Чайтанья/ танаа хайрласан билээ.

7. Рупа Госвами танаа аугаа сүнс Жива Госвами, Рагхунатха дас Госвами нар нэн эрхэм билээ. Жива Госвами нь Рупа Госвамийн шавь агаад Ядунанда Ачарьягийн шавь байсан Рагхунатха дас Госвами нь Адвайта Ачарьийн шавь болсон ба Рупа,

Санатана нарыг өөрийн гуравдахь ах нараа хэмээн тооцдог байв. Рагхунатха дас Госвамиин хайртай шавь нь Кришнадас Кавиража Госвами байсан ба Кришнадас Кавиража Госвами нь Локанатха Госвамиин ойрын найз байжээ. Тэд хамтдаа Вриндаванд амьдардаг байсан бөгөөд Кришнагийн тухай байнгад ярилцдаг байсан юм. Гададхара Пандитын шавь Локанатха Госвамид ердөө цорын ганц шавь байсан бөгөөд тэр нь Нароттама дас байв. Нароттама дас нь үргэлжид өөрийн гуру болон найддаа үйлчлэн зүтгэхүйд уусан автсан байлаа. Ийм ч учраас тэрээр Кришнадас Кавиража Госвамид нэн эрхэм байсан юм. Нароттама дас Тхакурын өлмийд үйлчлэн зүтгэхүй нь Вишванатха Чакраварти Тхакурын цорын ганц эрхэмлэх тэмүүлж байсан зүйл билээ. Тэрээр Нароттама дасаас тоолвол багш шавийн гинжин хэлхээний дөрөв дэхь *ачарья* байсан юм .

8. Вишванатха Чакраварти Тхакур нь Баладева Видьябхушаны *шикша-гуру*(Шикша-гуру- Түүнээс чин бишрэлтэн сургаал зааврыг нь хүртэх номын багш) байсан бөгөөд түүнд тэрээр “Шримад-Бхагаватам”-д агуулагдах сургаалыг тайлбарлан таниулжээ. Шри Баладева Видьябхушаны дараа нэртэй ачарья, Шрила Бхактивинода Тхакурын хайртай *шикша-гуру* Жаганнатха дас Бабажи явмой. Бхактивинода Тхакурын ойрын найз, дагалдагч нь нэр цуутай *маха-бхагавата* Шри Гауракишора дас Бабажи байсан бөгөөд түүний цорын ганц баяр баясгалан нь *хари-бхажан* байв.

9. Энэ бүх ариун гэгээн вайшнавууд нь бүгд маш өндөр түвшний чин бишрэлтэн буюу *парамахамса* нар байсан юм. Тэд бүгд Бурхан Гаурангийн Өөрийн бурханлаг гэр бүлд хамаардаг. Тэдний ариун өлмийнүүд нь хамгийн доод байр сууринд оршин буй, чин бишрэлийн үйлэнд ямар ч сонирхол үгүй хөөрхий *триданда санньяси* Шри Бхактисиддханта Сарасвати миний цорын ганц өмөг түшиг билээ.

Энэ дууг зохиогч Шри Бхактисиддханта Сарасвати Тхакур нь яруу найрагч-вайшнавуудын уламжлал ёсоор өөрийн нэрээ хамгийн төгсгөлд нь оруулжээ. Шри Бхактисиддханта Сарасвати Тхакурыг алдаршуулахын тулд түүний хайрт шавь Шри Чайтаньядевагаас эхлэлтэй багш шавийн хэлхээнд хамаарах Шри А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада энэ дуун дээр өөр нэгэн шүлэг нэмж бичжээ. Хүсвэл үүнийг есдэхь бадгийн оронд дуулж болно.

йрй-вйршабхйанавй-барй, садй севйа-севй-парй,

тйхйра дайита-дйса-нйма

тйра прадхйн прачйрако, йрй-бхактиведйнта нймо,

патита-жанете дойй-дхйма

Алдар суут Шри Варшабханави-дайита дас(Бхактисиддханта Сарасватид бурханлаг сахил хүртээх үед өгсөн номын нэр) нь үргэлжид өөрийн номын багштан Шрила Гауракишора дас Бабажид үйлчлэн зүтгэхүйд автнам. Түүний шавь, бүх унан доройтсон сүнснүүдийг энэрэн нигүүлсэгч, өршөөл адисын хувилгаан гаргуун номлогч Шри А.Ч.Бхактиведанта Свами Прабхупада Бурхан Чайтаньягийн илгээлтийг бүх дэлхий даяар номлон түгээж явмуй.

Шри Дамодараштакам

Энэхүү залбирлыг Сатьяврата Муни нь Нарада Муни болон Шаунака Риши нартай уулзан ярилцах үедээ өгүүлсэн ба Кришна Двайпаяна Вьясагийн “Падма-пуранд” дурьдагдсан байдаг.

“Картика сард Дамодара Бурханд мөргөх хэрэгтэй бөгөөд Сатьяврата мэргэний өгүүлэн айлдсан Бурхан Дамодарын тааллыг хангах “Дамодараштака” залбирлыг өдөр бүр уншин өргөх хэрэгтэй”.
(Шри Хари-бхакти-виласа, 2.16.198).

1

*намāmийиварам сач-чид-āнанда-рӯпам
ласат-куңдалам гокуле бхрāджсамāнам
йайодā-бхийолӯкхалāд дхāвамāнам
парāmриштам атийантато друтиа гопийā*

2

*рудантам мухур нетра-йугмам мрджантам
карāmбхожа-йугмена сāтанка-нетрам
мухух йивāса-кампа-трирекхāнка-каңтха-
стхита-граивам дāмодарам бхакти-баддхам*

3

*итйдрик сва-лйлāбхир āнанда-куңде
сва-гхошам нимажжантам āкхийāпайантам
тадийешиита-дэжйешу бхактаир житатвам
пунах прематас там йатāвритти ванде*

4

*варам дева мокшам на мокшиāвадхим вā
на чāнийам врне' хам варейāд апйха
идам те вапур нātха гопāла-бāлам
садā ме манаси āвирāстām ким анйаих*

5

*идам те мукхāмбхожам атийанта-нйлаир
вртām кунталаих снигдха-рактаийй ча гопийā
мухуий чумбитам бимба-рактāдхарам ме
манаси āвирāстām алам лакша-лāбхаих*

6

*намо дева дāмодарāнанта вишнӯо
прасйда прабхо дуккха-дэжлāбдхи-магнам
крпā-дритти-врштийāти-дйнам батāну-*

грхāнейша мām аджнām эдхи акши-дрійах

7

*куверātмажау баддха-мўртйаива йадват
твайā мочитау бхакти-бхāджсау кртау ча
татхā према-бхактим свака̄м ме прайаччха
на мокше грахо ме 'сти дāмодареха*

8

*намас те 'сту дāмне спхурад-дйнти-дхāмне
твадййодарāйātха виивасйа дхāмне
намо рāдхикāйаи твадййа-прийāйаи
намо 'нанта-лйлāйа девāйа тубхйам*

1. Би вээр бие махбодь нь мөнхийн цэнгэл жаргал, эрдэм мэдлэгийн өлгий болсон Дээд Бурхан танаа хүлцэнгүйгээр мөргөнөм. Тэрээр Гокулын бурханлаг орноо оршин байх агаад нүд гялбам гэрэл туяаг сацруулмуй. Далайн гахайн дүрийг санагдуулам, чимэн гоёсон ээмэг нь Түүний хөдөлгөөний аясаар хөнгөхөн хөдлөн ганхана. Модон ууранд уягдсан тэрээр Яшода эхээс айхын эрхэнд яаран сандран цааш тэмүүлэн зугатах хэдий ч Яшода ээж Түүнээс хурдан гүйх тул ямар ч байсан хөөн гүйцэх бөлгөө*.(*Энэ үйл явдал нь Тэрээр Яшода ээжийн чанаж болгохоор хадгалж байсан тарагтай ваарыг хагалсан, дараахан нь таазанд өлгөн хадгалж байсан цөцгийн тосыг хулгайлсан зэргээс үүдэлтэй) Энэ л Дээд Бурхан, Шри Дамодарад би өөрийн хүндэтгэл бишрэлээ өргөмүй.

2. Эхийнхээ гар дахь уяа хүлээсийг хараад уйлан сандрах Тэрээр урсан гарах нулимсаа бадамлянхуа мутраараа арчих бөгөөд нүд нь айдас хүйдсээр дүүрэн байна. Лавайн биед орших нарийн зураас адил уран тансаг хүзүү нь мөн гурван зураастай ажээ. Энэ л хүзүүг нь чимсэн эрдэнийн сувдан зүүлт ээрэн уйлан амьсгаадснаас чичрэн хөдлөх бөлгөө. Энгийн дээсээр бус эхийн ариун хайранд хүлэгдсэн энэ л Дээд Бурхан Шри Дамодара танаа хүлцэнгүй номхон хүндэтгэл бишрэлээ өргөмүй.

3. Ийм мэт Түүний хүүхэд ахуйн тоглоом наадам нь Гокулын оршин суугчдын юугаар ч илэрхийлэх аргагүй онгод хөөрлийн үндэс билээ. Энэ тоглоом наадгайгаараа Тэрээр агуу байдал, үгээр өгүүлшгүй гайхамшигт сүр жавхланг нь ямагт дурсан санах чин бишрэлтэн нартаа, зөвхөн ариун гэгээн хайр нь үлэмж дотно байдал, бүхий л хүндэтгэл, бишрэлээс ангид, цэвэр ариун хайр нь оргилон ундрах тийм л хүмүүс Түүнийг байлдан дагуулж чадахыг үзүүлж харуулсан юм. Асар их оргилон бялхсан хайраар, Бурхан Дамодарын өмнө зуу зуун удаа мөргөн залбирнам, би.

4. Ай Бурхан минь ээ, Та ямар ч адис ерөөлийг хайрлаж чадах хэдий ч би Танаас бодгаль бус байдлыг хийгээд дээдийн ангижрал гэгээрэл(Вайкунтхийн гариг дээрх мөнхийн амьдрал), өөр бусад сайн сайхан адислалыг(бхактийн есөн зарчмыг даган баримталснаар олж авч болох адислал) үл хүсэн мөргөнөм. Ай Бурхан минь ээ, харин би, Та энэхүү Вриндаванд орших Бала Гопала(жаахан хүү) дүрээрээ үргэлжид миний зүрхэнд оршин байхыг л хүсмүй. Надад үүнээс өөр ямар ч хишиг адислал хэрэггүй билээ.

5. Ай Бурхан минь ээ, Яшода ээж Таны улаан туяат хилэн хар үсээр хүрээлэгдсэн бадамлянхуа мэт нүүрийг дахин дахин үнсэх бөгөөд урууль тань *бимбын* жимс мэт ягааран байх бөлгөө. Үргэлжид би Таны гайхам үзэсгэлэнтэй бадамлянхуа мэт дүрийг өөрийн зүрхэндээ толидон харж байхыг болгоон соёрхтугай. Үүнээс өөр мянга мянган адис өршөөл надад огтоос хэрэггүй билээ.

6. Ай Дээд Бурхан минь ээ, Би Танд өөрийн хүндэтгэл бишрэлээ өргөнөм. Ай Дамодара! Ай Ананта! Ай Вишну! Ай Захирагч! Ай Эзэн Бурхан минь ээ! Би Танаас нэг л зүйлийг хүсмүй - энэ нь Та надад сэтгэл хангалуун үлдэх явдал билээ. Миний зүгт Өөрийн өршөөлт энэрэлт харцаа илгээж орчлонгийн уй гунигийн далайд живсэн аз муутай мунхаг харанхуй, мулгуу тэнэг намайг авран болгоогооч. Мөн Таныг үргэлжид толидон харж байхыг минь зөвшөөрч хайрлана уу.

7. Ай модон ууранд хүлэгдсэн жаахан хүүгийн дүрт Бурхан Дамодара минь ээ, Та Куверын хоёр хүү Манигрива, Налакувера нарт Нарада Мунигийн шингээсэн хараалыг устган зайлуулж тэднийг аугаа чин бишрэлтэнгүүд болгосон билээ. Ай Бурхан минь ээ, Өөрийн *према-бхактигаар* намайг мялаан шагнаж хайрлаач. Би зөвхөн үүнийг л тэсч ядан хүсэх ба ямар ч төрлийн ангижрал гэгээрэлд үл тэмүүлмүй.

8. Бурхан Дамодара минь ээ, Юуны өмнө би Таны гэдсийг ороон буй тэрхүү нүд гялбам гэрэл сацруулсан уяа хүлээсэнд мөргөн биширнэм. Үүний дараагаар би бүхий л орчлон оршин байх Таны гэдсэнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөнөм. Түүнчлэн би Таны бусдаас илүү эрхэмлэн хайрладаг Шримати Радхаранийн өмнө хүлцэнгүй номхоноор мөргөн залбирнам. Эцэст нь би Өөрийн дуусан төгсөшгүй тоглоом наадгайгаа илрүүлэн байх Дээд Бурхан Таны өмнө дахин дахин мөргөн залбирмуу.

Шри-Радхика-става

Шрила Рупа Госвами
("Става-мала"-гаас)

(нийтээр)

рāдхе жйа жайа мādхава-дайите
гокула-тарунī-мандала-махите

1

дāмодара-рати-вардхана-вейие
хари-нишкүта-врндā-випинейие

2

вршабхāнūdадхи-нава-йайи-лекхе
лалитā-сакхи гуна-рамита-виййкхе

3

*каруṇāṃ куру майи каруṇā-бхарите
санака-санātана-варṇита-чарите*

(нийтээр)

Ай Радха! Ай Мадхавын энхрий хайрт минь ээ! Ай Гокулын бүх бүсгүйчүүд мөргөн залбирдаг Та минь ээ! Таны алдар бадартугай! Таны алдар бадартугай!

1-3. Ай Та бээр өөрийн хувцаслалтаараа Бурхан Дамодарын хайрыг улам бадраах, Түүнийг өөртөө бат бөхөөр уян хүлэхийг эрмэлзэн байдаг билээ! Ай Бурхан Харигийн цэнгэн байдаг шугуй бүхий Вриндаваны хатан хаан минь ээ! Вришабхану хааныг бэлэгдсэн их далайн гүнээс илрэн гарсан шинэхэн саран минь ээ! Ай Лалитагийн эрхэм найз минь ээ! Найзархаг, эелдэг зан, Кришнад үнэнч байдлаараа Вишакхаг Танд бүрнээ даатгуулдаг Та минь ээ! Ай энэрэл нигүүлсэл бялхсан Та минь ээ! Бурханлаг чанарыг тань Санака, Санатана зэрэг аугаа мэргэд дуулан байдаг Та минь ээ! Ай Радха, надад өршөөл адислалаа хайрлаач !

Шри Дашаватара-стотра

Жаядева Госвами
(Гита Говиндагаас)

1

*пралайа-найодхи-жале дхритаваṅ аси ведам
вихита-вахитра-чаритрам акхедам
кейава дхрита-мйна-и́арйра жайа жагадйи́а харе*

2

*киштитир иха викулатаре тиштитхати тава приштитхе
дхараṇи-дхāраṇа-киṇа-чакра-гарिशтитхе
кейава дхрита-кўрма-и́арйра жайа жагадйи́а харе*

3

*васати даймана-и́икхаре дхараṇйи́ тава лагнā
и́айини калаṅка-калева нимагнā
кейава дхрита-и́у́кара-рўна жайа жагадйи́а харе*

4

*тава кара-камала-варе накхам адбхута-и́рнгам
далита-хираṇйакайи́ипу-тану-бхрнгам
кейава дхрта-нарахари-рўна жайа жагадйи́а харе*

5

чхалайаси викрамаңе балим адбхута-вāмана
пада-накха-нйра-дҗанита-дҗана-паавана
кейава дхрта-вāмана-рӯна жайа жагадййа харе

6

киатрийа-рудхира-майа джагад-апагата-пāтам
снапайаси пайаси йамита-бхава-тāпам
кейава дхрта-бхргупати-рӯна жайа жагадййа харе

7

витараси дикиу раңе дик-пати-каманийам
дайя-мукха-маули-балим рамаңййам
кейава дхрта-рāма-йарйра жайа жагадййа харе

8

вахаси вапуши виийаде васанам джаладāбхам
хала-хати-бхйти-милита-йамунāбхам
кейава-дхрта-халадхара-рӯна жайа жагадййа харе

9

ниндаси йажñа-видхер ахаха йрути-дҗāтам
садайа-хрдайа дарййита-пайу-гхāтам
кейава дхрта-буддха-йарйра жайа жагадййа харе

10

млеччха-ниваха-нидхане калайаси каравāлам
дхӯмакетум ива ким апи карāлам
кейава дхрта-калки-йарйра жайа жагадййа харе

11

йрй-дҗайадева-кавер идам удитам удāрам
йрну сухкха-дам йубха-дам бхава-сāрам
кейава дхрта-дайя-видха-рӯна жайа жагадййа харе

12

ведāн уддхарате джаганти вахате бхӯ-голам удбибхрате
даитйам дāрайате балим чхалайате киатра-киайам курвате
пауластйам жайате халам калайате кāруңйам āтанвате
млеччхāн мӯрчхайате даййакрити-крте криңайа тубхйам намаҳ

1. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай Загасны дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Аварга том загасны дүрд хувилан Та галав юүлэх үеийн шуугисан их усанд живж байсан Ведийг аврах завь нь болсон билээ.
2. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай яст мэлхийн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Бурханлаг яст мэлхийн дүрээр Та сүүн далайг хутгах бүлүүрийн үүргийг гүйцэтгэж байсан аугаа уул Мандараг өөрийн аварга том нуруун дээр тогтоон барьж байсан билээ. Таны нуруун дээр оршин ахуйдаа тэр аугаа уул шарх сорвийг санагдуулам ул мөрийг үлдээсэн ба энэ нь Таны нуруунд хэмжээ хязгааргүй алдар нэрийг авч ирсэн билээ.
3. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай Бодон гахайн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Та вээр орчлонгийн ёроолд унасан Гарбходака далайн уснаа живэн байсан Сарны гадарга дээрх толбыг санагдуулам энэхүү Газар Дэлхийг Өөрийн соёон дээрээ тогтоон барьж байсан билээ.
4. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай хүн-арслангийн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Хүн өөрийн хуруугаар зөгийг хоёр хэсэг болгон хаядаг шиг Та бээр тийм хялбараар Өөрийн гайхамшигт хурц хумсаараа зөгийтэй эгээ адилхнаар, чөтгөр Хирьянкашипугийн биеийг тасар татан хаясан билээ.
5. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ. Ай Одой-брахманы дүрд хувилсан Бурхан Хари минь ээ. Таны алдар бадартугай. Ай гайхалтай одой дүрт Бурхан минь ээ, Өөрийн аварга том алхмаараа Та хаан Балиг мэхэлж харин бадамлянхуан өлмийн хумснаас тань урсан гарах Гангын усаараа Та энэ ертөнц дээрх бүхий л амьд амьтдыг аварсан билээ.
6. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай Бхригупатигийн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Та бээр Танд алагдсан кшатрий-чөтгөрүүдийн бие цогцсоос урсан гарах цусан голоор Курукшетрийн талбарыг бялхаасан билээ. Та энэ ертөнцийн нүгэл хилэнцийг угаан арчсан ба Таны ачаар хүмүүн нар материаллаг ахуйн дүрэлзэн асах галаас аврагдсан билээ.
7. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай Рамачандрын дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Ланкын тулалдаанд Та арван толгойт Равана мангасыг даран сөнөөж, гайхамшигтай бэлгээр тэднийг баясгахыг хүссэндээ түүний толгойг Индра тэргүүнтэй арван зүгийг захиран ноёлох тэнгэр шүтээнүүдэд өргөсөн хийгээд тэдэнд багагүй зовлон зүдгүүр учруулсан тэрхүү хэрцгий догшин амьтныг Та л устгаасай хэмээн тэд хэдийнээс мөрөөдөж байсан билээ.
8. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай анжис барьсан Баларамын дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Бие тань нүд гялбам цагаан өнгөтэй ба хувцас тань яг л дөнгөж бүрэлдэн бий болсон үүл мэт цэнхэр өнгөтэй ажгуу. Өөрийн гайхамшигт бараан өнгөөр энэхүү хувцас

- нь Ямуна мөрний усыг санагдуулдаг билээ. Тэрээр Таныг Өөрийн анжсаар газар дэлсэх бүрд тань маш ихээр айдас хүйдэст автаж байдаг гэнэм.
9. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай Буддагийн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Ай Будда минь ээ, Таны зүрх энэрэл нигүүлслээр дүүрэн хийгээд ведийн тахилга өргөл хийх нэрийдлээр өрөвдөм хөөрхийлөлтэй амьтдыг алж нядлах үйлийг эрс буруушаасан билээ.
 10. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай Калкийн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Сүүлт од мэт илрэн залрах ахуйдаа Та бээр аймшигт илдийг гартаа барьж байдаг гэнэм. Тэрхүү илдээрээ Та Кали югагийн төгсгөлд амьдарч байсан бузар булай уналт доройтолд дорсон хүмүүсийг устгадаг билээ.
 11. Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай энэхүү арван янзын дүрд хувиран буун заларсан Бурхан Хари минь ээ. Таны алдар бадартугай! Эрхэм уншигч та яруу найрагч Жаядэвийн дууллыг сонсоорой. Учир нь дууллауудын сор нь болсон энэ дуулал аз жаргалыг бэлэглэж сайн сайхныг авчрах бүлгээ. Энэ дуулал нь энэхүү харанхуй ертөнц дэхь хамгийн гайхамшигт нандин зүйл нь билээ.
 12. Ай Бурхан Кришна минь ээ! Энэ арван дүрд хувиран буун заларсан Таны өмнө сөгдөн мөргөө. Матсыйн дүрээр Та Ведийг аварч, Курмын дүрээр аугаа уул Мандараг нуруун дээрээ тогтоон барьж байсан билээ. Варахын дүрээр Та Өөрийн соёогоор Дэлхийг өргөн гаргаж, Нрисимхийн дүрээр дайтыя Хираньякашипугийн цээжийг хага татаж, Ваманын дүрээр Та дайтийн хаан Балийг хууран мэхэлсэн билээ. Түүнээс гурван алхмын хэмжээтэй газар гуйгаад Та аварга том гурван алхмыг хийж бүхий орчлонг булаан авсан билээ. Парашурамын дүрээр та нүгэлдээ живсэн бүхий л кшатриудыг егүүтгэж харин Рамачандрын дүрээр *ракшасуудын*(мангасуудын) хаан Раванаг даран сөнөөсөн. Баларамын дүрээр анжис мөрөндөө тээн түүгээрээ Өөрийн эрх мэдлийг ариун бусчуудад үзүүлж, Ямуна мөрөнг Өөртөө татан авч ирсэн билээ. Бурхан Буддын дүрээр энэ ертөнцөд оршин буй бүхий л амьд амьтсыг өршөөн нигүүлсэж, харин Калкийн дүрээр млеччх буюу унан доройтсон хүмүүсийг самууруулахын тулд Кали-югагийн төгсгөлд залрах бүлгээ.

Бхажажу ре мана Шри Нанда-нандана

Говинда дас Кавиража

1

бхажажу ре мана ири-нанда-нандана-

абхайа-чараңравинда ре

дурлабха манава-жанама сат-сайге

тарохо э бхава-синдху ре

2

*ийта атапа бāта бариша᠓а
э дина жāминй жāги ре
бипхале севину крпа᠓а дуражана
чапада сукха-лаба лāги 'ре*

3

*э дхана, йаубана, путра, парижана
итхе ки āчхе паратйти ре
камала-дала-жала, жйвана тlаламала
бхажахū хари-пада нйти ре*

4

*йравана, кйртана, смара᠓а, вандана,
пāда-севана, дāсйа ре
пūжана, сакхй-жана, āтма-ниведана
говинда-дāса-абхилāша ре*

1. Ай ухаан минь ээ, хүмүүнийг аймшиггүй болгодог Нандын хүүгийн бадамлянхуан өлмийд мөргөн залбирагтун. Энэхүү ховор нандин бэлэг болох хүний бие махбодийг хүлээн авсан дээрээ ариун гэгээн бодгалиудтай харьцагтун. Учир нь та тэгж л материаллаг ахуйн далайг гатлан туулж чадна.

2. Өдөр ч, шөнө ч би халуун хийгээд хүйтэн, салхи болон борооноос болж зовж шаналан амгалан тайван байдлыг үл мэдэрнэм. Түр зуурхны аз жаргалын өчүүхэн дусалханы төлөө би дүүрсэн тэнэг хүмүүст үйлчлэн зүтгэнэм. Гэвч миний бүхий л оролдлого зүтгэл хуурмаг байжээ.

3. Миний бүхий л эд баялаг, залуу нас, нуган үрс, төрөл төрөгсөд надад жинхэнэ аз жаргалыг авч ирж чадах уу? Энэ амьдрал бол бадамлянхуан дэлбээн дээр бөнжигнөн байгаа шүүдрийн дусал мэт билээ. Иймээс чи Бурхан Харигийн бадамлянхуан өлмийд үргэлжид мөргөн залбирч мөн үйлчлэн зүтгэх ёстой.

4. Говинда дас *бхактигийн* есөн төрлийн үйлэнд өөрийгөө зориулан даатгахыг тэсч ядан хүснэм. Үүнд Бурхан Харигийн яруу алдрын тухай хүүрнэлийг сонсох, Түүнийг алдаршуулах, Түүнийг тухай дурсан санах, Түүнд залбирал өргөх, Түүний бадамлянхуан өлмийд үйлчлэх, Түүнд/Бурханд/ чин сүсэгт албат байдлаар үйлчэн зүтгэх, Түүнд цэцэг, хүж гэх мэт тэргүүтнийг өргөн мөргөх, Түүнд найзлан нөхөрлөж үйлчлэх хийгээд Түүнд өөрийгөө бүрнээ даатгах эдгээр үйлүүд хамаармуй.

Шри Шри Гаура-Нитьянандер дая
Шри Гаура, Нитьянанда нарын адислал

Лочана дас Тхакур

(“Дхамали”-гаас)

1

*парама коруна, пахӯ дуи жана,
нитāи гаурачандра
саба аватāра-сāра ишромани,
кевала āнанда-канда*

2

*бхажо бхажо бхāи, чайтанйа нитāи,
судрдха бийвāса кори’
вишайа чхāрийā, се расе мажсийā,
мукхе боло хари хари*

3

*декхо оре бхāи, три-бхуване нāи,
эмона дойāла дātā
пайу пāкхй жхуре, пāшāна видаре,
йуни’жāра гуна-гātхā*

4

*самсāре мажсийā, рохили порийā,
се паде нахило āйā
āпана карама, бхуñжāйе шамана,
кахойе лочана-дāса*

Бурханы Адислалт А.Ч.Бхактиведанта Свами Прабхупадын
тайлбар

Энэ дууг Лочана дас Тхакур бичжээ. Пахӯ гэдэг нь “Бурхан”, дуи жана гэдэг нь “хоёр” гэсэн утгатай. Лочана дас Тхакур, хоёр Бурхан болох Нитай-Гаурачандра (Бурхан Нитай, Бурхан Чайтанья) нар нь нэн өршөөнгүй(парама коруна) хэмээн баталжээ. Саба аватāра-сāра ишромани. Аватāра гэдэг нь “хувилгаан”, саба гэдэг нь “бүгд” гэсэн утгатай. Тэд бүхий л хувилгаадын бэлэгдэл болдог. Энэхүү хоёр хувилгааны онцлог нь гэвэл Тэдний өргөн барьж буй өөрийгөө танин ухамсарлахуйн арга нь зөвхөн баяр баясгаланг л авчирдагт оршино(кевала āнанда-канда). Учир нь Тэд зүгээр л дуулах болон бүжиглэхийг л уриалан дуудсан юм.

Бурхан Рама болон утга агуулгынх нь мөн чанарт гүн гүнзгийгээр нэвтрэх ухаан болон мэдлэг боловсрол шаарддаг “Бхагавад-гита” судрыг айлдсан Кришна гэх мэт өөр бусад олон хувилгаадууд байдаг. Гэвч Бурхан Чайтанья, Нитьянанда нар нэгэн аргыг өргөн барьжээ. Энэ арга практик нь зөвхөн баяр баясгаланг л авч ирдэг бөгөөд зүгээр л дулж, бүжиглэх хэрэгтэй байдаг. Иймээс Лочана дас бүгдэд хандан: *бхажо бхажо бхāи, чайтанйа нитāи* – “Эрхэм ах минь ээ, танаас гуйя, Бурхан Чайтанья, Нитьянанда нарт гүн бат итгэлтэйгээр мөргөгтүн” хэмээн өгүүлжээ. Хэрэв зүгээр л дуулж бүжиглэснээр хүссэн зорилгодоо хүрч чадах болов уу хэмээн бүү бодогтун. Та гарцаагүй түүнд хүрэх болно. Бурхан Чайтанья Махапрабху, энэ аргын тусламжтайгаар бүрэн дүүрэн төгс төгөлдөрт хүрч чадна гэж баталж байна. Ийм учраас зүрхэндээ хатуу итгэлтэйгээр дуулах хэрэгтэй(*бишйвāса кори*’).

Энэ аргын мөн чанар юунд оршино вэ? *Вишайа чхāрийā, се расе мажсийā*. Энэ аргын тусламжтайгаар Кришнагийн ухамсрыг олж авахыг хүсч буй хүн нь мэдрэхүйн цэнгэлд автах ёсгүй. Энэ бол цорын ганц хязгаарлалт юм. Хэрэв хүн өөрийн мэдрэхүйнүүдээ хангахаа таслан зогсоочихвол тэрээр гарцаагүй зорилгодоо хүрнэ. *Мукхе боло хари хари* – мэдрэхүйгээ хангах ородлогоо орхиж, зүгээр л: “Харе Кришна!Хари!Хари!” хэмээн дуулах хэрэгтэй.

Декхо оре бхāи, три-бхуване нāи. Лочана дас Тхакур: “Эрхэм ах минь ээ, зүгээр л энэ аргыг оролдоод үз, өөр дээрээ туршаад үз. Бүх гурван ертөнц даяар Бурхан Чайтанья, Бурхан Нитьянанда нартай эн тэнцэх нь үгүй билээ. Учир нь Тэд нэн өршөөнгүй ба зөвхөн хүмүүс төдийгүй бүр шувууд, араатан амьтад тэднийг харснаар уйлдаг” хэмээн өгүүлжээ. Бурхан Чайтаньяг Жхарикхандын ойгоор явж өнгөрөх үед ойн бүх амьтад:бар, заан, буга бүгд л Түүнтэй хамт Харе Кришна *мантраг* дуулж байжээ. Энэ дуу нь маш гайхамшигтай агаад түүнд хүмүүс төдийгүй араатан амьтад ч бүгд оролцож болдог. Мэдээжийн хэрэг, жирийн нэг хүн адгуус амьтдыг дуулуулж чадахгүй ч бид ядахнаа Чайтанья Махапрабху зэрлэг амьтдыг урамшуулан хөгжөөж байсан шиг Харе Кришна *мантрын* дууллаар хүмүүсийг урамшуулан хөгжөөхийг оролдож болох юм. Энэ дуулал нь хамгийн чулуун зүрхтнийг ч хайлуулан уяруулах чадалтай тийм гайхамшигтай билээ. *Пāшāна* гэдэг нь “чулуу” гэсэн утгатай. Тэрээр чулууг ч хайлуулах чадалтай тийм л гайхамшигтай.

Гэвч Лочана дас Тхакур, тэрээр мэдрэхүйгээ хангах үйлийн урхи занганд баригдан орооцолджээ хэмээн зүрх шимшрэн өгүүлсэн байна. Тэрээр өөртөө хандан: “Эрхэм ухаан минь ээ, чи мэдрэхүйгээ хангах үйлийн урхи занганд баригджээ. Чамайг Харе Кришна *мантра* дуулал үл татах юм. Хэрэв Бурхан Чайтанья, Бурхан Нитьянандын бадамлянхуан өлмий чамайг татахгүй бол өөр юу ч хэлэх билээ дээ? Надад үлдэж буй цорын ганц зүйл бол зүгээр л өөрийнхөө урагшгүй байдалд харамсан гашуудах билээ. Үхлийн тэнгэр Ямаража намайг энэ хөдөлгөөнд нэгдүүлэлгүй залхаан цээрлүүлж байна” гэсэн байна.

Даинья о прапатти

Бурханд дагаар орохуй буюу өөрийгөө даатгахуй

1

*хари хе дойāла мора жайа рāдхā-нāтх
бāро бāро эи-бāро лохо нижа сātх*

2

*баху жони бхрами' нāтхa!лоину йараң
нижа-гуңе крпā коро'адхама-тāраң*

3

*жагата-кāраңа туми жагата-жйван
томā чхāрā кāра нахи хе рāдхā-рамаң*

4

*бхувана-маңгала туми бхуванера пати
туми упекхиле нāтхa, ки хоубе гати*

5

*бхāвийā декхину эи жагата-мāжхāре
томā бинā кехо нāхи э дāсе уддхāре*

1. Ай Хари! Ай өгөөмөр Бурхан минь ээ! Ай Радхын Эзэн минь ээ, Таны алдар бадартугай ! Олон олон удаа би Танаас зугатан зайлсхийж явлаа. Гэвч одоо харин би Танд өөрийгөө даатган зориулж байна. Та намайг хүссэнээрээ л захирагтун.

2. Ай Бурхан минь! Олон олон сая эхийн хэвлийг дамжин дамжсаар би одоо л нэг Таны өмөг түшгийг олж байна. Өршөөл энэрлээ хандуулаач. Өөрийн бурханлаг хүчийг гарган энэ өөдгүй азгүй сүнсийг авраач.

3. Ай Радхын амраг хайрт минь ээ, Та бол орчлонгийн шалтгаан хийгээд түүний амь амьдрал нь билээ. Миний эзэмшин байдаг бүх зүйл зөвхөн Таны өршөөл нигүүлсэлээр л оршин байдаг.

4. Та бол ертөнцийн эзэн ба ертөнц дахинаа зөвхөн сайн сайхныг л авч ирдэг билээ. Ай Бурхан минь ээ, хэрэв Та л намайг түлхэн зайлуулвал би хаанаас өөрийн өмөг түшгийг олохсон билээ?

5. Энэ ертөнц даяар унан доройтсон таны албатыг аврах Танаас өөр хэн ч үгүй гэдэгт би хатуу итгэнэм бүлгээ.

Шри Вража-дхама-махимаамрита

Вража-дхамын рашаан мэт алдар

1

*жайа рāдхе, жайа кршңа, жайа врдāван
ййрй-говинда, гопйнāтхa, мадана-мохан*

2

*иййāма-кунда, рāдхā-кунда, гири-говардхан
кāлиндй жамунā жайа, жайа махāван*

3

*кеийй-гхāта, бамийй-батa, двāдайа-кāнан
жāхā саба лйлā коило ирй-нанда-нандан*

4

*ирй-нанда-жайодā жайа, жайа гона-гаң
ирйдāмāди жайа, жайа дхену-ватса-гаң*

5

*жайа бршабхāну, жайа кйртидā сундарй
жайа паурңамāсй, жайа āбхйра-нāгарй*

6

*жайа жайа гопййвара врндāвана-мāжх
жайа жайа кршнā-сакхā бату движа-рāж*

7

*жайа рāма-гхāта, жайа рохиңй-нандан
жайа жайа врндāвана-бāсй жата жан*

8

*жайа движа-патнй, жайа нāга-канйā-гаң
бхактите жāхāрā пāило говинда-чараң*

9

*ирй-рāса-маңдала жайа, жайа рāдхā-иййāм
жайа жайа рāса-лилā сарва-манорам*

10

*жайа жайожжвала-раса сарва раса-сār
паракиййā-бхāве жāхā бражет прачār*

11

ирй-жāхнавā-пāда-падма корийй смараң

дйна кришна-дāса кохе нāма-санкйртан

1. Радха, Кришна, Вриндаваны бурханлаг ой шугуйн яруу алдар бадартугай! Вриндаваны гурван үндсэн Шүтээн Бурхан Шри Говинда, Гопинатха, Маданамоханы алдар бадартугай!

2. Шьяма-кунда, Радха-кунда, Говардхан уул, Ямуна мөрний(Калинди) яруу алдар бадартугай! Кришна, Баларама нар хүүхэд ахуйн тоглоом наадмаа өрнүүлсэн Махаваны аугаа ойн алдар бадартугай!

3. Кришна, Кеши чөтгөрийг дарсан Кеши-гхатын яруу алдар бадартугай! Доор нь Кришна лимбэн дээрээ тоглон лимбэний эгшгээр *гопи* нарыг даллан дуудсан Вамши-ват модны алдар бадартугай! Вражийн бүхий л арван хоёр ойн яруу алдар бадартугай! Тэдгээр ойнуудад Нандын хүү Шри Кришнагийн бүхий л тоглоом наадам өрнөсөн билээ.

4. Кришнагийн бурханлаг эцэг, эх болох Нанда, Яшода нарын яруу алдар бадартугай! Шримати Радхарани, Ананга Манжари нарын ах Шридам тэргүүтэй малчин жаалуудын алдар бадартугай! Вражийн үнээд, тугалуудын алдар бадартугай!

5. Радхын бурханлаг эцэг, эх болох Вришабхана, үзэсгэлэнт Киртида нарын алдар бадартугай! Сандипани Мунигийн эх, Мадхумангал, Нандимукха нарын эмээ, Деварши Нарадын хайртай шавь Паурнамасийн алдар бадартугай! Вражийн малчин бүсгүйчүүдийн алдар бадартугай!

6. Ариун *дхамаг* хамгаалагч, Вриндавад оршин амьдрагч Гопишвара Шивагийн алдар бадартугай, яруу алдар бадартугай! Кришнагийн хөгжилтэй найз брахман Мадхумангалын яруу алдар бадартугай, алдар бадартугай!

7. Баларама Бурхан Өөрийн *раса* бүжгээ үйлдсэн Рама-гхатын алдар бадартугай! Рохиний хүү Бурхан Баларамын алдар бадартугай! Вриндаваны бүхий л оршин суугчдын яруу алдар бадартугай, алдар бадартугай!

8. Ихэмсэг зант *ведийн брахмануудын* эхнэрүүдийн яруу алдар бадартугай! Кали могойн эхнэрүүдийн алдар бадартугай! Өөрсдийн цэвэр чин бишрэл сүсгийн ачаар тэд бүгд Бурхан Говиндын бадамлянхуан өлмийг олсон бөлгөө.

9. Шри Кришнын *раса* бүжиг өрнөсөн газар нутгийн яруу алдар бадартугай! Радха, Шьямын алдар бадартугай! Бурхан Кришнагийн бүхий л тоглоом наадмын охь нь болсон бурханлаг *раса* бүжгийн яруу алдар бадартугай, алдар бадартугай!

10. Шри Кришна Вража нутагт бурханлаг *паракия-бхава*(паракия-бхава-гэр бүлийн холбоогүй ч охид, залуусын хоорондох хайр сэтгэл) хэлбэрээр тогтоосон, бусад бүхий л *расаг* давамгайлдаг амраг хайртуудын хоорондын амтлаг харьцааны яруу алдар бадартугай, алдар бадартугай!

11. Бурхан Нитьяландын гэргий Шри Жакнава Девийн бадамлянхуан өлмийг дурсан санаж, Кришнын өөдгүй муу албат, унан доройтсон би вээр ариун гэгээн нэрийн *санкиртаныг* магтан дуулж байна.

Жая Радха-Кришна гити

(жсайадевер прѣна-дхана хе)

жсайа рѣдхѣ-мадана-гопѣл рѣдхѣ-мадана-гопѣл рѣдхе
(сѣтѣ-нѣтхер прѣна-дхана хе)

3

жсайа рѣдхѣ-говинда рѣдхѣ-говинда рѣдхе
(рѣна госвѣмѣр прѣна-дхана хе)

4

жсайа рѣдхѣ-мадана-мохан рѣдхѣ-мадана-мохан рѣдхе
(санѣтанер прѣна-дхана хе)

5

жсайа рѣдхѣ-гопѣнѣтха рѣдхѣ-гопѣнѣтха рѣдхе
(мадху паңдитер прѣна-дхана хе)

6

жсайа рѣдхѣ-дѣмодара рѣдхѣ-дѣмодара рѣдхе
(жѣв госвѣмѣр прѣна-дхана хе)

7

жсайа рѣдхѣ-рамаңа рѣдхѣ-рамаңа рѣдхе
(гопѣл бхаттер прѣна-дхана хе)

8

жсайа рѣдхѣ-винода рѣдхѣ-винода рѣдхе
(локанѣтхер прѣна-дхана хе)

9

жсайа рѣдхѣ-гокулѣнанда рѣдхѣ-гокулѣнанда рѣдхе
(виѣванѣтхер прѣна-дхана хе)

10

жсайа рѣдхѣ-гиридхѣрѣ рѣдхѣ-гиридхѣрѣ рѣдхе
(дѣс госвѣмѣр прѣна-дхана хе)

11

жсайа рāдхā-ийāмасундар рāдхā-ийāмасундар рāдхе
(ийāманандер прāңа-дхана хе)

12

жсайа рāдхā-банка-бихārī рāдхā-банка-бихārī рāдхе
(харидāсер прāңа-дхана хе)

13

жсайа рāдхā-кāнта рāдхā-кāнта рāдхе
(вакрейварер прāңа-дхана хе)

14

жсайа гāндхарвикā-гиридхārī гāндхарвикā-гиридхārī рāдхе
(сарасватīр прāңа-дхана хе)

1. Жаядева Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ болсон Радха болон Мадхавын яруу алдар бадартугай!
2. Шри Адвайта Ачарьийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ болсон Радха болон Мадана-гопалын яруу алдар бадартугай!
3. Рупа Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Говиндын яруу алдар бадартугай!
4. Санатана Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ болсон Радха ба Мадана-моханы яруу алдар бадартугай!
5. Мадху Пандитын зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Гопинатхын яруу алдар бадартугай!
6. Жива Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Дамодарын яруу алдар бадартугай!
7. Гопал Бхатт Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха-раманы яруу алдар бадартугай!
8. Локанатха Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха-винодын яруу алдар бадартугай!
9. Вишванатха Чакраварти Тхакурын зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Гокуланандын яруу алдар бадартугай!
10. Рагхунатха дас Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Гиридхарийн яруу алдар бадартугай!
11. Шьямананда Госвамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Шьямасундарын яруу алдар бадартугай!
12. Харидас Свамийн зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха ба Банка-вихарийн яруу алдар бадартугай!
13. Вакрешвар Пандитын зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Радха-кантин яруу алдар бадартугай!
14. Шри Бхактисиддхантас Сарасвати Тхакурын зүрх сэтгэлийн нандин эрдэнэ Гандхарвика ба Гиридхарийн яруу алдар бадартугай!

Шри Туласи-арати

Чандрашекхара Кави

1

*намо намах туласи махārāṇи,
врнде махārāṇи намо намах
намо ре намо ре меййā намо нārāйаṇи*

2

*жāко дарайе, парайе агха-нāййа-и
махимā беда-пурāṇе бāкхāни*

3

*жāко патра, маñжарй комала
йрй-пати-чараṇа-камале лапатāни
дханйа туласи меййā, нūраṇа тапа кийе,
йрй-йāлагрāма-махā-пāтарāṇй*

4

*дхūпа, дйпа, наиведйа, āрати,
пхуланā кийе варакхā варакхāни
чхāппāнна бхога, чхатриййа бйāñжана,
бинā туласй прабху эка нāхи мāни*

5

*ййива-йука-нāрада, āур брахмāдико,
дхūрата пхирата махā-муни жйāнй
чандрайекхара меййā, терā жаййа гāове
бхакати-дāна дйжйе махārāṇи*

1. Ай Туласи Махарани! Ай Вринда! Ай чин бишрэлийн эх минь ээ! Ай Нараяни, би таны өмнө дахин дахин мөргөн залбирмуу.

2. Танд хүрэлцэх эсвэл ядаж таныг харсан тэр хүн бүхий л нүгэл хилэнцээсээ ангижирдаг. Таны яруу алдрын талаар Вед хийгээд Пуранууд магтан өгүүлдэг билээ.

3. Таны навч, эмзэгхэн *майжарī* тань Лакшмийн Эзэн Нараяны бадамлянхуан өлмийг ороон байдаг. Ай адис ерөөлт Туласи эх минь ээ, та өөрийн тэвчил наминчлалын хүчээр Шри Шалаграма-шилийн хатан, хамгийн гол эхнэр нь болсон билээ.

4. Танд хүж, шар тос бүхий зул өргөн *наиведья* болон *аратиг* үйлдэн буй хүмүүнд та өөрийн адис өршөөлийг асган цутгаж баяр баяслыг авч ирэх бөлгөө. Хэрэв Түүнд туласийн навчгүй тавин зургаан төрлийн чанасан хоол, гучин зургаан янзын *карриг* өргөвөл Бурхан тэдгээрт огтхон ч хүрэлцдэггүй билээ.

5. Шива Тэнгэр, Шукадева Госвами, Деварши Нарада, мөн бүх *гьяна-йогчид*, Брахма Тэнгэр тэргүүтэй аугаа *муни* нар таныг гороолон тойрдог. Ай эх минь ээ! Ай Махарани! Чандрашекхара таны алдрыг магтан дуулж байна. Түүнд цэвэр чин бишрэлийн бэлэг юугаа хайрлан болгоо.

Шри Туласи-киртан

1

*намо намах туласī! кришṇа-прейасī
рāдхā-кришṇа-севā пāбо эи абхилāшī*

2

*же томāра йāраṇа лой, тара вāñчхā пūrṇа хой
крпā кори' коро тāре брндāвана-бāсī*

3

*мор эи абхилāш, билāс кун̄же дио вās
найане херибо садā жугала-рūпа-рāйīш*

4

*эи ниведана дхаро, сакхīр аругата коро
севā-адхикāра дийе коро ниджа дāсī*

5

*дйна кришṇа-дāсе кой, эи жена мора хой
йīрī-рāдхā-говинда-преме садā жена бхāси*

1. Ай Кришнагийн энхрий хайрт Туласи минь ээ, Шри Шри Радха-Кришнад үйлчлэн зүтгэхийг эрхэмлэн хүсэж би таны өмнө дахин дахин мөргөн залбирмуу.
2. Чамайг өөрийнхөө өмөг түшгээ болгон сонгосон бүгдийн бүхий хүслийг чи гүйцэлдүүлдэг билээ. Түүнд өөрийн өршөөл хишгээ харамгүй хайрлахын хамт чи түүнийг Вриндаваны мөнхийн оршин суугч болгодог билээ.
3. Намайг Вриндаван-дхамын цэнгэл жаргалын гүн ногоон шугуйд оршин сууршихыг минь болгоон соёрхоно уу. Тэгсэн цагт би Радха-Кришнагийн гайхам тоглоом наадмыг байнгад толидон харж чадах билээ.
4. Танд мөргөн залбирья: намайг Вражийн хэн нэг малчны дагалдагч болгож өгнө үү. Мөн надад Бурханд үйлчлэн зүтгэх боломжийг хайрла, намайг өөрт тань үйлчлэн байх үйлчлэгч бүсгүй болгож өгөхийг хүсэн мөргөө.
5. Кришнагийн арчаагүй дорд зарц албат, унан доройтсон надад Шри Радха Говинда нарын хайр сэтгэлийн далайд мөнхөд умбан сэлэх гайхам боломжийг хайрлан болгоохыг гуйн залбирья, би.

Шри Туласи пранама

*вриндāйаи туласй-девайаи
прийāйаи кейавасйа ча
криш᳚а-бхакти-праде देवि
сатйаватйаи намо нама᳚х*

вриндāйаи-Вринда; *туласй-девайаи*-Туласи Деви; *прийāйаи*-түүнд эрхэм; *кейавасйа*-Бурхан Кришнад; *ча*-ба; *криш᳚а-бхакти*-Бурхан Кришнад чин бишрэлээр үйлчлэн зүтгэх; *праде*-түүнд хайрладаг; *деви*-ай дарь эх минь ээ; *сатйаватйаи*-Сатъявати; *нама᳚х нама᳚х*-олонтоо мөргөмүү.

Би, Бурхан Кришна танаа машид эрхэм Шримати Туласи Деви, Вриндын өмнө дахин дахин мөргөн залбирмуй. Ай охин тэнгэр минь ээ, та дээдийн үнэнийг төгс мэдэх хийгээд Бурхан Кришнад үйлчлэн зүтгэх чин бишрэл сүсгийг бүгдэд тараан түгээх бөлгөө.

Шри Туласи прадакшина мантра

*йāни кāни ча пāпāни
брахма-хатйāдикāни ча
тāни тāни пранаййанти
прадакши᳚а᳚х паде паде*

йāни кāни-ямар ч байсан; *ча*-мөн; *пāпāни*-нүгэл хилэнцүүд; *брахма-хатйа*-брахманыг хөнөөх; *āдикāни*-гэх мэтчилэн; *ча*-түүнчлэн; *тāни тāни*-тэд бүгд; *пранаййанти*-устгадаг; *прадакши᳚а᳚х*-(ачаар)тойрон явах (Туласи Девиг); *паде паде*-алхам тутамдаа.

Шримати Туласи Девийг тойрон алхан ахуйд хүн алхам тутамдаа брахманыг хөнөөсөн гэх мэт үйлдэж болох бүх л нүгэл хилэнцээсээ ангижирмуй.

Шри Нрисимха пранама

*намас те нарасимхāйа
прахлāдāхлāда-дāйине
хира᳚йакайипор вакша᳚х-
йилā-тāнка-накхāлайе*

намах-мөргөмүү; те-Танд; нара-симхāйа-Бурхан Нарасимхад; прахлāда-Прахлада Махаражид; āхлāда-баяр баясгалан; дāйине-авч ирэх; хиранйакайипох-Хираньякашипу; вакшах-цээж; ишилā-чулуу мэт хатуу; танка-сийлүүр хутга мэт; накха-āлайе-түүний хумс нь.

Прахлада Махаражад баяр хөөрийг авчрах Бурхан Нрисимха танаа бишрэл хүндэтгэл бүхнээ илэрхийлэн мөргөнөм. Түүний хурц хумс нь сийлүүр хутга мэтээр чөтгөр Хираньякашипугийн чулуу мэт цээжийг хага татаж хаясан билээ.

*ито нрисимхах парато нрисимхо
йато йато йāми тато нрисимхах
бахир нрисимхо хрдаие нрисимхо
нрисимхам āдим иаранам прападиe*

итах-энд; нрисимхах-Бурхан Нрисимха; паратах-тэнд; нрисимхах-Бурхан Нрисимха; йатах йатах-хаашаа ч; йāми- би явсан ч; татах-тэнд; нрисимхах-Бурхан Нрисимха; бахих-гаднаас нь; нрисимхах-Бурхан Нрисимха; хрдаие-зүрхэнд; нрисимхах-Бурхан Нрисимха; нрисимхам-Бурхан Нрисимхад; āдим-эх булагт; иаранам-дээд өмөг түшигт; прападиe-би даатганам.

Бурхан Нрисимха энд ч мөн тэнд ч оршин байх бөлгөө. Хаашаа л явна хаа сайгүй Бурхан Нрисимха оршмуй. Тэрээр зүрхэнд орших хийгээд мөн гадна талд ч оршмуй. Би вээр бүхий л юмсын эх үндэс, бүх зүйлсийн дээд өмөг түшиг Бурхан Нрисимха танаа өөрийгөө бүрнээ даатгаюу.

Бурхан Нрисимхад өргөх залбирал

(“Шри Дашаватара-стотра”-гаас)

*тава кара-камала-варе накхам адбхута-ийрнгам
далита-хиранйакайипу-тану-бхрнгам
кейава дхрита-нарахари-рūпа жайа жагадийиa харе*

Ай Кешава! Ай Орчлонгийн Эзэн минь ээ! Ай хүн-арслангийн дүрд хувилсан Бурхан Хари минь ээ! Таны алдар бадартугай! Хүн өөрийн хуруугаар зөгийг хоёр хэсэг болгон хаядаг шиг Та бээр тийм хялбараар Өөрийн гайхамшигт хурц хумсаараа зөгийтэй эгээ адилхнаар, чөтгөр Хирянькашипугийн биеийг тасар татан хаясан билээ.

ХАВСРАЛТ

Санскрит үгийг унших аргачлал

Түүхийн янз бүрийн үеүдэд санскрит үгийг тэмдэглэх янз бүрийн үсгүүд хэрэглэж ирсэн бөгөөд гагцхүү хамгийн тохиромжтой цагаан толгой нь *деванагари* болон үлджээ. *Деванāгарī* гэсэн үг нь, “сахиулсан тэнгэр нарын хотод хэрэглэх бичиг” гэсэн утгатай бүлгээ. *Деванāгарī* дөчин найман үсгээс бүтдэг нь: арван гурван эгшиг, гучин таван гийгүүлэгч болой. Эртний үсгийн дүрэм зохиогчид эл цагаан толгойг хэлний зайлцаагүй шаардлагаар зохиосон бөгөөд энэхүү бүтцийг барууны бүх эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн бүлгээ.

Энэ номонд ашигласан галигийн тогтолцоо нь, Юдит Тибергийн латин галигийн хуулбар болой. Чингэхдээ латин үсгүүдийг нь түүнд таарах кирилл үсгээр солиод ялгах тэмдгийг нь хадгалан үлдээжээ. Үүний зэрэгцээ монгол хэл дээр зарим санскрит үг ихээхэн өвөрмөц дуудагдахыг хэлэх нь зүйтэй. Жишээ нь, “йа” ба “йу” гэсэн авиа нь монгол хэл дээр “я” болон “ю” авиаг тэмдэглэдгээр дуудагдана. (Жишээ нь, Чаитанья гэж бичээд Чайтанья гэж унших гэх мэт). Ашиглаж буй систем нь үгийн галигийнх болохоос биш санскрит авианы галиг биш гэдгийг ойлгох нь чухал бөгөөд хөнгөн дуудлагыг *деванāгарī* дуудлагаар дууриалгасан боломжийн онож очсон хэлбэрт оруулав.

Галиглагдсан санскрит үгүүдийг тайлбар дотор бичмэл үсгээр тэмдэглэв. Харин бичмэлээр хүний нэр, газрын нэр, номууд болон философийн тогтолцооны нэрийг ялгасангүй. Эртнээс монгол хэл дээр олон тооны энэтхэг ном судар орчуулагдсанаас монгол хэлэнд бага зэрэг гажуудан хэлэгдэх болсон үгс, тухайлбал *сўтра*(монголоор судар), *шāстра*(монголоор шастир) гэх мэтийг санскрит хэллэгээр нь үлдээв. Гол гол үгүүдийн цаад утгыг үгийн хэлхээнд тайлбарлан өгүүлсэн болно.

ҮСГИЙН ДҮРС

Эгшигүүд дараахь байдлаар дуудагдана.

(үгийн эхэнд)

а- “нар” гэсэн үгэнд байгаа шиг

ā - хоёр дахин урт дууд

и- “жил” гэсэн үгэнд байгаа шиг

ī- хёр дахин урт дууд

у- “хул” гэсэн үгэнд байгаа шиг

ū-хоёр дахин урт дууд

р- “зарим” гэсэн үгэнд байгаа шиг

ṛ - хоёр дахин урт дууд

е(э)-“энэ” гэсэн үгэнд байгаа шиг

аи-“айл” гэсэн үгэнд байгаа шиг

о-“мод” гэсэн үгэнд байгаа шиг

ау-“аугаа” гэсэн үгэнд байгаа шиг

Энэтхэгийн санскрит хэлний ихэнхи сургуулиуд р, ṛ, ḷ үсгүүдийг харгалзан ри, рий, лри гэх мэтээр уншдаг.

Гийгүүлэгчүүдийг дараахь байдлаар уншдаг:

Хэлний угийн

(хоолойгоор дуудна)

к- “кино” гэсэн үгэнд байгаа шиг

г- “гич” гэсэн үгэнд байгаа шиг

ḅ- “хонгил” гэсэн үгэнд байгаа шиг

Уруулын

п- “пял” гэсэн үгэнд байгаа шиг

б- “бар” гэсэн үгэнд байгаа шиг

м- “эм” гэсэн үгэнд байгаа шиг

Шүдний

(церебрэлийнхтай адил боловч , хэлнийхээ үзүүрийг шүднийхээ угт шахаж дуудна)

т- “тив” гэсэн үгэнд байгаа шиг

д- “дор” гэсэн үгэнд байгаа шиг

н- “ном” гэсэн үгэнд байгаа шиг

Тагнайн

(хэлнийхээ дунд хэсгийг тагнайдаа хүргэж дуудна)

ч- “чин” гэсэн үгэнд байгаа шиг

ж-“Жон” гэсэн үгэнд байгаа шиг

ḥ- “хонь” гэсэн үгэнд байгаа шиг

Церебрэлийн(ṭ, ṭх, ḍ, ḍх, ṇ) нь хэлнийхээ үзүүрийн доод хэсгийг тагнайн урд

үзүүрт эргүүлэн нугалаад шахан дуудна.

Хийн түрлэгтэй(кх, гх, чх, жх, тх, дх, тх, пх, бх, тх, дх) нь хийн түрлэггүйгээсээ ялгарах нь гэвэл гол элементээс хамаарч английн сулавтар авиа h дагалдах ба үгийн утгаас болж тод юмуу бүдэг дуудагдана.

Хагас эгшигүүд

й- “биеэ” гэсэн үгэнд байгаа шиг
р- церебрэлийн р шиг
л- шүдний английн л шиг
в- монголын в шиг, гийгүүлэгчийн ард бол
английн w шиг

Шуугиант

й- “биш” гэдэг шиг зөөлрүүлж дууд
ш- монгол хэлний шар гэдэг шигш
с- монголын сар гэдэг шиг

Висарга

х- бүдэгхэн авиа бөгөөд
төгсгөлд нь эхэнд буй эгшигийг
дахин дуудна: ах нь аха, их нь
ихи гэж дуудагдах жишээтэй.

Анусвāра

м- францын “bon” гэсэн үг шиг эгшигийн
ард дуудагдах хамрын авиа

Хоолойн

х – английн h шиг тод авиа

Санскрит үгэнд чангаруулах өргөлтийн эгшиг тавьдаггүй. Хамгийн хүчтэй эгшиглэнтэй шадуудад байгаа үе болгон нь шүлгийн найруулгын эгшиг болон тооцогдоно. Үгүүдэд үеүд нь уртаараа ялгарна. Урт эгшигтэй нь (ā, ai, au, e, ī, ṛ, ū) эсвэл богино эгшигтэй, ганцаас илүүгүй гийгүүлэгчтэй(х ба м -ийг оролцуулаад) бол урт үе гэнэ.

ГАРЧИГ

Өмнөх үг
Оршил

Үндсэн залбирлууд

Шри гуру пранама*
Шри Рупа пранама*
Мангалачарана*
Шрила Прабхупада пранати*
Шрила Бхактисиддханга Сарасвати пранати*
Шрила Гауракишора пранати*
Шрила Бхактивинода пранати*
Шрила Жаганнатха пранати*
Шри вайшнава пранама*
Шри Гауранга пранама*
Шри Панча-таттва пранама*
Шри Кришна пранама*
Самбандхадхидева пранама*
Прайожанадхидева пранама*
Шри Радха пранама*
Панча-таттва маха-мантра*
Харе Кришна маха-мантра*
Шри Шри Гурв-аштака*
Шри Шри Шад-госвами аштака*

Шри Шри Шикшаштака*

Шрила Бхактивинода Тхакурын дуунууд

Арунодая-киртан
Шри Нама
Гопинатха
Гурудев
Манаса деха геха
Прасада-севая
Радха-Кришна бол
Жая Радха-Мадхава
Сиддхи-лаласа
Кабе ха'бе боло
Шуддха-бхаката
Бхога-арати
Гаура-арати
Шри Нама-киртан
Туми Сарвешварешвара
Охе! Вайшнава Тхакура
Вибхавари Шеша
Видьяра виласе

Шрила Наротгама дас Тхакурын дуунууд

Вайшнаве вигьяпти
Ишта-деве вигьяпти
Нама-санкиртана
Сакхи-вринде вигьяпти
Сапаршада-бхагавад-вираха-жанита-вилапа
Саварана-шри-гаура-махима
Шри Гуру-вандана
Саварана-шри-гаура-пада-падме прартхана
Манах-шикша
Шри Рупа Манжари пада
Васанти раса

Бусад ачарья вайшнавүүдын дуунууд

Кришнагийн бадамлянхуан өлмийд өргөх залбирал
Маркине бхагавата-дхарма
Шри Гуру-парампара
Шри Дамодараштака*
Шри Радхика-става*
Шри Дашаватара-стотра*
Бхажаху ре мана Шри Нанда-нандана
Шри Шри Гаура-Нитьянандер дая

Даинья о прапатти
Шри Вража-дхама-махимарита
Жая Радха-Кришна гити
Шри Туласи-арати
Шри Туласи киртан
Шри Туласи пранам*
Шри Туласи прадакшина мантра*
Шри Нрисимха пранама*
Бурхан Нрисимхад өргөх залбирал*

Хавсралт

Санскрит үгийг унших аргачлал

*-гэмдэглэгээгээр санскрит мантрануудыг тэмдэглэв. Бусад бүгдээрээ нь бенгали текстүүд.